



## **ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД**

### **НЭГ. ХЯНАСАН**

Авирмэдийн Амарбал  
Эдийн засагч-Хүн ам зүйч, Хүн ам зүйн ухааны доктор  
ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга, Хүн ам,  
орон сууцны тооллогын Улсын комиссын нарийн бичгийн  
дарга

Төмөрбаатарын Болор-Эрдэнэ  
Эдийн засагч-Хүн ам зүйч  
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

### **ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН**

Цэнджавын Бадрах  
Эдийн засагч-Хүн ам зүйч

Түвшинтөрийн Жаргалсайхан  
Эдийн засагч-Хүн ам зүйч

### **ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ**

Ичинноровын Цэрэндулам  
Эдийн засагч-Статистикч

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: [informationa@nso.mn](mailto:informationa@nso.mn)  
Утас: 11-321433

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

## **АГУУЛГА**

<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>2</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>6</b>
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	<b>8</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ</b> .....	<b>9</b>
<i>СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, СУУЦНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ</i>	
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ</b> .....	<b>18</b>
<i>ӨРХИЙН ТОО, ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, АХУЙН НӨХЦӨЛ</i>	
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ</b> .....	<b>45</b>
<i>БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ</i>	
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</b> .....	<b>68</b>
<i>ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ</i>	
<b>ТАВДУГААР БҮЛЭГ</b> .....	<b>86</b>
<i>ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ</i>	
<b>ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b> .....	<b>97</b>
<b>ХАВСРАЛТ ХҮСНЭГТ</b> .....	<b>110</b>



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1. Өрхийн тоо, хот, хөдөө, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он.....	19
Хүснэгт 2.2. Өрхийн тоо, өрхийн хэлбэрээр, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он.....	19
Хүснэгт 2.3. Хүн амьдрах зориулалттай сууцны тоо, аймаг, нийслэлээр, 2019 он.....	23
Хүснэгт 2.4. Хүн байнга амьдардаг сууцны тоо, аймаг, нийслэлээр, 2019 он.....	24
Хүснэгт 2.5. Хүн байнга амьдардаг сууцанд нийтийн орон сууцны байшингийн доторх сууцны эзлэх хувь, 2019 он.....	25
Хүснэгт 2.6. Орон сууцны байшин, ашиглалтад орсон оноор, 2019 он.....	26
Хүснэгт 2.7. Орон сууцны байшин, ашиглалтад орсон оноор, хот, хөдөө, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	26
Хүснэгт 2.8. Орон сууцны байшингийн тоо, үндсэн материал, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	27
Хүснэгт.2.9. Орон сууцны байшингийн тоо, талбайн хэмжээ, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	28
Хүснэгт.2.10. Гэрийн тоо, зах зээлийн үнэлгээгээр, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	29
Хүснэгт 2.11. Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2010,2020 он.....	30
Хүснэгт 2.12. Өрхийн сууцны төрөл, байршил, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	31
Хүснэгт 2.13. Өрхийн тоо, сууцны төрөл, аймаг, нийслэлээр, бүгд дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	32
Хүснэгт 2.14. Өрхийн тоо, сууцны төрөл, өмчийн хэлбэр, бүгд дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	33
Хүснэгт 2.15. Өрхийн тоо, сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	33
Хүснэгт 2.16. Өрхийн тоо, сууцны төрөл, цахилгааны эх үүсвэр, хот, хөдөө, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он.....	34
Хүснэгт 2.17. Өрхийн тоо,цахилгааны эх үүсвэр, дүнд эзлэх хувиар, 2020 он.....	35
Хүснэгт 2.18. Орон сууцны нөхцөл сайтай өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2020 он.....	38
Хүснэгт 2.19. Орон сууцны нөхцөл хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот хөдөөгөөр, 2020 он.....	39
Хүснэгт 2.20. Орон сууцны нөхцөл хагас хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2020 он.....	40
Хүснэгт 2.21. Орон сууцны нөхцөл дутуу хангагдсан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот хөдөөгөөр, 2020 он.....	41
Хүснэгт 2.22. Орон сууцны нөхцөл муу хангагдсан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот хөдөөгөөр, 2020 он.....	42
Хүснэгт 2.23. Орон сууцны нөхцөл огт хангагдаагүй өрхийн тоо, аймаг, нийслэл, хот хөдөөгөөр, 2020 он.....	43



Хүснэгт 3.1. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, сууцны төрлөөр, 2020 он.....	46
Хүснэгт 3.2. Байшинд амьдардаг өрхийн тоо, хот, хөдөө, өмчийн хэлбэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	47
Хүснэгт 3.3. Байшинд амьдардаг өрхийн тоо, хот, хөдөө, эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	47
Хүснэгт 3.4. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	48
Хүснэгт 3.5. Байшинд амьдардаг өрхийн тоо, ам бүлийн тоо, сууцны талбайн хэмжээ, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	49
Хүснэгт 3.6. Байшинд амьдардаг өрхийн тоо, сууцны талбайн хэмжээ, аймаг, нийслэл, дүнд эзлэх, хувь, 2020 он.....	49
Хүснэгт 3.7. Байшинд амьдардаг өрхийн тоо, ам бүл, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он.....	50
Хүснэгт 3.8. Байшинд амьдардаг өрхийн цахилгаан хангамж, 2010, 2020 он.....	51
Хүснэгт 3.9. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгаанаар хангагдсан байдал, 2020 он.....	51
Хүснэгт 3.10. Байшинд амьдардаг өрхийн тоо, халаалтын төрөл, хувиар, 2010, 2020 он.....	52
Хүснэгт 3.11. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, халаалтын төрөл, хувиар, 2020 он.....	53
Хүснэгт 3.12. Байшинд амьдардаг өрхийн тоо, усан хангамжийн төрөл, хувиар, 2020 он.....	54
Хүснэгт 3.13. Байшинд амьдардаг өрхийн тоо, усан хангамжийн төрөл, аймаг, нийслэл, хувиар, 2020 он.....	55
Хүснэгт 3.14. Байшингийн гаднах ундны усны эх үүсвэртэй өрхийн тоо, усны эх үүсвэрийн төрөл, дүнд эзлэх хувь 2020 он.....	56
Хүснэгт 3.14а. Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, ундны усаа зөөдөг зай, дүнд эзлэх хувь, 2020 он.....	57
Хүснэгт 3.15. Байшинд амьдардаг өрхийн тоо, хот, хөдөө, бие засах газрын төрлөөр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	57
Хүснэгт 3.16. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, бие засах газрын төрлөөр, дүнд эзлэх хувь 2020 он .....	58
Хүснэгт 3.17. Байшинд амьдардаг өрхийн тоо, хот, хөдөө, хатуу хог хаягдал зайлуулалтын төрлөөр, дүнд эзлэх хувь 2020 он.....	59
Хүснэгт 3.18. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хатуу хог хаягдал зайлуулалтын төрлөөр, дүнд эзлэх хувь 2020 он.....	59
Хүснэгт 3.19. Байшинд амьдардаг өрхийн тоо, бохир ус зайлуулах хэлбэр, дүнд эзлэх хувь 2020 он.....	60
Хүснэгт 3.20. Байшинд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, бохир ус зайлуулах хэлбэр, дүнд эзлэх хувь 2020 он.....	61



Хүснэгт 3.21. Байшинд амьдардаг ахуйн нөхцөл сайтай өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	62
Хүснэгт 3.22. Байшинд амьдардаг ахуйн нөхцөл хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	63
Хүснэгт 3.23. Байшинд амьдардаг ахуйн нөхцөл хагас хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	64
Хүснэгт 3.24. Байшинд амьдардаг ахуйн нөхцөл дутуу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	65
Хүснэгт 3.25. Байшинд амьдардаг ахуйн нөхцөл муу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	66
Хүснэгт 3.26. Байшинд амьдардаг ахуйн нөхцөл муу хангасан өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	67
Хүснэгт 4.1. Гэрт амьдардаг өрхийн тоо, ам бүл, гэрийн ханын тоо, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	69
Хүснэгт 4.2. Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, гэрийн ханын тоогоор, бүгд дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он.....	70
Хүснэгт 4.3. Гэрт амьдардаг өрхийн тоо, цахилгааны, эх үүсвэр, хот, хөдөөгөөр, дүнд, эзлэх хувь, 2010, 2020 он.....	72
Хүснэгт 4.4. Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны эх үүсвэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	73
Хүснэгт 4.5. Гэрт амьдардаг хотын өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны эх үүсвэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	74
Хүснэгт 4.6. Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, цахилгааны эх үүсвэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	75
Хүснэгт 4.7. Гэрт амьдардаг өрхийн тоо, ахуй нөхцөлийн зарим үзүүлэлт, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	76
Хүснэгт 4.8. Гэрт амьдардаг өрхийн тоо, ахуй нөхцөлийн зарим үзүүлэлт, аймаг, нийслэл, дүнд эзлэх хувь, 2020 он.....	77
Хүснэгт 4.9. Гэрт амьдардаг өрхийн тоо, сууцны гаднах ундны усны эх үүвэрээр, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	79
Хүснэгт 4.10. Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, ундны усны эх үүвэрээр, бүгд дүнд, эзлэх хувь, 2020 он.....	80
Хүснэгт 4.10 а. Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, ундны усаа зөөдөг зай, метрээр, дүнд эзлэх хувь, 2020 .....	81
Хүснэгт 4.11. Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн хоёр нөхцөл хангасан өрхийн тоо, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	82
Хүснэгт 4.12. Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн нэг нөхцөл хангасан өрхийн тоо, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	83
Хүснэгт 4.13. Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн нөхцөл хангагдаагүй өрхийн тоо, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	84
Хүснэгт 5.1. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, өмчийн хэлбэр, хот, хөдөөгөөр, хувиар, 2010, 2020 он.....	87
Хүснэгт 5.2. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, дүнд эзлэх хувиар, 2020 он.....	88



Хүснэгт 5.3. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, эзэмшлийн хэлбэр, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	88
Хүснэгт 5.4. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, эзэмшлийн хэлбэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	89
Хүснэгт 5.5. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн усан хангамжийн төрлөөр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	90
Хүснэгт 5.6. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцны гаднах усан хангамж төрлөөр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	91
Хүснэгт 5.7. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, ундны усны эх үүсвэрээр (сууцны гаднах усан хангамжтай), дүнд эзлэх хувь, 2020 он.....	91
Хүснэгт 5.8. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, хот, хөдөө, цахилгааны эх үүсвэр, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	92
Хүснэгт 5.9. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, халаалтын эх үүсвэр, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	92
Хүснэгт 5.10. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, бохир ус зайлуулдаг хэлбэр, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2010, 2020 он.....	93
Хүснэгт 5.11. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, бохир ус зайлуулдаг хэлбэр, дүнд эзлэх хувь, 2020 он.....	93
Хүснэгт 5.12. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, бие засдаг газрын бохирыг зайлуулдаг хэлбэр, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	94
Хүснэгт 5.13. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, хатуу хог хаягдлыг зайлуулдаг хэлбэр, хот, хөдөө, дүнд эзлэх хувь, 2020 он.....	95
Хүснэгт 5.14. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, хатуу хог хаягдлыг зайлуулдаг хэлбэр, аймаг, нийслэл, дүнд эзлэх хувь, 2020 он.....	96



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1. Өрхийн тоо, хэлбэрээр, 2020 он.....	20
Зураг 2.2. Өрх, өрхөд хамааралгүй тоологдсон хүн амын тоо, 2020 он.....	21
Зураг 2.3. Хүн амьдран суух зориулалттай сууцны тоо, 2019 он.....	22
Зураг 2.4. Хүн амьдран суух зориулалттай байшингийн тоо, 2019 он.....	22
Зураг 2.5. Хүн амьдрах зориулалттай сууцны тоо, хот, хөдөө, сууцны төрлөөр, 2019 он.....	24
Зураг 2.6. Хүн байнга амьдардаг сууц, төрлөөр, хот, хөдөө, 2019 он.....	25
Зураг 2.7. Гэрийн шалны үндсэн материал, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	28
Зураг 2.8. Өрхийн тоо, сууцны төрлөөр, 2020 он.....	30
Зураг 2.9. Өрхийн тоо, сууцны төрөл, хот, хөдөөгөөр .....	31
Зураг 2.10. Орон сууцны ахуйн нөхцөл хангасан байдал, хувиар, 2020 он.....	43
Зураг 3.1. Байшинд амьдардаг өрхийн тоо, хот, хөдөө, хувиар, 2020 он.....	47
Зураг 3.2. Байшинд амьдардаг өрхийн тоо, ахуй нөхцөлөөр хангагдсан байдал, хувиар, 2020 он.....	67
Зураг 4.1. Гэрт амьдардаг өрхийн тоо, гэрийн ханын тоо, бүгд дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он.....	71
Зураг 4.2. Гэрт амьдардаг өрхийн тоо, гэрийн ханын тоо, хот, хөдөө, дүнд эзлэх хувиар, 2020 он.....	71
Зураг 4.3. Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь, 2010, 2020 он.....	73
Зураг 4.4. Гэрт амьдардаг өрхийн ахуй нөхцөл хангасан байдал хот, хөдөө, хувиар, 2020 он.....	85





## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хавсралт-1. Хүн амьдран суух зориулалттай хотын нийт сууцны тоо, аймаг, нийслэлээр, 2019 он.....	111
Хавсралт- 2. Хүн амьдран суух зориулалттай хөдөөгийн нийт сууцны тоо, аймаг, нийслэлээр, 2019 он.....	111
Хавсралт-3. Өрхийн тоо аймаг, нийслэл, хот, хөдөө, сууцны төрлөөр, 2020 он.....	112
Хавсралт-4. Байшинд амьдардаг өрхийн тоо, байшингийн төрлөөр, 2020 он.....	112
Хавсралт-5. Байшинд амьдардаг хотын өрхийн усан хангамж, аймаг, нийслэл, усан хангамжийн төрлөөр, 2020 он.....	113
Хавсралт-6. Байшинд амьдардаг хотын өрхийн хатуу хог хаягдал зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2020 он.....	113
Хавсралт-7. Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн хатуу хог хаягдал зайлуулалт, аймаг, нийслэлээр, 2020 он.....	114
Хавсралт-8. Байшинд амьдардаг хотын өрхийн тоо, аймаг, нийслэл, бохир ус зайлуулах хэлбэр, 2020 он.....	114
Хавсралт-9. Байшинд амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, бохир ус зайлах хэлбэр, 2020 он.....	115
Хавсралт-10. Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, бие засах газрын төрлөөр, 2020 он.....	115
Хавсралт-11. Гэрт амьдардаг хотын өрхийн тоо, аймаг, нийслэл, хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэрээр, 2020 он.....	116
Хавсралт-12. Гэрт амьдардаг хөдөөгийн өрхийн тоо, аймаг, нийслэл, хатуу хог хаягдал зайлуулах хэлбэрээр, 2020 он.....	116
Хавсралт-13. Гэрт амьдардаг өрхийн тоо, аймаг, нийслэл, хот, хөдөө, бохир ус зайлуулах хэлбэрээр, 2020 он.....	117



## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын төр засгаас ард иргэдийнхээ орон сууцны хангамж хүрэлцээ, тав тухтай байдлын талаарх тоо баримтыг 40 гаруй жилийн өмнөөс цуглуулж ирсэн баялаг туршлагатай юм. Тухайлбал, хүн ам, орон сууцны 1969 оноос хойших 2020 оных хүртэлх 5 тооллогод хүн амын орон сууцны нөхцөлийн талаарх тоо баримтыг тодорхойлж иржээ. Энэхүү “Орон сууцны төрөл, ашиглалт, ахуйн нөхцөл” сэдэвчилсэн судалгаа нь Байшин, орон сууцны 2019 оны тооллого болон Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгүүдийг уялдуулан боловсруулснаараа өмнөх судалгаануудаас нэлээд онцлогтой, өргөн хүрээг хамарсан бүтээл боллоо.

Энэхүү судалгааны дүн нь төр засгаас сүүлийн жилүүдэд хүний хөгжлийг хангах, амьдралын чанарыг сайжруулах, байгаль эх дэлхийгээ хамгаалах, орчны бохирдлыг багасгахын тулд юуны өмнө орон байрны асуудлыг шийдвэрлэхийн чухлыг анхаарч хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлого хөтөлбөрийг тодорхойлох, үр дүнг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм. Тус судалгаа нь 5 бүлэг, хавсралтаас бүрдэж байгаа юм.

Сэдэвчилсэн судалгааны 1 дүгээр бүлэгт судалгааны зорилго, сууцны тухай ойлголт, тодорхойлолт, 2 дугаар бүлэгт өрхийн тоо, орон сууцны төрөл нөхцөл, 3 дугаар бүлэгт байшинд амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл, 4 дүгээр бүлэгт гэрт амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл, 5 дугаар бүлэгт сууцны бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөлийн талаар тусгасан.

Судалгаанд хүн амын орон сууцны хүрэлцээ хангамж, ахуйн нөхцөлийн талаарх сүүлийн хоёр тооллогын хооронд гарсан тоон мэдээллийн өөрчлөлт, чанар байдлыг улсын хэмжээгээр, байршлаар, аймаг, нийслэлээр дэлгэрэнгүй тусгасан байна.

Тооллогын дүнг үндэслэн цаашид төр засгаас хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгод орон сууцны талаар тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрийг төлөвлөж, хэрэгжүүлэхтэй холбогдсон санал зөвлөмж оруулсан нь чухал ач холбогдолтой болсон.

Сэдэвчилсэн судалгаанд тооллогын дүнгээс зарим гол гол үзүүлэлтийг бодит тоогоор, улс, аймаг, нийслэлээр тодорхойлж, хавсаргасан нь хэрэглэгчдийн таашаалд нийцнэ гэдэгт итгэлтэй байна.



# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, СУУЦНЫ ТУХАЙ  
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**



## 1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Орон сууцны төрөл, ахуйн нөхцөлийн сэдэвчилсэн судалгааны гол зорилго нь Байшин, орон сууцны 2019 оны тооллого болон Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнг нэгтгэн өмнөх тооллогуудын дүнтэй зэрэгцүүлэн хүн амын орон сууцны хүрэлцээ хангамж, сууцны ахуйн нөхцөлийн сүүлийн жилүүдийн хөгжлийн түвшнийг тодорхойлж, цаашид төрөөс хүн амын орон сууц, түүний хангамж, хүрэлцээ, ахуйн нөхцөлийг сайжруулах талаар төрийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг дүгнэх суурь мэдээлэл болох юм.

## 1.2. ТОВЧ ОЙЛГОЛТ

Хүний эрүүл энх, тав тухай амьдрах үндсэн нөхцөлийн нэг нь орон сууц юм. Монгол Улсын төр засгаас ард иргэдийнхээ орон сууцны хүрэлцээ хангамж, тав тухтай байдал, хөгжил дэвшлийн талаарх тооллого судалгааг 1933 оноос цуглуулж ирсэн баялаг туршлагатай. Улс, хоршооллын байгууллагын орон сууцны тооллогыг 1940, 1960 онд явуулсан байдаг. Хүн ам, орон сууцны тооллогыг олон улсын нэгдсэн арга аргачлалтай нийцүүлэн 1969 оноос хойш 5 удаагийн тооллого явуулж, түүндээ хүн амын орон сууцны нөхцөлийн талаарх тоо баримтыг гаргаж иржээ. Үүнээс гадна 1969, 1979, 1989 онд улс, хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллого явуулж байсан аж.

Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд явуулсан нь тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш хийгдсэн ийм төрлийн анхны тооллого юм. Монгол Улсын төр засгаас сүүлийн жилүүдэд хүний хөгжлийг хангах, амьдралын чанарыг сайжруулахын тулд орон сууцны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ирлээ.

Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогод “Орон сууцны асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшнийг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл амьдрах нөхцөл болохын хувьд Монгол Улсын төрийн бодлогын салшгүй хэсэг юм”<sup>1</sup>, мөн түүнчлэн Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогод “Орон сууц, нийтийн аж ахуй бол хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хүн амыг орон сууцжуулах, аюулгүй ундны усаар хангах, бохир усыг цэвэршүүлэн байгаль-экологийн тэнцлийг хадгалах, хэрэглэгчийг дулаан, цахилгааны шугам сүлжээнд холбогдох нөхцөлийг бий болгох замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, бохирдлыг бууруулахад тэргүүлэх ач холбогдолтой, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн салбар мөн” гэж <sup>2</sup> тодорхойлсон байдаг.

<sup>1</sup> Монгол улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого. УИХ-ын тогтоол. 1999 он

<sup>2</sup> Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоолын хавсралт



### 1.3. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ, БАЙШИН, ОРОН СУУЦНЫ 2019 ОНЫ ТООЛЛОГОД ХЭРЭГЛЭСЭН ОРОН СУУЦ, АХУЙН НӨХЦӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн ам, орон сууцны тооллогод **сууц** гэдэг ойлголтыг ихээхэн өргөн хүрээгээр авч үздэг. Тухайлбал: бүх төрлийн байшин, гэр, цаатны урц, оюутан сурагчид, ажиллагчдын дотуур болон нийтийн байр, цэргийн хүрээ, хорих анги, асрамжийн газрын байр зэрэг хүн амьдрахад зориулагдсан бүхий л байр сууцыг хамруулахаас гадна хүн амьдрахад зориулагдаагүй, аж ахуйн нэгж, албан байгууллагад тохируулан төрөл бүрийн зориулалтаар барьсан, хүмүүс оршин сууж амьдрахаар тохижуулсан барилга байшин болон тооллогын товын үед хүн амьдарч байсан орон сууцны орц, хонгил, дулааны шугам сүлжээний худаг, вагончик, түр урц зэргийг хамруулдаг. Мөн Байшин, орон сууцны 2019 оны тооллогод хүн амьдран суух зориулалттай бүх төрлийн орон сууц, түүний насжилт, хана болон дээврийн материал, дэд бүтцийг хамруулсан. Түүнчлэн зуслангийн суурьшлын бүсийг харгалзахгүйгээр улирлын чанартай амьдардаг байшин орон сууцыг ч мөн хамруулсан.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогод өрх, хүн амын амьдарч байгаа сууцыг гэр, орон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн зориулалтын орон сууцны байшин, нийтийн байр гэж ангилсан. Өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийд нь хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, бусад сууц (Зориулалтын бус) гэж ангилж тодорхойлов. Үүнд:

**Гэр.** Монголын ард түмний уламжлалт сууц болох бүх төрлийн гэр, цаатны урцыг хамааруулсан.

**Байшин.** Байшин гэж “Нэг, болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байр” гэсэн олон улсын жишиг нэгдсэн ойлголтоор хамруулсан. Байшинд орон сууцны байшин, бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаанд болон бусад газар барьсан тоосго, шавар, мод болон бусад материалаар бүрдсэн ханатай сууцны байшин), нийтийн болон нийтийн зориулалтын бусад байрыг энд хамааруулсан.

**Орон сууцны байшин.** Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зориулалтаар ашиглаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хамруулав. Энэ нь айл өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрд зориулагдсан нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь бүх төрлийн дэд бүтцээр хангагдсан, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. (Нийтийн орон сууцны байшин, түүний доторх сууц гэсэн нарийвчилсан тодорхойлолтыг энэ судалгааны 2-р бүлэгт тусгайлан оруулав). Үүнд:

а. Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй



- б. Сууцны дотор бие засах газартай
- в. Сууцны дотор байрлуулсан онгоц шүршүүртэй
- г. Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна

**Бие даасан тохилог сууц.** Нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон, эсвэл инженерийн шугам сүлжээний холболт болон оролт нь бие даасан дулаан агааржуулалтын систем, ус хангамж, бохирын шугам, цахилгааны хангамж, холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах (ус татдаг) газартай. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц туслах өрөө тасалгаа дээврийн хөндий, зөөврийн давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамруулав. Сууцны өрөө (унтлагын ба зочны) гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах ханын шүүгээтэй мөн мансардтай, мансардгүйг үл харгалзав.

**Сууцны тусдаа байшин.** Ихэвчлэн гэр хорооллын хашаанд болон бусад газарт нэг түүнээс дээш өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын систем, ус хангамж дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй байгааг харгалзаж үзээгүй болно.

**Нийтийн байр.** Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байж болно. Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчид, бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, тэдгээртэй адилтгах бусад нийтийн байрыг хамруулав.

**Бусад.** Анхнаасаа хүн амьдрахаар зориулалтаар бариагүй эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууцыг хамруулав. Энэ нь сургууль, үйлдвэр албан газар, байгууллагын хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан) Айл өрх хүн амьдарч байгаа мөн байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад зориулагдаагүй байр, талбайг бусад сууц гэж үзэв. Жишээлбэл, вагончик, амбаар, пин агуулах, дэлгүүр мухлаг, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей) ой мод, уул хад, агуй зэрэгт айл өрх хүн амьдарч байгаа нөхцөлд бусад сууц гэж үзэв.

**Нийтийн зориулалтын бусад байр.** Нийтийн зориулалтын бусад байр гэдэгт амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, хорих газар, цэргийн хүрээ зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байрыг хамруулав. Амралтын газар гэж хот суурин болон түүнээс өөр газар байрласан амралт чөлөө цаг өнгөрөөх хэрэглэлээр тоноглогдсон үзвэр үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг, рашаан сувиллын газар гэж эмчилгээний тоног хэрэглэлээр тоноглогдсон газар гэж ойлгон үүнд хамруулав. Зочид буудал гэж хот бусад суурин газар бусад газар байрласан зочид үйлчлүүлэгчдийг хүлээн авч, байр, хоол болон бусад үйлчилгээ үзүүлдэг газрыг, түр хоноглох байр гэж авто буудал, дэн буудлын болон түүнтэй адил төстэй бусад үйл ажиллагаа явуулдаг газрыг хамруулсан.



**Өрөөний тоо.** Өрөөний тоонд амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын өрөө оруулав.

**Сууцны талбайн хэмжээ.** Сууцны талбайн хэмжээ нь хүн амьдрах талбай (амралтын унтлагын хүүхдийн, ажлын болон хооллох өрөө) туслах өрөө, тасалгаа (гал тогооны, угаалгын, бие засах өрөө хонгил, ханын шүүгээ агуулах)-ны талбайн нийлбэрээр авав.

### **УСАН ХАНГАМЖ:**

**Хамгаалагдсан гүний худаг.** Газрын гүний усны нөөцөд хүрэх хэмжээгээр гүнзгий өрөмдөж гаргасан худаг. Гүний худаг нь ус урсах голчид гаднаас хөрс нурах, гадаргын урсац нэвчихээс хамгаалсан яндантай байдаг. Гүний худгаас усыг цахилгаан эрчим хүч, дизель мотор, салхи, нарны эрчим хүчний төхөөрөмж, эсвэл гар шахуургын тусламжтайгаар гаргадаг зэрэг үзүүлэлтийг харгалзан үзэв. Гүний худгийн ус түгээх байрыг үүнд хамруулав.

**Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ус түгээх байр.** Хот суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байрыг хамааруулсан.

**Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр.** Хот, суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдоогүй нийтийн ус түгээх байр.

**Хамгаалагдсан гар худаг.** Гадаргын усны урсац худагт орохоос сэргийлж өндөрлөсөн, бетон болон бусад материалаар мал, амьтан, хог унахаас хамгаалсан байхын зэрэгцээгээр амсар нь таглаа бүхий худаг.

**Хамгаалсан булаг, шанд.** Булгийн эх ундарга нь тусгай хамгаалалтад байдаг, засаж тохижуулан хашиж хамгаалсан, гадаргын урсац орохоос хамгаалж, тоосго болон бетон хийцээр битүүлсэн ус авах зориулалтын хоолойтой булаг, шандыг хамруулна.

**Хамгаалагдаагүй гүний худаг.** Гүний худгийн ус урсах голчид гаднаас хөрс нурах, гадаргын урсац нэвчихээс хамгаалсан яндангийн хамгаалалт нь эвдэрч гэмтсэн тохиолдолд хамгаалагдаагүй гэж үзэв.

**Хамгаалагдаагүй гар худаг.** Худагт гадаргын урсац орохоос хамгаалаагүй, мал амьтан, хог унахаас хамгаалсан таглаагүй гар худаг.

**Хамгаалагдаагүй булаг, шанд.** Гадаргын урсац болон мал, амьтан орохоос хамгаалаагүй ил задгай буюу засаж тохижуулсан хаалт, хашлагагүй булаг, шанд.



**Усны машин.** Эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж ус зөөх зориулалтын тээврийн хэрэгслээр тээж борлуулах үйлчилгээ.

**Ердийн хөсгөөрх зөөврийн ус.** Ус зөөврийн зориулалтын авто тээврээс бусад мал болон бусад төрлийн хэрэгслээр зөөвөрлөн түгээх үйлчилгээг хамруулав.

**Савласан ус.** Аж ахуйн нэгжүүд тусгай хяналт, зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн ундны зориулалтаар цэвэршүүлэн савласан, зөвхөн хувийн ариун цэвэр болон ундны зориулалтаар бэлтгэгдсэн ус.

**Хурын ус.** Бороо, цасны усыг дээвэр ба газрын гадаргуугаас цуглуулж, нөөцлүүрт хадгалсан ус.

**Усны ил эх үүсвэр.** Гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм, голын салаа, татуурга болон усалгааны сувгаас шууд авсан ус.

**Бусад.** Дээрхээс өөр ундны эх үүсвэр ашигласан ус.

#### **ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР:**

**Төвлөрсөн систем.** Хот, суурины ихэнх хэрэглэгчдийг нэгдсэн сүлжээний нэг буюу хэд хэдэн эх үүсгүүрээс төвлөрсөн байдлаар цахилгаанаар хангагдаж байвал төвлөрсөн хангамжийн системтэй гэж үзэв. Улсын хэмжээний цахилгааны шугам сүлжээ (дэд станц) болон усан станцаас цахилгаанаа авдаг сууцыг төвлөрсөн системтэй гэж мөн үзэв. Цахилгаан станцад холбогдсон цахилгааны сүлжээг төвлөрсөн системтэй гэж үзэв.

**Дизель станц.** Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон цахилгааны сүлжээтэй орон сууцыг хамааруулав.

**Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж.** Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч болгодог төхөөрөмжийг үүнд хамааруулав.

**Бага оврын цахилгаан үүсгүүр.** Тухайн нэг өрх болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг үүнд хамааруулав.

#### **ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР:**

**Төвлөрсөн систем.** Улсын болон тухайн орон нутгийн хувьд дулааны цахилгаан станц, уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн халаалттай гэж үзэв.

**Уурын зуух.** Орон сууцны тухайн барилга халаалтаа уурын зуухаар шийддэг бол хувийн уурын зуухаар халаалтаа шийддэг гэж үзлээ.





**Цахилгаан халаагуур.** Тухайн өрхийн хэрэгцээг хангах үүднээс цахилгаан эрчим хүчээр ажилладаг халаах төхөөрөмжийг үүнд хамааруулав.

**Газрын гүний дулаан.** Газрын гүний дулаан ашиглан халаалтын эх үүсвэрээ шийддэг бол тухайн сууцны халаалтыг газрын гүний дулааны эх үүсвэртэй гэж үзэв.

**Шатдаг хий.** Шатдаг хийг (Байгалийн хий) ашиглан халаалтын эх үүсвэрээ шийддэг бол тухайн сууцны халаалтыг шатдаг хийн дулааны эх үүсвэртэй гэж үзнэ.

**Нам даралтын зуух.** Нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах үүднээс нэгдсэн халаалтын сүлжээнд ашиглаж буй бага оврын зуухыг үүнд оруулна.

**Ердийн галлагаа.** Уламжлалт зуух, пийшинтэй бол ердийн галлагаатай гэнэ.

### **СУУЦНЫ БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ:**

**Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.** Сууцны бохирыг цуглуулан, гадагшлуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээний системд холбогдсон бие засах газрыг хамруулав.

**Соруулдаг бохир усны цооног.** Жорлон болон гэрээс хол, газар дор байрлуулсан, ус нэвтэрдэггүй ялгадас, бохирыг хуримтлуулах савтай бохирын хоолойгоор холбогдсон бие засах газрыг хамруулав.

**Битүү тунгаагуур** гэдэгт бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах хэрэглэл юм. Тунасан лагийг үе үе юүлж цэвэрлэдэг. орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан стандартын дагуу хийгдсэн, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж,

**Энгийн нүхэн жорлон.** Газарт ухсан нүхэнд ялгадас хуримтлагддаг, гадаргын ус орохоос сэргийлсэн, тавцан суурь нь газраас дээш өндөрлөгдсөн нүхэн жорлонг хамааруулав.

**Сайжруулсан нүхэн жорлон.** Дээвэртээ агааржуулах хоолой, яндантай, хоолой болон яндангийн амсрыг ялаа шавж орохоос хамгаалан тороор тагласан, газар ухаж хавтангаар доторлосон, суудалд тааруулж гаргасан нүхтэй, гадаргын ус орохоос хамгаалж бүх талаас нь хаалт хийсэн жорлонг хамааруулсан.

**Био жорлон.** Нүүрстөрөгчөөр баялаг материал (хүнсний ногооны хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсаар үнэргүй, гэм хоргүй бордоо хийх хуурай бие засах газар.



**Битүү тунгаагуур (Септик).** Бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуур.

### **БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ:**

**Төвлөрсөн систем.** Улсын болон тухайн орон нутгийн бохир ус зайлуулалт хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн байдлаар бохир ус зайлуулдаг систем.

**Бие даасан систем.** Тухайн орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан, орон нутгийн ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр бохир ус зайлуулах бага хэмжээний систем. (бохир, ялгадас саармагжуулах танк) орно.

**Цооногт асгадаг.** Хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг хуримтлуулах, зайлуулах шаардлага хангасан хийц бүхий байгууламж.

**Задгай асгадаг.** Тусгайлан зориулсан бохир ус зайлуулах цооноггүй, задгай газарт бохир усаа асгадаг болон зөөх, булах гэх мэт гар аргаар бохирыг зайлуулдаг тохиолдлууд.

### **ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ:**

**Тохижилт үйлчилгээний байгууллагаар.** Улсын болон тухайн орон нутгийн албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл бусадтай (хог ачигчтай) гэрээ хийж хог хаягдлыг зайлуулдаг тохиолдлыг хамааруулна.

**Зөвшөөрөгдсөн цэгт хаядаг.** Албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллагын зааварчилгаагаар эсвэл албан зохицуулалтгүйгээр оршин суугчид хогоо нийтийн хогийн газар болон тодорхой төвлөрсөн цэгт зайлуулдаг тохиолдлыг хамруулсан.

**Шатаадаг.** Хог зайлуулах тодорхой газаргүй, хогоо хуримтлуулж байгаад шатаадаг тохиолдлыг хамруулав.

**Булдаг.** Хог зайлуулах тодорхой газаргүй, хогоо хуримтлуулж байгаад газар нүх ухаж булдаг тохиолдлыг хамруулна.

### **СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР:**

**Иргэний өмч.** Иргэн сууцаа өөрөө барьсан, худалдаж авсан болон хувьчилж авсан сууцыг хамруулав.



**Хувийн аж ахуйн нэгж, байгууллагын** сууцанд хувийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын (өмчийнх нь 51 хувиас дээш хувийн өмчтэй) мэдлийн сууцыг хамруулав.

**Төрийн өмч.** Төрийн өмчийн сууцанд төрийн, орон нутгийн засаг захиргааны болон төрийн өмч давамгайлсан (төрийн өмч нь 51 хувиас дээш) аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн сууц.

### **СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР:**

**Өөрийн эзэмшил.** Сууцаа хувьчилж авсан болон худалдаж авсан, өөрөө барьсан хувийн өмчийн сууцыг өөрийн эзэмшлийн сууцанд хамруулав.

**Бусдын сууцанд түрээстэй суудаг.** Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцыг түрээслэн амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг түрээсийн сууц гэж үзэв.

**Бусдын сууцанд түрээсгүй суудаг.** Төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцанд түрээсийн хөлс төлөхгүйгээр амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг бусдын сууцанд түрээсгүй суудаг гэж үзэв.



# **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ӨРХИЙН ТОО, ОРОН СУУЦНЫ  
ТӨРӨЛ, АХУЙН НӨХЦӨЛ**



## 2.1. ӨРХИЙН ТОО

Хүн ам, орон сууцны тооллогод өрх гэдэг ойлголт “Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх” гэж үздэг, олон улсын жишиг аргачлалтай. Өрхийн гишүүд нь хоорондоо садан төрлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Өрх гэдэг ойлголт нь гэр бүл гэдэг ойлголтөөс ялгаатай. Нэг өрхөд хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно. Өрхийн талаарх энэ тодорхойлолт нь өмнөх тооллогууд болон олон улсад ашигладаг нэгдмэл ойлголт юм.

### ХҮСНЭГТ 2.1. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Байршил	2010		2020		2020/2010 %
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	
<b>Бүгд</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>897.4</b>	<b>100.0</b>	<b>126</b>
Хот	479.5	67.2	606.3	67.6	127
Хөдөө	234.3	32.8	291.1	32.4	124

Монгол Улсын өрхийн тоо 2020 онд 2010 оныхоос 186.6 мянгаар буюу 25.7 хувиар өссөн байна. Өрхийн жилийн дундаж өсөлт энэ хугацаанд 2.9 хувь байгаа нь мөн үеийн хүн амын жилийн дундаж өсөлтөөс 0.7 пунктээр илүү байна.

Хотын өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2010 онд 2000 оныхоос 12.4 пунктээр өсөж байсан бол 2020 онд 2010 оныхоос 0.4 пунктээр өссөн нь хүн ам өрхөөрөө хот суурин газар уруу шилжих шилжилт бага зэрэг саарсан гэж үзэж болохоор байна.

## 2.2. ӨРХИЙН ХЭЛБЭР

Хүн ам, орон сууцны тооллогоор өрхийн хэлбэрийг тодорхойлохдоо тухайн өрхөд тоологдсон хүмүүс өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг үндэслэн тодорхойлдог олон улсын жишиг аргачлал байдаг. Монгол Улсын хүн ам, орон сууцны үе үеийн тооллогод өрхийн ам бүлийн гишүүд, өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг асууж байсан боловч өрхийн тоог өрхийн хэлбэрээр ангилан гаргах үзүүлэлтийг хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн тодорхойлж ирсэн.

### ХҮСНЭГТ 2.2. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Өрхийн хэлбэр	2010		2020	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>713.8</b>	<b>100.0</b>	<b>897.4</b>	<b>100.0</b>
Ганц бие	75.9	10.6	137.8	15.4
Ам бүлээрээ	445.0	62.4	536.3	59.8
Нийлмэл	177.9	24.9	203.3	22.6
Холимог	14.4	2.1	20.0	2.2

Хотын нийт өрхөд ганц бие өрхийн эзлэх хувь 2010 онд 9.9 байсан бол 2020 онд 14.2 болж нэмэгджээ. Энэ үзүүлэлт хөдөөд 12.2 хувиас 17.7 болж өссөн байна.



## ЗУРАГ 2.1. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН.




Монгол улсын нийт өрхийн дотор ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 61.9 мянгаар буюу 81.5 хувиар өссөн нь бусад хэлбэрийн өрхөөс өндөр өсөлттэй байна. Энэ нь манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл, онцлогтой уялдаатай байж болох боловч цаашдаа хүн амын өсөлт хөгжилд сөрөг нөлөөтэй үзүүлэлт учир үүний шалтгаан нөхцөлийг цаашид анхааран нарийвчлан судлах шаардлагатай юм.

Ам бүлээрээ өрх гэдэгт эхнэр, нөхөр, үр хүүхдүүдийнхээ хамт амьдарч байгаа өрхийг хамааруулдаг. Манай улсын 10 өрх тутмын 6 нь ам бүлээрээ амьдарч байна. Нийлмэл ам бүлтэй өрхөд эцэг, эх, ах, дүүс садан төрлөөрөө амьдарч байгаа өрхийн хамруулдаг. Ийм өрхийн тоо өнгөрсөн тооллогын үеийнхээс 25.4 мянгаар буюу 14.3 хувиар өссөн байна. Ураг төрлийн хамааралтай, хамааралгүй хүмүүс өрх болон амьдарч байгааг холимог өрх гэж үздэг. Ийм төрлийн өрхийн тоо өнгөрсөн тооллогын үеийнхээс 5.1 мянгаар буюу 34.2 хувиар өссөн байна.

”Өрх үүсгээгүй нэгжид тоологдсон” хүмүүст тооллогын үед нийтээрээ буюу хэсэг бүлгээрээ амьдарч байгаа хоорондоо гэр бүл, ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүсийг хамааруулдаг. Өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүмүүс ихэвчлэн цэрэг, хоригдол, оюутан сурагчид болон ажиллагчдын нийтийн байр, эмнэлэг, сувилал, зочид буудлын нэг өрөөнд хамт амьдарч байгаа болон орон сууцны нэг өрөө буюу бүхэлд нь хөлслөн сууж байгаа мөн байшингийн дээвэр хонгил, орц, дулааны шугам сүлжээний сувагт хамт амьдардаг, ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүс хамаардаг.



## ЗУРАГ 2.2. ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2020 ОН



Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 897.4 мянган өрхөд бүх хүн амын 97.7 хувь нь, үлдсэн 2.3 хувь нь өрх үүсгээгүй нэгжид тоологдсон нь өмнөх тооллогын үеийнхээс 1.2 пунктээр буурсан байна. Энэ нь албан бусаар ашигт малтмал олборлогчид, болон бусад нийтийн болон бусад байранд гэр бүл, садан төрлийн холбоогүй хүмүүс хамтран амьдрагчдын тоо өмнөх тооллогын үеийнхээс буурсантай холбоотой юм.

Өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүн амын нийт хүн амд эзлэх хувь улсын дунджаар 2.3 хувь байна. Өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүн амын нийт хүн амд эзлэх хувь Улаанбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Төв аймгуудад улсын дунджаас өндөр байгаагийн дотор Өмнөговь аймагт хамгийн өндөр (5.6 хувь) байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлд олон тооны ажиллагчид байдагтай холбоотой.

### 2.3. ХҮН АМЬДРАХАД ЗОРИУЛАГДСАН СУУЦНЫ ТОО, ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын хүрээнд Байшин, орон сууцны тооллогыг 2019 оны сүүлийн хагас жилд зохион байгуулж явуулсан. Манай улсад орон сууцыг хүн амьдардаг эсэхийг харгалзалгүйгээр тоолох ажиллагаа 1989 оноос хойш явуулаагүй байсан билээ.

Улс, хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллогыг 1990-ээд он хүртэл нэлээд хэдэн удаа явуулж байсан боловч хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын хүрээнд улс хоршооллын байгууллагын орон сууцны фондын тооллого явуулах шаардлагагүй болсон байв. Учир нь: тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, 1990-ээд оны сүүлч гэхэд улс, хоршооллын байгууллагын өмчид байсан орон сууцны 90 гаруй хувь нь хувьчлагдсан байсан. Гэвч хүн амын орон сууцны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, сууцанд хүн амьдрах орчин нөхцөл, эрүүл ахуйн шаардлагыг дээшлүүлэх талаарх төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай тоо мэдээллийг бүрдүүлэх шаардлага сүүлийн үед улам нэмэгдэх болсон.

Байшин, орон сууцны тооллогын үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хүн амьдран суух зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлох, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд оршиж байв. Нөгөө талаар байшин, орон сууцны тооллогыг явуулах урьдах нөхцөл



тодорхой хэмжээгээр хангагдсан байлаа. Үүний нэг жишээ нь Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” -ыг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлсэн явдал байв.

Байшин, орон сууцны 2019 оны тооллогын дүнгээр улсын хэмжээнд 677 620 сууц байгаагийн 44.9 хувь нь гэр, үүний дотор 74.2 хувь нь үндсэн гэр үлдэх хэсэг нь илүү гэр байв. Нийт сууцны 55.1 хувь нь байшин сууц байгаагийн дотор 78.3 хувь нь үндсэн байшин, 21.7 хувь нь улирлын чанартай хүн амьдардаг зуслангийн байшин байна.


Тооллогоор хүн байнга амьдардаг өрхийн дэлгэрэнгүй мэдээллийг тухайн өрхийн гишүүдээс асууж цуглуулсан.

### **ЗУРАГ 2.3. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ СУУЦНЫ ТОО, 2019 ОН**



Хүн байнга амьдрах зориулалттай нийт сууцнаас тооллогын үед 442 725 сууцанд хүн байнга амьдарч байсны 51.0 хувь нь буюу 22 884 нь гэр, 46.0 хувь нь буюу 216 841 нь байшин байна.

### **ЗУРАГ 2.4. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ, ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ БАЙШИНГИЙН ТОО, 2019 ОН**



*\*Байшингийн доторх сууцыг оруулаагүй дүн.*

Орон сууцны байшин гэсэн ойлголт, тодорхойлолтын хүрээнд нийтийн орон сууцны байшин, түүний доторх сууц гэсэн олон улсын жишиг ойлголт байдаг.

Зориулалтын зураг төслөөр баригдсан бүтэц хийцийн хувьд хоёроос дээш айл суухад зориулан төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран) ус, цахилгаан, дулаан, бохир, цэвэр ус





зайлуулах болон бусад дэд бүтцийн нэгдсэн системтэй сууцыг, нийтийн зориулалтын орон сууцны байшин гэж ойлгодог.

Нийтийн зориулалтын орон сууцны байшин дотор өрх тус бүрд зориулагдсан нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, тоноглол төхөөрөмжтэй, бусад айлаас тусгаарласан зориулалтын хана (хаалттай) нэгдсэн шат, хонгил эсвэл гудамж, хашаа уруу шууд гарах хаалгатай нэг айл суухад зориулагдсан дэд бүтцийн системтэй сууцыг нийтийн сууцны байшин доторх сууц гэж ойлгодог. Байшин, орон сууцны 2019 оны тооллогын дүнгээр нийтийн зориулалттай орон сууцны 7444 байшинд 335 587 айлын сууц байна.

Хүн байнга амьдардаг улсын хэмжээний нийт сууцны 32.0 хувь нь нийслэлд, 25.0 хувь нь Хангай бүсэд, 18.1 хувь нь Төвийн бүсэд, 15.5 хувь нь баруун бүсэд, 9.4 хувь нь Зүүн бүсэд байна.


### ХҮСНЭГТ 2.3. ХҮН АМЬДРАХ ЗОРИУЛАЛТТАЙ СУУЦНЫ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	СУУЦНЫ ТӨРӨЛ			
		Гэр	Илүү гэр	Байшин	Зуслангийн байшин
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>677 620</b>	<b>225 884</b>	<b>78 477</b>	<b>292 255</b>	<b>81 004</b>
Архангай	30 053	12 846	5 311	9 327	2 569
Баян-Өлгий	17 525	327	42	16 598	558
Баянхонгор	27 044	14 065	7 227	4 789	963
Булган	19 226	5 593	660	10 348	2 625
Говь-Алтай	12 973	8 260	2 074	2 412	227
Дорноговь	14 909	5 805	2 488	5 965	651
Дорнод	17 714	5 044	1 320	9 256	2 094
Дундговь	13 598	8 166	2 056	2 711	665
Завхан	20 331	8 520	2 882	7 819	1 110
Өвөрхангай	33 144	16 891	4 824	9 333	2 096
Өмнөговь	19 106	10 354	4 701	3 879	172
Сүхбаатар	18 508	9 959	1 839	5 779	931
Сэлэнгэ	25 064	4 216	1 399	17 344	2 105
Төв	29 720	9 762	4 743	10 973	4 242
Увс	20 564	12 124	2 710	4 387	1 343
Ховд	19 105	10 197	3 174	5 263	471
Хөвсгөл	46 736	8 573	3 603	24 842	9 718
Хэнтий	25 134	9 992	2 658	8 551	3 933
Дархан-Уул	15 145	1 954	1 539	9 991	1 661
Орхон	22 246	3 827	803	14 297	3 319
Говьсүмбэр	2 815	1 370	419	976	50
Улаанбаатар	226 960	58 039	22 005	107 415	39 501

Хүн амьдран суух зориулалттай сууцны төрөл, байршлаар нэлээд ялгаатай байна. (Хавсралт-1, Хавсралт-2)



## ЗУРАГ 2.5. ХҮН АМЬДРАХ ЗОРИУЛАЛТТАЙ СУУЦНЫ ТОО, ХОТ, ХӨДӨӨ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2019 ОН



Байшин, орон сууцны тооллого явуулсны гол ач холбогдол нь улсын хэмжээнд байгаа хүн амьдрахад зориулагдсан нийт сууцны тоог төрөл тус бүрээр нь тодорхойлсны дотор тэдгээрт хүн байнга амьдардаг, амьдардаггүйгээр (Илүү гэр, зуслангийн байшин зэрэг) нь ялган тодорхойлсон нь цаашид улсын хэмжээнд орон сууцны хүрэлцээ хангамжийн талаарх төсөл хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой мэдээлэл бүрдсэн гэж үзэж байна.

### ХҮСНЭГТ 2.4. ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ҮҮНЭЭС: СУУЦНЫ ТӨРЛӨӨР				
		Гэр	Нийтийн орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин	Бие даасан тохилог сууц	Нийтийн байр
<b>УЛСЫН ДҮН</b>	<b>442 725</b>	<b>225 884</b>	<b>7 444</b>	<b>203 556</b>	<b>4 257</b>	<b>1 584</b>
Архангай	19 395	12 846	56	6 479	9	5
Баян-Өлгий	15 204	327	64	14 559	198	56
Баянхонгор	17 464	14 065	146	3 151	83	19
Булган	12 699	5 593	53	6 994	42	17
Говь-Алтай	10 303	8 260	359	1 624	38	22
Дорноговь	10 461	5 805	311	4 155	147	43
Дорнод	12 162	5 044	229	6 577	293	19
Дундговь	10 194	8 166	85	1 734	170	39
Завхан	14 083	8 520	67	5 356	101	39
Өвөрхангай	23 672	16 891	95	6 447	196	43
Өмнөговь	13 479	10 354	95	2 772	209	49
Сүхбаатар	14 704	9 959	133	4 090	472	50
Сэлэнгэ	17 673	4 216	280	12 829	304	44
Төв	17 480	9 762	199	7 082	333	104
Увс	15 076	12 124	105	2 815	25	7
Ховд	14 188	10 197	175	3 765	31	20
Хөвсгөл	23 178	8 573	83	14 429	66	27
Хэнтий	14 659	9 992	144	4 428	67	28
Дархан-Уул	8 646	1 954	425	5 959	245	63
Орхон	14 147	3 827	205	9 774	324	17
Говьсүмбэр	2 168	1 370	58	710	26	4
Улаанбаатар	141 690	58 039	4 077	77 827	878	869




## ХҮСНЭГТ 2.5. ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦАНД НИЙТИЙН ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДОТОРХ СУУЦНЫ ЭЗЛЭХ ХУВЬ, 2019 ОН

Улсын дундаж хувь 43.5							
Улсын дундажаас хамгийн өндөр				Улсын дундажаас хамгийн бага			
Аймаг, нийслэл	Хүн байнга амьдардаг сууц*	Нийтийн орон сууцны байшингийн доторх сууц	Нийтийн орон сууцны байшин доторх сууцны эзлэх хувь	Аймаг	Хүн байнга амьдардаг сууц*	Нийтийн орон сууцны байшингийн доторх сууц	Нийтийн орон сууцны байшин доторх сууцны эзлэх хувь
Дархан-Уул	23 768	15 547	65.4	Өвөрхангай	25 871	2 294	8.9
Улаанбаатар	387 834	250 221	64.5	Баян-Өлгий	16 519	1 379	8.3
Говьсүмбэр	4 549	2 439	53.6	Хөвсгөл	25 011	1 916	7.7
Орхон	27 091	13 149	48.5	Архангай	20 826	1 487	7.1
Дорноговь	18 836	8 686	46.1	Завхан	15 086	1 070	7.1

\*Орон сууцны байшингийн доторх сууцыг оруулсан дүн

Хүн байнга амьдарч байгаа сууцны төрөл хот, хөдөөд ихээхэн ялгаатай, үүний дотор нийтийн орон сууцны байшин томоохон төв суурин газарт гол төлөв байдаг тулд нийт сууцанд тохилог орон сууцны эзлэх хувь байршлаар нэлээд ялгаатай байна.

## ЗУРАГ 2.6. ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦ, ТӨРЛӨӨР, ХОТ, ХӨДӨӨ, 2019 ОН



Манай орны ард иргэд орон сууцны байшинд амьдрах нь тийм ч эртний уламжлалтай биш. Ялангуяа нийтийн орон сууцны байшинд амьдарч эхэлсэн нь ХХ зууны дунд үеэс гэж үзэж болох юм.



## ХҮСНЭГТ 2.6. ОРОН СУУЦНЫ БАЙШИН, АШИГЛАЛТАД ОРСОН ОНООР, 2019 ОН

Ашиглаглалтад орсон оны ялгаа	Бүгд	ҮҮНЭЭС: СУУЦНЫ ТӨРЛӨӨР			
		Нийтийн зориулалттай орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин	Бие даасан тохилог сууц	Нийтийн байр
Бүгд	216 841	7 444	203 556	4 257	1 584
1950 оноос өмнө	361	22	310	-	29
1950-1959 он	2 307	251	1 900	13	143
1960-1969 он	2 850	470	2 211	22	147
1970-1979 он	4 414	734	3 511	25	144
1980-1989 он	13 128	993	11 786	64	285
1990-1999 он	26 511	441	25 765	214	91
2000-2009 он	64 414	1 330	61 681	1 114	289
2009-2019 он	96 929	3 160	90 693	2 660	416
Тодорхойгүй	5 927	43	5 699	145	40

Байшин, орон сууцны 2019 оны тооллогын дүнгээрх орон сууцны нийт байшинд 1960 оноос өмнө ашиглалтад орсон барилга зөвхөн 1.2 хувийг, нийтийн орон сууцны байшин 3.7 хувийг, сууцны тусдаа байшин 1.1 хувийг тус тус эзэлж байна. Бие даасан тохилог сууц 1950 оноос өмнө байсангүй.

Монгол Улсад орон сууцны барилга үүний дотор нийтийн орон сууцны барилга баригдаж эхэлсэн нь 1950-иад оны сүүлч, 1960-аад оноос нэлээд эрчимжсэнийг түүхийн олон баримтаас харж болно.

## ХҮСНЭГТ 2.7. ОРОН СУУЦНЫ БАЙШИН, АШИГЛАЛТАД ОРСОН ОНООР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

Ашиглалт орсон оны ялгаа	ХОТ				ХӨДӨӨ			
	Байшингийн тоо-бүгд	Дүнд эзлэх хувь	Нийтийн орон сууцны байшингийн тоо	Дүнд эзлэх хувь	Байшингийн тоо-бүгд	Дүнд эзлэх хувь	Нийтийн орон сууцны байшингийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	148 442	100.0	6 658	100.0	68 399	100.0	786	100.0
1950 оноос өмнө	233	0.2	22	0.3	128	0.2	-	-
1950-1959 он	1 396	0.9	236	3.5	911	1.3	15	1.9
1960-1969 он	1 622	1.1	355	5.3	1 228	1.8	115	14.6
1970-1979 он	2 634	1.8	557	8.4	1 780	2.6	177	22.5
1980-1989 он	7 711	5.2	833	12.5	5 417	7.9	160	20.4
1990-1999 он	17 121	11.5	382	5.7	9 390	13.7	59	7.5
2000-2009 он	47 962	32.3	1 265	19.0	16 452	24.1	65	8.3
2009-2019 он	64 796	43.7	2 971	44.6	32 133	47.0	189	24.0
Тодорхойгүй	4 967	3.3	37	0.6	960	1.4	6	0.8

Манай улсад нийтийн орон сууцыг 1950-иад оноос эхэлж барьж эхэлсэн ялангуяа нийслэлд 1950-иад оны сүүлчээс нэг, хоёрдугаар дөчин мянгат, тавин мянгат, 120-н мянгатын орон сууцны хороолол, сүүлдээ 1960-аад оны сүүлч 1970-1980-аад онд ЗХУ-(Хуучин нэрээр) техник, эдийн засгийн тусламжаар олон хороолол ашиглалтад орж байсан боловч, тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн эхний үед нийтийн зориулалтын орон сууцны барилга



барих ажил бага зэрэг саарсан боловч сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж байгаа нь харагдаж (Хүснэгт-2.6, 2.7) байна.

Байшин, орон сууцны 2019 оны тооллогоор орон сууцны барилгын ханын үндсэн материалыг цутгамал төмөр бетон, угсармал төмөр бетон, блок, тоосго, мод сэндвич хавтан бусад гэсэн ангиллуудаар ангилж тодорхойлов. Ингэхдээ цутгамал төмөр бетон гэдэгт: хэв болон арматурын эд ангийг бэлтгэх бэлэн бэлдцээр, салангид хэв босгож арматур зангидаж, ханыг бетон хольц зуурч дүүргэсэн бүтээцийг, угсармал төмөр бетон гэдэгт: угсармал бетонон хавтанг барилгад байрлуулан давхарлан дүүргэсэн бүтээцийг, холимог гэдэгт: хэв болон арматурын эд ангийг бэлтгэж, бэлэн байдлаар салангид хэв босгож ханыг тоосго блок гэх мэт материалаар дүүргэсэн бүтээцийг тус тус ойлгож хамруулсан болно.


### ХҮСНЭГТ 2.8. БАЙШИНГИЙН ТОО, ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

Ханын үндсэн материал	Бүгд		НЗОСБ*		Сууцны тусдаа байшин		Бие даасан тохилог сууц		Нийтийн байр	
	Сууцны тоо.Мян	Дүнд эзлэх хувь	Сууцны тоо.Мян	Дүнд эзлэх хувь	Сууцны тоо.Мян	Дүнд эзлэх хувь	Сууцны тоо.Мян	Дүнд эзлэх хувь	Сууцны тоо.Мян	Дүнд эзлэх хувь
Бүгд	216.8	100.0	7.4	100.0	203.6	100.0	4.3	100.0	1.6	100.0
Цутгамал төмөр бетон	5.2	2.4	1.9	24.9	3.0	1.5	0.2	5.9	0.1	4.1
Угсамал төмөр бетон	1.9	0.9	1.3	17.8	0.5	0.2	0.1	2.0	-	0.9
Блок	45.5	21.0	0.8	10.9	43.5	21.4	0.8	19.2	0.4	22.7
Тоосго	27.8	12.8	2.3	30.6	23.8	11.7	1.3	31.7	0.4	25.4
Мод	127.1	58.6	-	-	125.2	61.5	1.3	29.4	0.6	38.2
Сэндвич хавтан	1.1	0.5	-	-	0.8	0.4	0.2	5.8	-	2.1
Холимог	4.3	2.0	0.7	9.6	3.3	1.6	0.2	4.4	0.1	3.3
Бусад	4.0	1.8	0.5	6.2	3.5	1.7	0.1	1.6	0.1	3.3

Байшингийн 57.9 хувь нь бетонон шалтай, 36.5 хувь нь модон шалтай, 5.6 хувь нь бусад материалаар бүтсэн шалтай юм. Харин шалны хучилтад хулдаас 55.6 хувь, шахмал паркет 24.5 хувь, модон паркет 10.7 хувь, үлдэх 8.6 хувь нь мод, плита болон бусад материалаар хучсан байна.



## ЗУРАГ 2.7. ГЭРИЙН ШАЛНЫ ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Манай улсад гол төлөв төв суурин газрын гэр хороололд сууцны тусдаа байшин сүүлийн үед олон тоогоор баригдах болсон. Тэдгээрийн талбайн хэмжээ бие даасан тохилог сууцтай жишихэд арай бага байдаг байна. Тухайлбал: 51 хүртэл Кв.м талбайтай сууцны тусдаа байшин нийт сууцны 51.9 хувийг эзэлж байхад бие даасан тохилог сууцанд энэ хувь 13.4 хувь байна. Харин 100 түүнээс дээш Кв.м талбайтай сууц сууцны тусдаа байшингийн 6.7 хувийг эзэлж байхад бие даасан тохилог сууцанд энэ хувь 47.3 хувь байна.

### ХҮСНЭГТ.2.9. СУУЦНЫ ТУСДАА БАЙШИН БОЛОН БИЕ ДААСАН ТОХИЛОГ СУУЦНЫ ТОО, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

Сууцны талбайн хэмжээ, кв.м	Сууцны тусдаа байшингийн тоо	Дүнд эзлэх хувь	Бие даасан тохилог сууц	Дүнд эзлэх хувь
Бүгд	203 556	100.0	4 257	100.0
21 хүртэлх	8 261	4.1	11	0.3
21-30	24 042	11.8	89	2.1
31-40	32 370	15.9	122	2.9
41-50	41 051	20.2	348	8.2
51-60	29 627	14.6	207	4.9
61-70	22 280	10.9	452	10.6
71-80	18 037	8.9	442	10.4
81-90	6 192	3.0	215	5.1
91-100	7 217	3.5	306	7.2
101+	13 549	6.7	2 013	47.3
Тодорхойгүй	930	0.5	52	1.2

Байшин, орон сууцны 2019 оны тооллогоор орон сууцны үнийг тооллогод хамрагдаж буй өрхийн гишүүний тооллогын хуудасны асуултад хариулснаар



авсан. Ингэхдээ ямар нэг шалгуур тавиагүйг хэрэглэгчид анхаарах нь зүйтэй. Тооллогын дүнгээс үзэхэд сууцны тусдаа байшингийн 14.3 хувь нь 11 сая хүртэл төгрөгийн үнэтэй, харин 11-30 сая төгрөгийн үнэтэй байшин бүх байшингийн 46,5 хувийг, 31 саяас дээш төгрөгийн үнэтэй нь 26.8 хувийг эзэлж байхад бүх байшингийн 12.4 хувьд өрхийн гишүүд өөрийнхөө сууцыг үнэлээгүй байв. Харин бие даасан тохилог сууцны 61.7 хувь нь 51 ба түүнээс дээш сая төгрөгийн үнэтэй гэж хариулсан байна.

Нийтийн орон сууцны байшингийн 1990 оноос өмнө баригдсан байшин доторх сууцны 56.6 хувь нь нэг кв.м талбай нь нэг сая хүртэл төгрөгийн үнэтэй, 35.7 хувь нь 1.1-1.2 сая төгрөгийн үнэтэй гэж хариулсан байна. Харин орон сууцны байшин нь 1990 оноос хойш баригдсан нийт сууцны 28.1 хувь нь нэг кв.м талбайн үнэ нэг сая хүртэл төгрөгийн үнэтэй, харин 53.4 хувь нь 1.1-1.2 сая төгрөгийн үнэтэй гэж хариулсан байна.

Гэрийн үнэлгээ нь гэрийн ханын тоо, болон төв суурин газарт харилцан адилгүй байгааг дараах хүснэгтээс харж болно.

#### **ХҮСНЭГТ.2.10. ГЭРИЙН ТОО, ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН**


Гэрийн зах зээлийн үнэ	БҮГД	ҮҮНЭЭС: ХАНЫН ТОГООР				
		4	5	6	8	10
Бүгд						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
2 сая түүнээс бага	42.8	61.1	41.6	25.5	11.0	22.0
2.1-4 сая	37.2	25.6	39.1	47.2	29.4	22.0
4-өөс дээш сая	15.9	8.0	15.0	25.4	58.2	52.0
Тодорхойгүй	4.1	5.3	4.3	1.9	1.4	4.0
Хот						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
2 сая түүнээс бага	53.4	71.7	53.3	29.2	13.7	27.7
2.1-4 сая	29.4	13.3	31.6	42.1	23.6	15.7
4-өөс дээш сая	11.1	6.7	8.8	26.5	60.6	53.0
Тодорхойгүй	6.2	8.3	6.3	2.2	2.2	3.6



## 2.4 ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Судалгааны дараагийн хэсэгт өрхийн орон сууцны төрөл, нөхцөлийн талаарх үзүүлэлтүүдийг хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр танилцуулах болно гэдгийг хэрэглэгчид анхаарна гэдэгт найдаж байна.

### ЗУРАГ 2.8. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр нийт өрхийн 38.2 хувь нь гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Манай улсын өрхүүдийн сууцны төрөл сүүлийн 20 жилд нэлээд өөрчлөгдөж, хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 50.9 хувь нь гэрт амьдарч байсан бол 2010 онд 45.2 хувь, 2020 онд өмнөх тооллогынхоос 7.0 пунктээр буурчээ. Энэ нь хот, суурин газарт оршин суугаа өрхийн тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр нийтийн орон сууцны байшин олон тоогоор ашиглалтад орж, мөн хот суурин газарт төдийгүй хөдөө орон нутаг амьдарч байгаа өрхүүд байшинд амьдрах нь улам нэмэгдэж байгаатай холбоотой.

### ХҮСНЭГТ 2.11. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	2010		2020	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	713.8	100.0	897.4	100.0
Гэр	322.8	45.2	342.4	38.2
Байшин	382.8	53.6	547.0	60.9
Орон сууцны байшин	152.3	21.3	264.3	29.4
Бие даасан тохилог сууц	3.8	0.5	6.5	0.7
Сууцны тусдаа байшин	209.9	29.6	267.9	29.9
Нийтийн байр	16.7	2.3	8.3	0.9
Бусад сууц	8.2	1.2	8.0	0.9

Өрхүүдийн сууцны төрөл байршлаар нэлээд ялгаатай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна. Төрөөс хүн амыг орон сууцжуулах төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж байгаагийн үр дүнд байшинд амьдардаг өрхийн тоо нийслэл болон аймгуудын төвүүдэд нэлээд өсжээ.

Хотын нийт өрхийн 74.5 хувь нь байшинд, 24.7 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 8.0 пунктээр буурч, байшинд амьдардаг өрхийнх 8.6 пунктээр нэмэгджээ. Хөдөөгийн өрхийн





66.1 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 4.8 пунктээр буурч, харин байшинд амьдардаг өрхийн хувь 4.2 пунктээр өссөн байна. Ерөнхийдөө хот, хөдөөд гэр, байшинд амьдардаг өрхийн хувийн жинд гэрийн эзлэх хувь тооллого хооронд буурч байна.

Байшинд амьдардаг өрхийн тоо өсөж байгаагийн дотор бие даасан тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэж байгаа нь хүн амын амьдралын чанар дээшилж, тав тухтай амьдрах нөхцөл нэмэгдэж байгааг харуулж байна. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 29.4 хувийг эзэлж байгаа нь 2010 оныхоос 8.1 пунктээр нэмэгджээ.

Үүний дотор сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2010 оныхоос 0.5 пунктээр, бие даасан тохилог сууцных 0.2 пунктээр тус тус өсөв. Гэрт амьдардаг өрхийн тоо хөдөөд илүү хэвээр байгаа боловч сумын төв, хөдөөгийн өрхүүдийн сууцны төрөл бас ялгаатай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.


## ХҮСНЭГТ 2.12. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, БАЙРШИЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	БҮГД	БАЙРШИЛ				
		Нийслэл	Аймгийн төв	Тосгон	Сумын төв	Хөдөө
2010						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	45.2	28.9	39.4	36.7	52.0	84.7
Байшин	53.6	69.7	59.1	62.3	46.9	14.9
Бусад сууц	1.2	1.4	1.5	1.0	1.1	0.4
2020						
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэр	38.2	22.2	29.9	32.3	39.6	79.1
Байшин	60.9	77.3	68.8	65.9	58.6	20.1
Бусад сууц	0.9	0.5	1.3	1.8	1.8	0.8


Байшинд амьдардаг өрхийн тоо нийслэлд 7.6 пунктээр өссөн байхад, аймгийн төвд 9.7 нэмэгдсэн нь аймгийн төвүүдэд орон сууцны барилга эрчимтэй нэмэгдэж байгааг харуулж байна.

## ЗУРАГ 2.9. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

### ХОТ



### ХӨДӨӨ





Өрхийн амьдарч байгаа сууцны төрөл хот, хөдөөд нэлээд ялгаатай байгаагийн зэрэгцээгээр, аймаг, нийслэлд мөн ялгаатай байгаа билээ. (Хавсралт-3)

### ХҮСНЭГТ 2.13. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Аймаг, нийслэл	Гэр амьдардаг өрх		Байшинд амьдардаг өрх		Бусад сууцанд	
	2010	2020	2010	2020	2010	2020
Бүгд	45.2	38.2	53.6	60.9	1.1	0.9
Архангай	73.6	70.5	26.2	28.7	0.3	0.8
Баян-Өлгий	5.1	3.0	94.5	95.6	0.4	1.4
Баянхонгор	86.2	78.3	13.5	21.0	0.4	0.7
Булган	53.6	50.2	45.8	47.5	0.6	2.3
Говь-Алтай	83.5	80.2	16.0	19.1	0.6	0.7
Дорноговь	45.4	41.1	53.2	57.6	1.4	1.3
Дорнод	31.5	34.4	62.0	63.1	6.5	2.5
Дундговь	82.4	78.0	17.2	21.3	0.4	0.7
Завхан	74.9	65.5	24.8	33.2	0.3	1.3
Өвөрхангай	82.2	69.0	17.5	30.2	0.3	0.8
Өмнөговь	80.1	73.5	19.1	25.6	0.8	1.0
Сүхбаатар	69.7	64.3	28.3	35.4	2.0	0.3
Сэлэнгэ	24.6	22.7	74.6	76.0	0.8	1.3
Төв	62.1	59.6	36.7	39.3	1.2	1.2
Увс	84.9	79.4	14.8	19.9	0.3	0.7
Ховд	73.4	69.5	26.1	27.9	0.5	2.7
Хөвсгөл	62.7	47.4	36.9	51.0	0.4	1.6
Хэнтий	61.7	62.4	37.7	36.4	0.7	1.3
Дархан-Уул	17.5	13.1	81.0	86.1	1.5	0.8
Орхон	24.4	15.7	74.6	83.9	1.0	0.4
Говьсүмбэр	35.7	37.4	62.8	60.7	1.5	1.9
Улаанбаатар	29.0	22.2	69.7	77.3	1.4	0.5

Өрхийн сууцны төрөл, аймгуудын дундаас Баян-Өлгий аймаг ихээхэн онцлогтой, 2020 оны тооллогын дүнгээр энэ аймгийн нийт өрхийн дөнгөж 3.0 хувь нь гэрт амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 2.1 пунктээр буурсан байна.

Энэ нь Казах түмний эрт дээр үеэс амьдарч ирсэн үндэсний онцлогтой том гэрт амьдарч ирсэн боловч уул гэр нь өвлийн улиралд хүйтэн, дулаан хадгалах чадвар муу байдгаас сүүлийн үед Казахууд хот, хөдөөгүй байшинд амьдрах болсонтой холбоотой.

Улсын хэмжээнд гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 7.1 пунктээр буурсны дотор ихэнх аймаг болон нийслэлд энэ үзүүлэлт буурсан байхад харин Дорнодод 2.9, Говьсүмбэрт 1.7, Хэнтийд 0.7 пунктээр өссөн байна. Нийт өрхөд гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь Хөвсгөлд 15.3, Өвөрхангайд 13.2, Завханд 9.7, Орхонд 8.7, Баянхонгорт 7.9 пунктээр буурсан нь бусдаас өндөр байна. Харин Сэлэнгэд 1.9, Булганд 3.4, Говь-Алтайд 3.2, Архангайд 3.1 пунктээр буурсан нь бусад аймаг, нийслэлээс бага байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өрхийн сууцны өмчийн хэлбэрийг иргэний, хувийн аж ахуйн нэгжийн, төрийн гэж ангилсан нь өмнөх 2010 оны тооллогынхтой ижил байна.



## ХҮСНЭГТ 2.14. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨМЧИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	БҮГД		ӨМЧИЙН ХЭЛБЭР		
	Мян. өрх	Эзлэх хувь	Иргэний	Хувийн ААНБ	Төрийн
<b>2010</b>					
БҮГД	713.8	100.0	96.2	2.2	1.6
Гэр	322.8	100.0	99.2	0.4	0.4
Байшин	382.8	100.0	94.7	2.9	2.5
Бусад сууц	8.2	100.0	48.6	39.8	11.6
<b>2020</b>					
БҮГД	897.4	100.0	98.5	0.8	0.7
Гэр	342.4	100.0	99.1	0.8	0.1
Байшин	547.0	100.0	98.3	0.7	1.0
Бусад сууц	8.0	100.0	95.8	1.9	2.3

Тооллогын дүнгээс үзэхэд өөрийн өмчийн сууцанд амьдарч байгаа өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 2.3 пунктээр нэмэгдэж, манай иргэд үндсэндээ өөрийн өмчийн сууцтай болсон байна. Байшинд амьдарч байгаа өрхийн нэг хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 1.5 пунктээр буусан байна.

Өрхийн сууцны өмчлөл, эзэмшил нь нэлээд ялгаатай үзүүлэлт билээ. Улсын хэмжээний нийт өрхийн хэдэн хувь нь өөрийн гэсэн сууцтай, хэдэн хувь нь айлд эсвэл түрээсийн сууцанд амьдарч байгааг харуулах үзүүлэлт бол сууцны эзэмшлийн хэлбэр юм. Энэ нь цаашид хүн амыг орон сууцжуулах төсөл хөтөлбөрийг боловсруулахад шаардагдах мэдээллийн эх үүсвэр болдог.

## ХҮСНЭГТ 2.15. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Эзэмшлийн хэлбэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Мян.өрх	Дүнд зэлэх хувь	Мян.өрх	Дүнд зэлэх хувь	Мян.өрх	Дүнд зэлэх хувь
<b>2010</b>						
БҮГД	713.8	100.0	479.5	100.0	243.3	100.0
Өөрийн	619.0	86.7	401.1	83.7	217.9	93.1
Бусдын сууцанд түрээстэй	45.0	6.3	40.9	8.5	4.1	1.7
Бусдын сууцанд түрээсгүй	43.5	6.1	33.0	6.9	10.6	4.5
Бусад	6.3	0.9	4.5	0.9	1.7	0.7
<b>2020</b>						
БҮГД	897.4	100.0	606.3	100.0	291.1	100.0
Өөрийн	822.6	91.6	547	90.2	275.6	94.4
Бусдын сууцанд түрээстэй	32.8	3.7	28.3	4.7	4.5	1.6
Бусдын сууцанд түрээсгүй	39.5	4.4	28.9	4.8	10.6	3.6
Бусад	2.5	0.3	2.1	0.3	0.4	0.1

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 74.8 мянган өрх, өөрийн гэсэн сууцгүй байгаа нь өмнөх тооллогынхоос 20 мянгаар буурсан боловч цаашид хүн амыг орон сууцжуулах төсөл хөтөлбөрийн эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Хотын өрхийн 9.8 хувь буюу 59.3 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаа нь Булган, Говь-Алтай, Дорноговь, Сүхбаатар аймгийн нийт өрхийн тоотой дүйцэхүйц хэмжээ юм. Өөрийн гэсэн сууцгүй өрхийн



тоо хөдөөд харьцангуй цөөн байгаа нь шинэ гэр бүл бологсад болон бусад шаардлагатай тохиолдолд шинээр гэр барьж орон сууцны асуудлыг шийддэг монгол уламжлалтай холбоотой гэж үзэж байна.

## 2.5. ОРОН СУУЦНЫ ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, АХУЙН НӨХЦӨЛ

Өрхийн цахилгааны хангамж. Төр засгаас төв суурин газрын айл өрхүүдийг төвлөрсөн системээс цахилгаанаар хангах арга хэмжээг улам нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүч, бага оврын цахилгааны үүсгүүр ашигладаг болсноор ард иргэдийн цахилгааны хангамж улам нэмэгдэж байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.

### ХҮСНЭГТ 2.16. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Цахилгааны эх үүсвэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Мян. өрх	Дүнд эзлэх хувь	Мян. өрх	Дүнд эзлэх хувь	Мян. өрх	Дүнд эзлэх хувь
<b>2010</b>						
Бүгд	713.8	100.0	479.5	100.0	234.3	100.0
Төвлөрсөн систем	548	76.8	456.1	95.1	91.9	39.2
Дизель станц	19.7	2.8	9.3	1.9	10.4	4.4
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	110.2	15.4	6.3	1.3	103.9	44.4
Бага оврын цахилгаан үүсгүүр	12.3	1.7	2.2	0.5	10.1	4.3
Цахилгааны эх үүсвэргүй	23.6	3.3	5.6	1.2	18.0	7.7
<b>2020</b>						
Бүгд	897.4	100.0	606.3	100.0	291.1	100.0
Төвлөрсөн систем	732.5	81.6	599.2	98.8	133.3	45.8
Дизель станц	0.4	0.1	0.2	0.0	0.3	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	152.0	16.9	4.6	0.8	147.4	50.6
Бага оврын цахилгаан үүсгүүр	7.7	0.9	1.0	0.2	6.6	2.3
Цахилгааны эх үүсвэргүй	4.8	0.5	1.3	0.2	3.5	1.2

Төвлөрсөн эх үүсвэрээс цахилгаанаар хангагддаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 4.8, хотын өрхийнх 3.7, хөдөөгийн өрхийнх 6.6 пунктээр тус тус өссөн байна. Харин дизель станцаас эрчим хүчээ авдаг өрхийн тоо улсын хэмжээнд буурсан бол, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаанаар хангагддаг өрхийн тоо нэмэгдсэн байна. Гэвч цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо өнгөрсөн тооллогын үеийнхээс 18.8 мянгаар буусан боловч хот суурин газарт 1.3 мянган өрх цахилгаангүй байсаар байна.

Төр засгаас ард иргэндээ цахилгаанаар хангах арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлсний үр дүнд ерөнхийдөө цахилгааны хангамж улсын хэмжээнд сайжирч байгаа боловч аймаг тус бүрд харилцан адилгүй байна.



## ХҮСНЭГТ 2.17. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	ӨРХИЙН ТОО- БҮГД	ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР			
		Үүсвэртэй	Хувь	Үүсвэргүй	Хувь
БҮГД	897 427	892 610	99.5	4 817	0.5
Архангай	27 055	26 714	98.7	341	1.3
Баян-Өлгий	24 327	24 217	99.5	110	0.5
Баянхонгор	25 570	25 348	99.1	222	0.9
Булган	18 481	18 268	98.8	213	1.2
Говь-Алтай	16 075	15 856	98.6	219	1.4
Дорноговь	20 115	20 014	99.5	101	0.5
Дорнод	23 378	23 174	99.1	204	0.9
Дундговь	14 212	14 107	99.3	105	0.7
Завхан	20 713	20 591	99.4	122	0.6
Өвөрхангай	33 062	32 826	99.3	236	0.7
Өмнөговь	21 106	20 820	98.6	286	1.4
Сүхбаатар	17 725	17 710	99.9	15	0.1
Сэлэнгэ	29 004	28 883	99.6	121	0.4
Төв	27 043	27 013	99.9	30	0.1
Увс	21 646	21 605	99.8	41	0.2
Ховд	22 513	22 089	98.1	424	1.9
Хөвсгөл	37 914	37 405	98.7	509	1.3
Хэнтий	23 906	23 534	98.4	372	1.6
Дархан-Уул	28 797	28 752	99.8	45	0.2
Орхон	28 386	28 377	100.0	9	-
Говьсүмбэр	4 979	4 933	99.1	46	0.9
Улаанбаатар	411 420	410 374	99.7	1 046	0.3

Улсын хэмжээнд цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 18.8 мянгаар буурсан сайн үзүүлэлт байна. Улсын хэмжээнд 4817 өрх цахилгааны эх үүсвэргүй байгаагийн дотор Улаанбаатар хот, Хэнтий, Хөвсгөл, Архангай аймгуудад цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо бусдаас олон байна.

**Өрхийн сууцны ахуйн нөхцөл.** Төрөөс иргэдийг орон сууцжуулахад ихээхэн анхаарч, зохих амжилт олж байгаагийн зэрэгцээгээр орон сууц, түүний инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, төвлөрсөн болон бие даасан ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламж, халуун ус, дулаан, цахилгааны шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон арга хэмжээнүүдийг боловсруулж, хэрэгжүүлсээр байна. Үе үеийн хүн ам, орон сууцны тооллогоор өрхийн ахуйн нөхцөлийг тухайн үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинтэй уялдуулан янз бүрийн хэлбэрээр судалсаар ирсэн. Тухайлбал: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийн ундны усны эх үүсвэр, хатуу хог хаягдал болон бохир усаа зайлуулах хэлбэр, бие засах газар зэрэг үзүүлэлтийг оруулсан. Харин хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор усан хангамж, халаалтын эх үүсвэр, бохир ус, хатуу хог хаягдал зайлуулалт, бие засах газрын төрлийг асуусан нь өмнөх тооллогын дүнтэй ерөнхий агуулгаараа ижил төстэй боловч доторх задаргаа асуултууд нь нэлээд ялгаатай байдлаар тодорхойлсон.

Хүн ам, орон сууцны сүүлийн хоёр тооллогын дүнгээс өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг сонгон нэгтгэж, өрх ахуйн нөхцөлөөр хир хангагдсан байдлыг тодорхойлохыг оролдсон болно. Үүнд:

**Ц-** Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан байдал. Үүнд: өрхийн цахилгааны



эх үүсвэрийн төрөл хэлбэрээс үл хамааран цахилгааны ямар нэг эх үүсвэртэй бол цахилгаанаар хангагдсан гэж үзсэн.

**У-** Усан хангамж. Үүнд: төвлөрсөн болон бие даасан усан хангамжийн системтэй өрхүүдийг хамруулсан. Ингэхдээ халуун, хүйтэн устай эсвэл зөвхөн хүйтэн устай эсэхийг харгалзаж үзээгүй

**Ж-** Бие засах газрын төрөл. Үүнд: бие засах газрын бохир зайлуулалт нь төвлөрсөн, бие даасан системд холбогдсон, битүү тунгаагуурт урсгадаг, энгийн нүхэн жорлонтой өрхүүдээс сайжруулсан болон био жорлонтой өрхүүдийг хамруулсан.

**Б-** Бохир ус зайлуулалт. Үүнд: бохир усаа төвлөрсөн болон бие даасан системтэй болон тусгай цооногт хуримтлуулж зайлуулдаг өрхүүдийг хамруулсан.

**Х-** Хатуу хог, хаягдал зайлуулалт. Үүнд: хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг, зөвшөөрөгдсөн цэгт хаядаг өрхүүдийг тус тус хамруулав. Эдгээр нь өмнөх тооллогынхтой ихэнхдээ тохирч байгаа боловч зарим нэг үзүүлэлт арай зөрүүтэйг анхаарах нь зүйтэй.

Өрхийг ахуйн нөхцөлийг хангасан байдлыг дараах 6 ангилал болгож үзэв. Үүнд:

- Ахуйн нөхцөл сайтай өрх (5 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг хангасан өрх (4 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг хагас хангасан өрх (3 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрх (2 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг муу хангасан өрх (1 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг хангаагүй өрх (Нэгч нөхцөл хангаагүй)

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын хуудасны асуултуудад өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийг хариулсан байдлаас доорх тодорхойлолтын шаардлагыг хангасан нөхцөлд ахуйн нөхцөлийн шаардлага хангасан гэж үзэж байгааг хэрэглэгчид тодорхой ойлгуулахын тулд дэлгэрэнгүй оруулав.

Ундны усны хангамж. Төвлөрсөн усан хангамж гэх ойлголтод ус олборлох, цэвэрлэх, дамжуулах, зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах системийг хамруулдаг.

Бие даасан системд холбогдсон усан хангамжид улсын болон орон нутгийн дулаан, ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр тухайн сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан бие даасан байдлаар ус олборлож хэрэглэж байгаа системийг бид мөн ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан гэж үзсэн.

Цахилгааны хангамж. Цахилгааны төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгэвэр зэрэг цахилгаан гаргах үүсвэрээс үл хамааран цахилгаан гэрэлтэй өрхийг цахилгаанаар хангагдсан гэж үзсэн.



Бие засах газрын хувьд өрхийн бие засах газрын бохир зайлуулах шугам нь төвлөрсөн системд холбогдсон гэдэгт бохирыг цуглуулан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий системд холбогдсон учир орчны ариун цэврийн болон хөрс, ус зэрэг байгаль орчинд хор нөлөөгүй гэж үзсэн.

Түүнчлэн бие засах газар нь төвлөрсөн системд холбогдоогүй ч гэсэн бохир усан дахь үл уусах хольц болон шимт бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах битүү тунгаагуур (Септник)-ыг мөн ариун цэвэр, орчны бохирдолд нөлөөгүй гэж үзсэн.

Био жорлон нь нүүрстөрөгчөөр баялаг материал (хүнсний ногооны хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсаар үнэргүй, гэм хоргүй, бордоо хийх хуурай бие засах газрыг орчин үеийн шинжлэх ухааны ололтыг ашиглан байгаль орчинд хор нөлөөгүй бие засах газар гэж үзсэн.

Сайжруулсан нүхэн жорлон гэдэгт дээвэртээ агааржуулах хоолой, эсвэл яндантай, хоолой болон яндангийн амсрыг ялаа орохоос хамгаалан тороор тагласан, гадаргын ус орохоос хамгаалж бүх талаас нь хаалт хийсэн жорлонг байгаль орчин ялангуяа хөрсний бохирдолд бусад энгийн нүхэн жорлонгоос арай бага хор нөлөөтэй гэж үзсэн.

**Бохир ус зайлуулалт.** Өрхийн бохир ус зайлуулах шугам нь улсын болон тухайн орон нутгийн бохир ус зайлуулах асуудал хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн байдлаар бохир ус зайлуулдаг шугамтай холбогдсон тул төв суурин газрын ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан гэж үзсэн.

Түүнчлэн тухайн орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан, орон нутгийн ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр бохир ус зайлуулах бага хэмжээний бие даасан систем нь (бохир, ялгадас саармагжуулах танк) орон сууцны орчны эрүүл ахуйн шаардлагад нийцсэн гэж үзсэн.

**Хатуу хог хаягдал зайлуулалт.** Өрх нь хатуу хог хаягдлаа улсын болон тухайн орон нутгийн албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл бусадтай (хог ачигчтай) гэрээ хийж, хог хаягдлыг зайлуулдаг тохиолдол нь орон сууцны тухайн орчны бохирдолд бага нөлөөтэй гэж үзэж ахуйн нөхцөл хангасан гэдэгт хамааруулав.

Албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллагын зааварчилгаагаар эсвэл албан зохицуулалтгүйгээр оршин суугчид хогоо нийтийн хогийн газар болон тодорхой төвлөрсөн цэгт зайлуулдаг тохиолдол буюу зөвшөөрөгдсөн цэгт хатуу хог хаядаг тохиолдол нь хогийг тодорхой давтамжтайгаар орон сууцны орчноос зайлуулдаг учир тухайн айл өрх, орон сууцны ариун цэвэр эрүүл ахуйд нийцэж байгаа гэж үзсэн.

Хүн ам, орон сууцны тооллогод дээрх таван нөхцөл бүгд хангагдсан өрхийг бид орон сууцны ахуйн нөхцөл сайтай өрх гэж үзсэн.





## ХҮСНЭГТ 2.18. СУУЦНЫ НӨХЦӨЛ САЙТАЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	УЦЖБХ	Хувь	Өрхийн тоо	УЦЖБХ	Хувь	Өрхийн тоо	УЦЖБХ	Хувь
БҮГД	897 427	263 024	29.3	606 282	253 332	41.8	291 145	9 692	3.3
Архангай	27 055	868	3.2	5 792	852	14.7	21 263	16	0.1
Баян-Өлгий	24 327	745	3.1	8 906	711	8.0	15 421	34	0.2
Баянхонгор	25 570	1 785	7.0	9 284	1 752	18.9	16 286	33	0.2
Булган	18 481	510	2.8	4 516	480	10.6	13 965	30	0.2
Говь-Алтай	16 075	1 374	8.5	5 325	1 356	25.5	10 750	18	0.2
Дорноговь	20 115	6 109	30.4	23 328	5 316	22.8	5 469	793	14.5
Дорнод	23 378	4 907	21.0	12 142	4 854	40.0	7 973	53	0.7
Дундговь	14 212	1 112	7.8	12 600	1 006	8.0	10 778	106	1.0
Завхан	20 713	719	3.5	3 726	687	18.4	10 486	32	0.3
Өвөрхангай	33 062	1 810	5.5	4 568	1 581	34.6	16 145	229	1.4
Өмнөговь	21 106	2 337	11.1	9 235	1 694	18.3	23 827	643	2.7
Сүхбаатар	17 725	2 299	13.0	8 200	2 129	26.0	12 906	170	1.3
Сэлэнгэ	29 004	4 930	17.0	5 177	2 218	42.8	12 548	2 712	21.6
Төв	27 043	2 044	7.6	9 858	1 721	17.5	19 146	323	1.7
Увс	21 646	1 351	6.2	4 711	1 345	28.6	22 332	6	0.0
Ховд	22 513	1 550	6.9	8 330	1 466	17.6	13 316	84	0.6
Хөвсгөл	37 914	816	2.2	7 960	788	9.9	14 553	28	0.2
Хэнтий	23 906	2 665	11.1	12 775	1 470	11.5	25 139	1 195	4.8
Дархан-Уул	28 797	15 443	53.6	8 231	13 247	160.9	15 675	2 196	14.0
Орхон	28 386	12 357	43.5	27 250	12 185	44.7	1 136	172	15.1
Говьсүмбэр	4 979	2 127	42.7	2 948	1 308	44.4	2 031	819	40.3
Улаанбаатар	411 420	195 166	47.4	411 420	195 166	47.4	-	-	-

Ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогынхоос улсын хэмжээгээр 2.6 пунктээр өссөний дотор Дархан-Уул 19.2, Сэлэнгэ 12.8, Улаанбаатар 6.7, Говьсүмбэр 5.5 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Гэвч олон аймагт энэ үзүүлэлт өнгөрсөн тооллогын үеийнхээс буурсны дотор Дундговь 12.3, Увс 10.2, Хэнтий 10.1, Өмнөговь 9.0 пунктээр буурсан нь бусад аймгаас илүү олон хувиар буурчээ. Энд анхаарах нэг асуудал бол хоёр тооллогын асуултын ялгаатай байдлаас хамаарч байж болох талтай. Тухайлбал: 2020 оны тооллогоор ердийн нүхэн жорлонтой өрхийг бохир зайлуулах орчин үеийн төхөөрөмжтэй гэж оруулаагүй (Өмнөх 2010 оны тооллогод ердийн нүхэн жорлонг өрх дангаараа ашигладаг бол ахуй нөхцөл хангасан үзүүлэлтэд оруулж байсан) нь өмнөх тооллогын үеийнхээс ахуй нөхцөл хангасан гэдэгт орж байсан нэг үзүүлэлт хасагдаж байгаа юм.

Сууцны ахуйн нөхцөлөөр хангагдах байдал нь хот суурин газарт амьдарч байгаа өрхүүд хөдөөгийн өрхүүдээс илүү байх нь зүй асуудал. Хот суурин үүний дотор нийслэл болон аймгийн төвүүдэд цэвэр, бохир ус зайлуулах төвлөрсөн системтэйн зэрэгцээгээр хатуу хог хаягдлыг төвлөрсөн журмаар тээвэрлэж зайлуулдаг зэрэг давуу талууд олонтой юм. Хотын нийт өрхөд ахуйн нөхцөл сайтай өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 5.2 пунктээр өссөний дотор Дорноговьд 25.8, Сэлэнгэд 19.9, Увс 11.5, Говьсүмбэрт 11.4, Завханд 11.1 пунктээр тус тус өссөн байна. Харин энэ үзүүлэлт олон аймагт буурсны дотор Дархан-Уулд 31.1, Хэнтийд 24.3, Төвд 17.5, Ховдод 13.4, Өмнөговь 11.4 пунктээр буурсан нь бусдаас илүү байна.





Өмнө дурдсан сууцны таван нөхцөлөөс аль нэгийг нь хангаагүй боловч бусад дөрвөн нөхцөлийг хангасан өрхийг ахуйн нөхцөл хангасан өрхөд хамруулсан.

## ХҮСНЭГТ 2.19. СУУЦНЫ НӨХЦӨЛ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Бүгд	4 нөхцөл хангаг дсан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангагд сан	Хувь	Бүгд	4 нөхцөл хангагд сан	Хувь
БҮГД	897 427	10 788	1.2	606 282	9 656	1.6	291 145	1 132	0.4
Архангай	27 055	121	0.4	5 792	106	1.8	21 263	15	0.1
Баян-Өлгий	24 327	420	1.7	8 906	288	3.2	15 421	132	0.9
Баянхонгор	25 570	80	0.3	9 284	67	0.7	16 286	13	0.1
Булган	18 481	68	0.4	4 516	44	1.0	13 965	24	0.2
Говь-Алтай	16 075	106	0.7	5 325	100	1.9	10 750	6	0.1
Дорноговь	20 115	395	2.0	23 328	308	1.3	5 469	87	1.6
Дорнод	23 378	423	1.8	12 142	404	3.3	7 973	19	0.2
Дундговь	14 212	80	0.6	12 600	44	0.3	10 778	36	0.3
Завхан	20 713	114	0.6	3 726	93	2.5	10 486	21	0.2
Өвөрхангай	33 062	132	0.4	4 568	63	1.4	16 145	69	0.4
Өмнөговь	21 106	320	1.5	9 235	158	1.7	23 827	162	0.7
Сүхбаатар	17 725	70	0.4	8 200	32	0.4	12 906	38	0.3
Сэлэнгэ	29 004	448	1.5	5 177	232	4.5	12 548	216	1.7
Төв	27 043	185	0.7	9 858	63	0.6	19 146	122	0.6
Увс	21 646	158	0.7	4 711	150	3.2	22 332	8	0.0
Ховд	22 513	324	1.4	8 330	298	3.6	13 316	26	0.2
Хөвсгөл	37 914	110	0.3	7 960	90	1.1	14 553	20	0.1
Хэнтий	23 906	153	0.6	12 775	112	0.9	25 139	41	0.2
Дархан-Уул	28 797	311	1.1	8 231	254	3.1	15 675	57	0.4
Орхон	28 386	215	0.8	27 250	215	0.8	1 136	-	-
Говьсүмбэр	4 979	78	1.6	2 948	58	2.0	2 031	20	1.0
Улаанбаатар	411 420	6 477	1.6	411 420	6 477	1.6	-	-	-

Сууцны ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс нэгээс бусад аймаг, нийслэлд буурсны дотор улсын хэмжээнд 17.7 пунктээр, аймгуудын дотроос Өмнөговь 33.2, Дундговь 27.0, Увс 23.9, Өвөрхангай 23.6, Увс 23.7, Говь-Алтай 20.5 пунктээр тус тус өссөн нь бусдаас илүү их буурсан байна. Харин энэ хувь зөвхөн Баян-Өлгийд 0.4 пунктээр өссөн аж. Энэ нь сууцны ахуйн нөхцөл сайтай өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс өссөн нь дараа дараагийн ахуйн нөхцөлүүдийг арай бага хангаж байгаа өрхийн нийт өрхөд эзлэх хувь буурах үндэслэл болох талтай.

Хотын нийт өрхөд орон сууцны дөрвөн нөхцөл хангасан өрхийн эзлэх хувь улсын хэмжээнд 1,6. хувь байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс пунктээр 21.4 пунктээр буурсны дотор Өмнөговь 51.6, Дундговь 40.3, Увс 32.7, Ховд 32.0 тус тус буурсан нь бусдаас өндөр байна.

Өмнө дурдсан сууцны таван нөхцөлөөс хоёр нөхцөл хангаагүй боловч бусад гурван нөхцөлийг хангасан өрхийг ахуйн нөхцөл хагас хангасан өрхөд хамруулсан.



**ХҮСНЭГТ 2.20. СУУЦНЫ НӨХЦӨЛ ХАГАС ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Бүгд	3 нөхцөл хангагд- сан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангагд- сан	Хувь	Бүгд	3 нөхцөл хангагд- сан	Хувь
БҮГД	897 427	20 727	2.3	606 282	16 850	2.8	291 145	3 877	1.3
Архангай	27 055	207	0.8	5 792	123	2.1	21 263	84	0.4
Баян-Өлгий	24 327	1 238	5.1	8 906	744	8.4	15 421	494	3.2
Баянхонгор	25 570	205	0.8	9 284	101	1.1	16 286	104	0.6
Булган	18 481	281	1.5	4 516	136	3.0	13 965	145	1.0
Говь-Алтай	16 075	131	0.8	5 325	84	1.6	10 750	47	0.4
Дорноговь	20 115	545	2.7	23 328	461	2.0	5 469	84	1.5
Дорнод	23 378	277	1.2	12 142	181	1.5	7 973	96	1.2
Дундговь	14 212	135	0.9	12 600	59	0.5	10 778	76	0.7
Завхан	20 713	259	1.3	3 726	127	3.4	10 486	132	1.3
Өвөрхангай	33 062	271	0.8	4 568	115	2.5	16 145	156	1.0
Өмнөговь	21 106	619	2.9	9 235	324	3.5	23 827	295	1.2
Сүхбаатар	17 725	82	0.5	8 200	60	0.7	12 906	22	0.2
Сэлэнгэ	29 004	1 627	5.6	5 177	600	11.6	12 548	1 027	8.2
Төв	27 043	480	1.8	9 858	100	1.0	19 146	380	2.0
Увс	21 646	319	1.5	4 711	274	5.8	22 332	45	0.2
Ховд	22 513	459	2.0	8 330	259	3.1	13 316	200	1.5
Хөвсгөл	37 914	406	1.1	7 960	230	2.9	14 553	176	1.2
Хэнтий	23 906	369	1.5	12 775	203	1.6	25 139	166	0.7
Дархан-Уул	28 797	578	2.0	8 231	468	5.7	15 675	110	0.7
Орхон	28 386	98	0.3	27 250	65	0.2	1 136	33	2.9
Говьсүмбэр	4 979	65	1.3	2 948	65	2.2	2 031	-	-
Улаанбаатар	411 420	384	0.1	411 420	379	0.1	-	5	-

Сууцны ахуйн гурван нөхцөл хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үед аймаг, нийслэлд жигдэвтэр дийлэнх нь 20-иос дээш хувь нь хангасан байсан аж. Гэтэл энэ үзүүлэлт 2020 оны тооллогын дүнгээр өмнөхөөсөө ихээхэн өөр болсон нь анхаарал татаж байна. Энэ нь өмнөх тооллогын үед ахуйн нөхцөл хангасан үзүүлэлтэд гэр хорооллын нүхэн жорлонг дангаараа ашигладаг бол ахуйн нөхцөл хангасан үзүүлэлтэд оруулдаг байсантай холбоотой гэж үзэж байна.

Нийт өрхөд ахуйн гурван нөхцөл хангасан өрхийн эзлэх хувь улсын дүнгээр 27.7 пунктээр үүний дотор 30 хувиас дээш хувиар буурсан аймаг тав байна. Бусад аймаг, нийслэлээс Баян-Өлгий аймаг 5.6 хувь буурсан нь хамгийн бага нь юм. Бусад аймаг 20-иос дээш хувиар буурсан аж. Хотын нийт өрхөд ахуйн гурван нөхцөл хангасан өрхийн эзлэх хувь улсын дүнгээр 30.4 пунктээр буурсны дотор 40-өөс дээш пунктээр буурсан аймаг 6 байна.

Өрхийн сууцны нөхцөлийг дутуу хангасан гэсэн ойлголтыг бид сонгосон таван нөхцөлөөс хоёр нөхцөлийг хангасан өрхүүдийг хамруулж байгаа юм.



## ХҮСНЭГТ 2.21. СУУЦНЫ НӨХЦӨЛ ДУТУУ ХАНГАГДСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	2 нөхцөл хангагдсан	Хувь
БҮГД	897 427	450 408	50.2	606 282	317 555	52.4	291 145	132 853	45.6
Архангай	27 055	10 269	38.0	5 792	4 495	77.6	21 263	5 774	27.2
Баян-Өлгий	24 327	13 548	55.7	8 906	6 888	77.3	15 421	6 660	43.2
Баянхонгор	25 570	11 632	45.5	9 284	7 082	76.3	16 286	4 550	27.9
Булган	18 481	10 533	57.0	4 516	3 440	76.2	13 965	7 093	50.8
Говь-Алтай	16 075	7 606	47.3	5 325	3 560	66.9	10 750	4 046	37.6
Дорноговь	20 115	8 863	44.1	12 142	5 845	48.1	5 469	3 018	55.2
Дорнод	23 378	13 362	57.2	12 600	6 880	54.6	7 973	6 482	81.3
Дундговь	14 212	7 138	50.2	3 726	2 610	70.0	10 778	4 528	42.0
Завхан	20 713	12 434	60.0	4 568	3 591	78.6	10 486	8 843	84.3
Өвөрхангай	33 062	17 671	53.4	9 235	7 412	80.3	16 145	10 259	63.5
Өмнөговь	21 106	12 855	60.9	8 200	5 901	72.0	23 827	6 954	29.2
Сүхбаатар	17 725	8 349	47.1	5 177	2 906	56.1	12 906	5 443	42.2
Сэлэнгэ	29 004	18 214	62.8	9 858	6 001	60.9	12 548	12 213	97.3
Төв	27 043	16 324	60.4	4 711	2 780	59.0	19 146	13 544	70.7
Увс	21 646	11 273	52.1	8 330	6 267	75.2	22 332	5 006	22.4
Ховд	22 513	11 624	51.6	7 960	5 709	71.7	13 316	5 915	44.4
Хөвсгөл	37 914	22 218	58.6	12 775	10 857	85.0	14 553	11 361	78.1
Хэнтий	23 906	13 513	56.5	8 231	5 633	68.4	25 139	7 880	31.3
Дархан-Уул	28 797	10 794	37.5	23 328	8 568	36.7	15 675	2 226	14.2
Орхон	28 386	15 025	52.9	27 250	14 430	53.0	1 136	595	52.4
Говьсүмбэр	4 979	1 930	38.8	2 948	1 467	49.8	2 031	463	22.8
Улаанбаатар	411 420	195 233	47.5	411 420	195 233	47.5	-	-	-

Улсын хэмжээний нийт өрхийн 50.2 хувь нь сууцны ахуйн нөхцөлийн сонгосон 5 шалгуураас зөвхөн хоёрыг хангасан байна. Үүний дотор 14 аймаг улсын дунджаас дээгүүр 50 түүнээс дээш хувиар хангасан байна. Хотын өрхийн 52.4 хувь нь хоёр нөхцөл хангасан байхад улсын дунджаас нэлээд өндөр 70 түүнээс дээш хувиар хангасан 8 аймаг байна.

Өрхийн сууцны сонгосон 5 нөхцөлөөс хоёрыг хангасан аймгууд бараг бүхэлдээ цахилгаан гэрэлтэй, хатуу хог хаягдлыг тогтоосон цэгт асгаж, зайлуулдаг үзүүлэлтийг хангасан байна.

Сууцны нөхцөл муу хангагдсан өрхөд сонгосон таван нөхцөлөөс зөвхөн нэг нөхцөлийг хангасан өрхийг хамруулсан.



## ХҮСНЭГТ 2.22. СУУЦНЫ НӨХЦӨЛ МУУ ХАНГАГДСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь	Бүгд	Нэг нөхцөл хангагдсан	Хувь
БҮГД	897 427	149 178	16.6	606 282	8 608	1.4	291 145	140 570	48.3
Архангай	27 055	15 302	56.6	5 792	198	3.4	21 263	15 104	71.0
Баян-Өлгий	24 327	8 282	34.0	8 906	274	3.1	15 421	8 008	51.9
Баянхонгор	25 570	11 665	45.6	9 284	282	3.0	16 286	11 383	69.9
Булган	18 481	6 930	37.5	4 516	400	8.9	13 965	6 530	46.8
Говь-Алтай	16 075	6 657	41.4	5 325	213	4.0	10 750	6 444	59.9
Дорноговь	20 115	4 117	20.5	12 142	204	1.7	7 973	3 913	49.1
Дорнод	23 378	4 253	18.2	12 600	281	2.2	10 778	3 972	36.9
Дундговь	14 212	5 656	39.8	3 726	6	0.2	10 486	5 650	53.9
Завхан	20 713	7 094	34.2	4 568	69	1.5	16 145	7 025	43.5
Өвөрхангай	33 062	12 975	39.2	9 235	63	0.7	23 827	12 912	54.2
Өмнөговь	21 106	4 726	22.4	8 200	119	1.5	12 906	4 607	35.7
Сүхбаатар	17 725	6 912	39.0	5 177	50	1.0	12 548	6 862	54.7
Сэлэнгэ	29 004	3 703	12.8	9 858	799	8.1	19 146	2 904	15.2
Төв	27 043	7 995	29.6	4 711	47	1.0	22 332	7 948	35.6
Увс	21 646	8 514	39.3	8 330	290	3.5	13 316	8 224	61.8
Ховд	22 513	8 195	36.4	7 960	227	2.9	14 553	7 968	54.8
Хөвсгөл	37 914	13 923	36.7	12 775	775	6.1	25 139	13 148	52.3
Хэнтий	23 906	6 890	28.8	8 231	794	9.6	15 675	6 096	38.9
Дархан-Уул	28 797	1 640	5.7	23 328	782	3.4	5 469	858	15.7
Орхон	28 386	398	1.4	27 250	41	0.2	1 136	357	31.4
Говьсүмбэр	4 979	704	14.1	2 948	47	1.6	2 031	657	32.3
Улаанбаатар	411 420	2 647	0.6	411 420	2 647	0.6	-	-	-

Өрхийн ахуй нөхцөлийн сонгосон таван шалгуураас зөвхөн нэгийг хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 16.6 хувь байгаа нь улсын чанартай том хотууд Дархан, Эрдэнэт, нийслэлд энэ хувь бага байгаатай холбоотой. Харин аймгуудад энэ үзүүлэлт нэлээд өндөр байна. Нийт өрхөд ахуйн нэг үзүүлэлт хангасан өрхийн эзлэх хувь 30 түүнээс дээш байгаа аймаг 12 байна. Хотын өрхүүдийн хувьд арай өөр, илүү бага хувийг эзэлж байгаа нь төв суурин газарт амьдардаг өрхүүд бараг бүхэлдээ цахилгаан гэрэлтэй байгаатай холбоотой.

Өрхийн ахуйн нөхцөлийн таван шалгуураас нэгийг ч хангаагүй өрх нь үндсэндээ цахилгаан гэрэлгүй өрх гэж үзэж болох юм. Учир нь дээр тэмдэглэсэнчлэн зөвхөн нэг нөхцөлийг хангасан өрх бүхэлдээ цахилгаан гэрлээс өөр нөхцөл хангагдаагүй өрхүүд байсан билээ.




## ХҮСНЭГТ 2.23. СУУЦНЫ НӨХЦӨЛ ОГТ ХАНГАГДААГҮЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Бүгд	Ахуйн нөхцөл хангаг даагүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангагда агүй	Хувь	Бүгд	Ахуйн нөхцөл хангагда агүй	Хувь
БҮГД	897 427	3 302	0.4	606 282	281	0.0	291 145	3 021	1.0
Архангай	27 055	288	1.1	5 792	18	0.3	21 263	270	1.3
Баян-Өлгий	24 327	94	0.4	8 906	1	0.0	15 421	93	0.6
Баянхонгор	25 570	203	0.8	9 284	-	-	16 286	203	1.2
Булган	18 481	159	0.9	4 516	16	0.4	13 965	143	1.0
Говь-Алтай	16 075	201	1.3	5 325	12	0.2	10 750	189	1.8
Дорноговь	20 115	86	0.4	12 142	8	0.1	7 973	78	1.0
Дорнод	23 378	156	0.7	12 600	-	-	10 778	156	1.4
Дундговь	14 212	91	0.6	3 726	1	0.0	10 486	90	0.9
Завхан	20 713	93	0.4	4 568	1	0.0	16 145	92	0.6
Өвөрхангай	33 062	203	0.6	9 235	1	0.0	23 827	202	0.8
Өмнөговь	21 106	249	1.2	8 200	4	0.0	12 906	245	1.9
Сүхбаатар	17 725	13	0.1	5 177	-	-	12 548	13	0.1
Сэлэнгэ	29 004	82	0.3	9 858	8	0.1	19 146	74	0.4
Төв	27 043	15	0.1	4 711	-	-	22 332	15	0.1
Увс	21 646	31	0.1	8 330	4	0.0	13 316	27	0.2
Ховд	22 513	361	1.6	7 960	1	0.0	14 553	360	2.5
Хөвсгөл	37 914	441	1.2	12 775	35	0.3	25 139	406	1.6
Хэнтий	23 906	316	1.3	8 231	19	0.2	15 675	297	1.9
Дархан-Уул	28 797	31	0.1	23 328	9	0.0	5 469	22	0.4
Орхон	28 386	7	0.0	27 250	-	-	1 136	7	0.6
Говьсүмбэр	4 979	42	0.8	2 948	3	0.1	2 031	39	1.9
Улаанбаатар	411 420	140	0.0	411 420	140	0.0	-	-	-

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр сууцны ахуйн сонгосон :нөхцөлөөс нэгийг ч хангаагүй өрх улсын хэмжээнд 11.7 мянга байсан бол 2020 онд 3.3 мянга болж, 8.4 мянгаар буурсан байна. Эдгээр өрхийн тоо улсын хэмжээний нийт өрхийн 0.4 хувийг эзэлж байгаагийн дотор бусдаас хамгийн өндөр хувийг Архангай, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд эзэлж байна.

## ЗУРАГ 2.10. СУУЦНЫ АХУЙН НӨХЦӨЛ ХАНГАСАН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН





Сууцны ахуйн нөхцөлийг сонгосон таван үзүүлэлтээс үзэхэд 2020 онд нэлээд дэвшил гарсан гэж үзэж болохоор байна. Сууцны нөхцөл нэг буюу хоёр эсвэл огт хангаагүй өрхийн тоо үндсэндээ хөдөө орон нутагт байгаа нь харагдаж байна. Хөдөө мал аж ахуй эрхэлж байгаа өрхүүдийн хувьд цахилгааны эх үүсвэртэй байхад бусад нөхцөлийг тэр бүр хангаад байх шаардлага бага юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс үзэхэд өрхүүдийн цахилгааны хангамж, өмнөх тооллогын үеийнхээс нэлээд сайжирсан нь өрхүүдийн ахуй нөхцөлөөр хангагдсан байдлыг нэмэгдүүлэхэд нэг чухал нөхцөл болсон байна. Харин 2020 оны тооллогоор өрхийн ахуй нөхцөлийн үүний дотор бохир ус, бие газрын бохирыг зайлуулах хэлбэрүүдийг өмнөх тооллогын үеийнхээс нэлээд олон үзүүлэлтээр нарийвчлан тодорхойлсон.

Энэ нь хөрс, ус, агаарын чанар, эрүүл ахуй, орчны бохирдолд өрхүүдийн бие газрын болон бохир ус, хатуу хог хаягдал хир нөлөөлж байгааг тодорхойлох, цаашид энэ талын төр засгийн бодлого хөтөлбөр боловсруулахад үндэслэл болохуйц мэдээлэл бүрдсэн гэж үзэж байна.



# ГУРАВДУГААР БҮЛЭГ

**БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН  
ТОО, АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ**



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод байшин гэж нэг, болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байрыг хамруулсан. Байшинд бие даасан тохилог сууц (хаус), сууцны тусдаа байшин (гэр хорооллын хашаанд болон бусад газар барьсан тоосгон, шавар болон модон ханатай сууцны байшин), нийтийн болон нийтийн зориулалтын бусад байрыг энд хамааруулсан. Байшин түүний төрлийн талаарх тодорхойлолтыг энэ судалгааны ойлголт тодорхойлолт болон нэгдүгээр бүлэгт тодорхой тусгасан тул энд давхардуулаагүй.

### ХҮСНЭГТ 3.1. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН


Аймаг, нийслэл	Бүгд	Сууцны төрлөөр			
		Нийтийн зориулалттай орон сууцны байшин дотрох сууц	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр
Бүгд	546 979	264 316	6 440	267 923	8 300
Архангай	7 761	884	34	6 755	88
Баян-Өлгий	23 258	469	292	22 444	53
Баянхонгор	5 375	1 947	50	3 341	37
Булган	8 770	532	33	8 097	108
Говь-Алтай	3 064	1 257	79	1 561	167
Дархан-Уул	24 794	15 005	408	9 051	330
Дорноговь	11 583	5 614	207	5 220	542
Дорнод	14 748	5 163	106	8 689	790
Дундговь	3 026	906	187	1 755	178
Завхан	6 880	786	102	5 887	105
Өвөрхангай	9 998	1 678	157	8 056	107
Өмнөговь	5 396	1 890	267	2 967	272
Сүхбаатар	6 275	1 718	508	3 866	183
Сэлэнгэ	22 034	4 456	523	16 779	276
Төв	10 618	1 632	313	8 163	510
Увс	4 313	1 347	85	2 842	39
Ховд	6 279	1 823	80	4 248	128
Хөвсгөл	19 334	983	135	18 040	176
Хэнтий	8 696	2 731	81	5 558	326
Орхон	23 812	12 070	426	11 135	181
Говьсүмбэр	3 021	2 088	41	810	82
Улаанбаатар	317 944	199 337	2 326	112 659	3 622

Сүүлийн жилүүдэд айл өрхүүд төв суурин газар төдийгүй хөдөө орон нутагт байшинд амьдрах сонирхол улам нэмэгдэж байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр байшинд 547.0 мянган өрх амьдарч байгаа нь нийт өрхийн 60.9 хувь нь юм. Энэ нь өмнөх тооллогын үеийнхээс 7.3 пунктээр, үүний дотор нийтийн орон сууцны байшин суудаг өрх 8.1, бие даасан тохилог сууцанд суудаг өрх 0.2, сууцны тусдаа байшинд суудаг өрх 0.3 пунктээр тус тус өссөн байна. Байшинд амьдардаг өрхүүдийн сууцны төрөл, байршлаар нэлээд ялгаатай байна. (Хавсралт-4)





### ЗУРАГ 3.1. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ,ХУВИАР, 2020 ОН



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор сууцны өмчийн хэлбэрийг өмнөх тооллогынхтой ижил ангиллаар тодорхойлсон.

### ХҮСНЭГТ 3.2. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ӨМЧИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Байршил	БҮГД	ӨРХИЙН ТОО, ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР			БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ		
		Иргэний	Хувийн ААНБ-ЫН	Төрийн	Иргэний	Хувийн ААНБ-ЫН	Төрийн
БҮГД	546 979	537 568	3 855	5 556	98.3	0.7	1.0
Хот	451 538	445 938	2 246	3 454	98.7	0.5	0.8
Хөдөө	95 341	91 630	1 609	2 102	96.1	1.7	2.2

Байшинд амьдардаг өрхийн нэг хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа нь орон сууцыг хувьчлах үйл явц үндсэндээ дуусаж байгааг харуулж байна. Гэвч өмчлөлийн хэлбэр эзэмшлийн хэлбэр нэлээд ялгаатайг дээр тэмдэглэсэн.

### ХҮСНЭГТ 3.3. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Байршил	БҮГД	ӨРХИЙН ТОО, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭРЭЭР				БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ			
		Өөрийн	Бусдын сууцанд түрээстэй	Бусдын сууцанд түрээсгүй	Бусад	Өөрийн	Бусдын сууцанд түрээстэй	Бусдын сууцанд түрээсгүй	Бусад
БҮГД	546 979	491 128	26 514	27 574	1 763	89.8	4.8	5.0	0.3
Хот	451 538	405 477	23 272	21 392	1 497	89.8	5.2	4.7	0.3
Хөдөө	95 341	85 651	3 242	6 182	266	89.8	3.4	6.5	0.3



Байшинд амьдардаг өрхийн дотор улсын хэмжээнд 55.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаа нь 10 өрх тутмын нэг нь өөрийн гэсэн сууцгүй байна гэсэн үг юм. Иймээс ялангуяа төв суурин газарт орон сууцжуулах төсөл хөтөлбөрийн улам эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

### ХҮСНЭГТ 3.4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР			
		Өөрийн	Бусдын сууцанд түрээстэй	Бусдын сууцанд түрээсгүй	Бусад
БҮГД	100.0	89.8	4.8	5.0	0.3
Архангай	100.0	96.9	0.9	2.0	0.1
Баян-Өлгий	100.0	94.1	1.5	4.3	0.1
Баянхонгор	100.0	96.1	1.4	1.9	0.7
Булган	100.0	92.9	2.1	4.9	0.1
Говь-Алтай	100.0	92.9	3.3	3.7	0.2
Дорноговь	100.0	79.8	9.1	10.7	0.4
Дорнод	100.0	81.3	5.4	12.9	0.5
Дундговь	100.0	88.2	6.3	5.1	0.4
Завхан	100.0	95.8	1.3	2.8	0.1
Өвөрхангай	100.0	95.9	2.1	1.9	0.1
Өмнөговь	100.0	85.3	3.7	10.2	0.9
Сүхбаатар	100.0	88.8	2.8	8.3	0.1
Сэлэнгэ	100.0	89.0	3.7	7.1	0.2
Төв	100.0	88.6	3.8	7.3	0.3
Увс	100.0	94.5	2.2	3.0	0.3
Ховд	100.0	93.9	2.2	3.8	0.2
Хөвсгөл	100.0	92.6	1.8	5.5	0.1
Хэнтий	100.0	87.0	4.7	8.1	0.2
Дархан-Уул	100.0	87.1	4.3	8.3	0.4
Орхон	100.0	89.8	4.5	5.6	0.1
Говьсүмбэр	100.0	76.5	8.0	13.0	2.5
Улаанбаатар	100.0	89.8	5.8	4.0	0.4

Аймаг, нийслэлийн нийт өрхийн дотор өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 90-дээш хувьтай аймаг, нийслэлийн тоо бүх аймгийн дөнгөж тал хувь нь юм. Аймгийн нийт өрхөд өөрийн эзэмшлийн сууцгүй өрхийн эзлэх хувь Дорноговь, Говьсүмбэрт хамгийн бага байна. Өөрийн эзэмшлийн сууцгүй өрхийн тоо Улаанбаатарт 32399, Дархан-Уулд 3209, Дорнодод 2765, Орхонд 2423, Дорноговьд 2336 байгаа нь бусдаас олон байгаа бол Баянхонгорт 211, Говь-Алтайд 218, Архангайд 237, Увсад 239 байгаа нь бусдаас цөөн байна.

Хүн ам, орон сууцны 1969 оны тооллогоос хойш үе үеийн тооллогуудад байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээг ам бүлийн тоотой нь харьцуулан судалсаар ирсэн. Тооллогуудын дүнгээс үзэхэд манай орны байшинд амьдардаг өрхийн талбайн хэмжээ нэмэгдэж, түүний хирээр амьдрах орчин нөхцөл сайжирсаар байгаа нь харагдаж байна.



### ХҮСНЭГТ 3.5. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	БҮГД		СУУЦНЫ ТАЛБАЙ, КВАДРАТ МЕТР					
	Мян. Өрх	Бүгдэд эзлэх хувь	20 хүртэл		21-40		41+	
			мян. өрх	эзлэх хувь	мян. өрх	эзлэх хувь	мян. өрх	эзлэх хувь
2010								
БҮГД	378.2	100.0	50.4	13.3	151.3	40.0	176.5	46.7
1-2	95.0	100.0	19.1	20.1	39.7	41.8	36.2	38.1
3-4	180.6	100.0	22.7	12.5	72.6	40.2	85.3	47.3
5-6	82.8	100.0	7.2	8.7	31.4	37.9	44.2	53.4
7+	19.8	100.0	1.5	7.5	7.4	37.6	10.9	54.9
2020								
БҮГД	546.6	100.0	46.4	8.5	133.1	24.4	367.1	67.1
1-2	160.6	100.0	16.5	10.2	42.8	26.6	101.3	63.1
3-4	213.2	100.0	17.3	8.1	50.9	23.9	145.0	68.0
5-6	132.2	100.0	9.8	7.4	29.9	22.6	92.6	70.0
7+	40.6	100.0	2.8	7.1	9.6	23.6	28.2	69.4

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнг 2010 оныхтой харьцуулахад 20 хүртэл Кв.м талбайтай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 4.8 пунктээр буурч, харин 40-өөс дээш Кв.м талбайтай сууцанд амьдардаг өрхийнх 20.4 пунктээр өссөн байна. Мөн түүнчлэн манай улсын өрхийн дундаж ам бүл 3-4 байдаг. Сууцны талбай нь 40-өөс дээш Кв.м талбайтай сууцанд амьдардаг 3-4 ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 20.7 пунктээр өссөн байна.

### ХҮСНЭГТ 3.6. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД				ХОТ			
	БҮГД	СУУЦНЫ ТАЛБАЙ, КВ.М			БҮГД	СУУЦНЫ ТАЛБАЙ, КВ.М		
		20 хүртэл	21-40	40-өөс дээш		20 хүртэл	21-40	40-өөс дээш
БҮГД	100.0	8.5	24.4	67.1	100.0	8.3	23.4	68.3
Архангай	100.0	8.6	23.9	67.6	100.0	6.8	22.7	70.5
Баян-Өлгий	100.0	4.5	18.2	77.3	100.0	1.2	7.6	91.2
Баянхонгор	100.0	10.7	20.6	68.7	100.0	9.6	20.4	70.1
Булган	100.0	9.3	35.0	55.7	100.0	7.2	30.8	62.1
Говь-Алтай	100.0	7.3	29.7	62.9	100.0	5.6	28.4	65.9
Дорноговь	100.0	11.8	45.2	42.9	100.0	12.6	44.5	42.8
Дорнод	100.0	9.3	22.3	68.4	100.0	5.1	19.8	75.1
Дундговь	100.0	8.0	17.8	74.2	100.0	7.3	16.3	76.4
Завхан	100.0	9.9	11.4	78.7	100.0	7.3	11.7	81.0
Өвөрхангай	100.0	9.2	22.8	68.0	100.0	7.2	16.0	76.9
Өмнөговь	100.0	4.7	25.5	69.8	100.0	3.9	21.4	74.7
Сүхбаатар	100.0	5.9	28.2	65.9	100.0	5.2	27.9	66.9
Сэлэнгэ	100.0	7.1	27.5	65.4	100.0	7.4	19.2	73.3
Төв	100.0	8.5	13.5	78.0	100.0	8.1	9.0	82.9
Увс	100.0	9.8	19.5	70.8	100.0	7.8	15.9	76.3
Ховд	100.0	11.6	27.3	61.1	100.0	8.4	22.1	69.5
Хөвсгөл	100.0	15.6	36.5	47.9	100.0	14.8	35.3	49.8
Хэнтий	100.0	6.7	26.6	66.7	100.0	6.9	25.8	67.3
Дархан-Уул	100.0	8.2	29.1	62.7	100.0	7.7	25.2	67.2
Орхон	100.0	7.8	22.3	70.0	100.0	7.8	22.2	70.0
Говьсүмбэр	100.0	4.8	23.2	72.0	100.0	5.4	25.4	69.3
Улаанбаатар	100.0	8.7	23.3	68.0	100.0	8.7	23.3	68.0

Манай улсын байшинд амьдардаг өрхийн 67.1 хувь нь 40-өөс дээш Кв.м талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх г тооллогын үеийнхээс 20.4 пунктээр



өссөний дотор Дорнод 42.8, Өвөрхангай 36.9, Төв 35.2 пунктээр өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байхад Дорноговь 7.3, Өвөрхангай 1.5, Хөвсгөл 0.1 пунктээр өссөн нь хамгийн бага өсөлттэй байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр байшинд амьдардаг нийт өрхөд 40-өөс дээш Кв.м талбайтай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь улсын дунджаас нэлээд өндөр 70 түүнээс дээш хувьтай аймаг 5 байна. Харин байшинд амьдардаг хотын нийт өрхөд 40-өөс дээш Кв.м талбайтай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь улсын дунджаас нэлээд өндөр 70 түүнээс дээш хувьтай аймаг 12 байгаа нь хотын өрхүүд илүү том талбайтай сууцанд амьдардаг болохыг харуулж байна.

### ХҮСНЭГТ 3.7 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	БҮГД	ӨРӨӨНИЙ ТОО					
		1	2	3	4	5-7	8+
2010							
БҮГД	100.0	33.6	39.5	18.9	5.5	2.1	0.4
1-2	100.0	43.5	37.0	14.5	3.5	1.2	0.3
3-4	100.0	32.8	40.8	18.9	5.2	1.9	0.4
5-6	100.0	26.5	40.0	22.4	7.5	3.0	0.6
7+	100.0	23.5	38.4	24.9	8.5	3.9	0.8
2020							
БҮГД	100.0	28.6	43.5	20.4	5.3	1.9	0.2
1-2	100.0	37.6	41.3	15.8	3.8	1.3	0.1
3-4	100.0	28.6	45.7	19.2	4.6	1.7	0.2
5-6	100.0	24.0	42.8	23.8	6.8	2.4	0.3
7+	100.0	23.4	40.9	25.1	7.2	2.9	0.4

Байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээ, ам бүлийн тооны харьцаа нь хүн амын амьдрах таатай нөхцөл хир бүрдсэн байгааг харуулах нэг гол үзүүлэлт билээ. Манай орны хувьд энэ үзүүлэлт тийм ч таатай бус байгааг тооллогыг дүн харуулав. Байшинд амьдардаг нийт өрхийн 72.1 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогынхтой харьцуулахад дөнгөж нэг пунктээр буурсан аж.

Тус улсын өрхийн ам бүлийн дундаж болох 3-4 ам бүлтэй өрхийн 74.3 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 0.7 пунктээр өссөн нь чамлалттай үзүүлэлт юм. Гэтэл 7 түүнээс дээш ам бүлтэй өрхийн 64.3 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогынхоос 2.4 пунктээр өссөн нь хангалттай өсөлт биш юм.

### БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор байшинд амьдардаг өрхийн цахилгааны хангамжийн үзүүлэлтийг өмнөх тооллогынхтой ижлээр нэлээд дэлгэрэнгүй тодорхойлсон.

Ингэхдээ тухайн өрхийн цахилгааны эх үүсвэрээс үл хамааран цахилгаан гэрэлтэй бол цахилгаанаар хангагдсан гэж үзэв.



### ХҮСНЭГТ 3.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ, 2010, 2020 ОН

Цахилгааны эх үүсвэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	Мян.өрх	Дүнд эзлэх хувь
2010						
<b>Бүгд</b>	<b>382.8</b>	<b>100.0</b>	<b>315.8</b>	<b>100.0</b>	<b>67.0</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	358.3	93.6	310.4	98.3	47.9	71.5
Дизель станц	7.0	1.8	3.8	1.2	3.3	4.9
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	13.5	3.5	0.6	0.2	12.9	19.3
Бага оврын цахилгаан үүсгүүр	2.0	0.5	0.6	0.2	1.3	2.0
Цахилгааны эх үүсвэргүй	2.0	0.5	0.8	0.2	1.3	1.9
2020						
<b>Бүгд</b>	<b>547.0</b>	<b>100.0</b>	<b>451.6</b>	<b>100.0</b>	<b>95.4</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	528.8	96.7	450.4	99.7	78.4	82.3
Дизель станц	0.3	0.0	0.2	0.0	0.1	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	16.8	3.1	0.7	0.2	16.1	16.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	0.8	0.1	0.2	0.0	0.6	0.6
Цахилгааны эх үүсвэргүй	0.3	0.1	0.3	0.0	0.0	0.1

Байшинд амьдардаг өрхүүд үндсэндээ цахилгаанаар хангагдсан байна. Цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 0.4 пунктээр буурч, хөдөөгийн өрхийн 0.1 хувь нь цахилгаангүй байна.

Байшинд амьдардаг өрхийн цахилгааны хангамж өнгөрсөн тооллогын үеийнхээс нэлээд нэмэгдсэн боловч аймаг, нийслэл, байршлаар ангилж үзэхэд анхаарах зарим зүйл байна.

### ХҮСНЭГТ 3.9. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНААР ХАНГАГДСАН БАЙДАЛ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД		ЦАХИЛГААНТАЙ		ЦАХИЛГААНГҮЙ	
	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь
БҮГД	546 979	100.0	546 676	99.9	303	0.1
Архангай	7 761	100.0	7 761	100.0	-	-
Баян-Өлгий	23 258	100.0	23 233	99.9	25	0.1
Баянхонгор	5 375	100.0	5 375	100.0	-	-
Булган	8 770	100.0	8 769	100.0	1	0.0
Говь-Алтай	3 064	100.0	3 064	100.0	-	-
Дорноговь	11 583	100.0	11 583	100.0	-	-
Дорнод	14 748	100.0	14 727	99.9	21	0.1
Дундговь	3 026	100.0	3 026	100.0	-	-
Завхан	6 880	100.0	6 880	100.0	-	-
Өвөрхангай	9 998	100.0	9 995	100.0	3	0.0
Өмнөговь	5 396	100.0	5 396	100.0	-	-
Сүхбаатар	6 275	100.0	6 273	100.0	2	0.0
Сэлэнгэ	22 034	100.0	22 034	100.0	-	-
Төв	10 618	100.0	10 617	100.0	1	0.0
Увс	4 313	100.0	4 312	100.0	1	0.0
Ховд	6 279	100.0	6 279	100.0	-	-
Хөвсгөл	19 334	100.0	19 333	100.0	1	0.0
Хэнтий	8 696	100.0	8 685	99.9	11	0.1
Дархан-Уул	24 794	100.0	24 792	100.0	2	0.0
Орхон	23 812	100.0	23 812	100.0	-	-
Говьсүмбэр	3 021	100.0	3 021	100.0	-	-
Улаанбаатар	317 944	100.0	317 709	99.9	235	0.1



Байшинд амьдардаг өрхүүдээс нийслэлд 235, Баян-Өлгий, Дорнод, Хэнтий аймгуудад цөөн өрхүүд цахилгаангүй байгаа боловч үндсэндээ цахилгаанаар хангагдсан байна.

### **БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ДУЛААНЫ ХАНГАМЖ.**

Хүйтний улирал урт байдаг манай орны хувьд сууцны дулаан хангамжийн асуудал гэр бүлийн гишүүдийн тав тухтай, эрүүл амьдрах нэг чухал нөхцөл болдог билээ. Байшинд амьдардаг өрхийн 49.6 хувь төвлөрсөн халаалтын системд, үүний дотор хотын өрхийн 57.6 хувь холбогдсон нь өмнөх тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 5.7 пунктээр, хотод 5.9 пунктээр тус тус өссөн байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод өмнөх тооллогоос өрхийн дулаан хангамжийн үзүүлэлтийг өргөжүүлж, газрын гүний, шатдаг хийн халаагуураар дулаанаа хангадаг өрхийг тодорхойлсон боловч маш цөөн өрхүүд байгаа учир энд тусгайлан оруулаагүй болно. Улсын хэмжээнд газрын гүний дулаанаар хангадаг өрх 41, шатдаг хийгээр дулаанаа хангадаг өрх 51 байгаа юм.

### **ХҮСНЭГТ 3.10. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Халаалтын төрөл	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн систем	43.9	51.6	7.2	49.6	57.5	12.2
Нам даралтын зуух	5.3	5.6	3.6	7.1	7.3	6.2
Цахилгаан хаагуур	0.6	0.7	0.5	2.0	2.3	0.6
Ердийн галлагаа	50.2	42.1	88.7	41.3	32.9	81.0

Аймаг, нийслэлийн байшинд амьдардаг өрхийн дулаан хангамжийн төрөлд сүүлийн хорин жилд ихээхэн өөрчлөлт гарчээ. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнг 2000 оныхтой зэрэгцүүлэхэд Архангай аймгийн байшинд амьдардаг өрхөөс 2000 онд төвлөрсөн системээс дулаанаа авдаг өрх байхгүй байсан бол 2010 онд бүх өрхийн 9.7 хувь, Баянхонгор аймгийн 32.9 хувь нь төвлөрсөн системээс дулаанаа авдаг болж ихээхэн дэвшил гарч байжээ.

Мөн 2000 оны тооллогын үед төвлөрсөн халаалтын системд холбогдсон өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жингээр хамгийн доогуур хувьтай байсан Баян-Өлгий, Хөвсгөл аймгуудад нэлээд ахиц гарч байжээ. Мөн Төв аймагт төвлөрсөн системээс дулаанаа аваг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 20.0 хувь болж өмнөхөөсөө 6.3 дахин нэмэгдэж байсан нь өмнөх тооллогыг үеийн оргил өсөлт байсан аж. Түүнчлэн Завхан аймгийн байшинд амьдардаг нийт өрхийн 15.5 хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон нь өмнөх тооллогын үеэс 2.3 дахин өсөж байжээ.

Хүн ам, орон сууцны сүүлийн хоёр тооллогын хооронд ч аймаг, нийслэлийн байшинд суудаг өрхийн дулаан хангамжийн эх үүсвэр нэлээд өөрчлөлт гарсан байна.



### ХҮСНЭГТ 3.11. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ХАЛАЛТЫН ТӨРӨЛ			
		Төвлөрсөн систем	Нам даралтын зуух	Цахилгаан халаагуур	Ердийн галлагаа
БҮГД	100.0	49.7	7.1	2.0	41.3
Архангай	100.0	10.7	7.4	0.2	81.7
Баян-Өлгий	100.0	3.4	9.0	0.2	87.4
Баянхонгор	100.0	36.9	11.9	0.8	50.4
Булган	100.0	6.6	2.4	0.6	90.5
Говь-Алтай	100.0	49.5	11.2	0.8	38.4
Дорноговь	100.0	56.0	8.4	1.2	34.4
Дорнод	100.0	36.5	5.7	0.2	57.5
Дундговь	100.0	40.6	10.0	1.9	47.6
Завхан	100.0	14.1	6.7	0.5	78.7
Өвөрхангай	100.0	19.9	8.8	0.5	70.8
Өмнөговь	100.0	45.6	20.7	2.1	31.6
Сүхбаатар	100.0	38.5	7.2	0.7	53.6
Сэлэнгэ	100.1	25.6	5.1	0.5	68.7
Төв	100.0	23.5	8.8	0.9	66.7
Увс	100.0	35.9	12.8	0.2	51.0
Ховд	100.0	28.9	14.7	0.8	55.5
Хөвсгөл	100.5	5.8	4.4	0.3	89.4
Хэнтий	100.0	33.3	6.0	0.9	59.7
Дархан-Уул	100.0	63.6	3.1	0.4	32.9
Орхон	100.0	52.9	4.6	0.7	41.8
Говьсүмбэр	100.0	73.6	5.4	0.1	20.9
Улаанбаатар	100.0	62.5	7.2	3.0	27.2

Байшинд амьдардаг өрхийн халаалтын эх үүсвэр өнгөрсөн тооллогын үеийнхээс нэлээд ахиц гарсан гэж үзэж болохоор байна. Ялангуяа төвлөрсөн системээс халаалтаа авдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 19.5 пунктээр өссөний дотор Дорноговь 11.5, Сүхбаатар тус бүр 13.0 пунктээр өссөн байна. Төвлөрсөн системээс халаалтаа авдаг өрхийн тоо өсөхийн хирээр төв суурин газрын ердийн галлагаатай өрхийн нийт өрхөд эзлэх хувь буурч байна. Ердийн галлагаатай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 22.4 пунктээр буурсны дотор Өмнөговь 22.4, Сүхбаатар 12.8, Увс 10.9, Ховд 10.1 пунктээр буусан байна.

#### **БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ.**

Өрхийн усан хангамж, үүний дотор шаардлага хангасан ундны усаар хангахад төвлөрсөн усан хангамжийн системд айл өрхийг аль болох олноор холбох зэрэг нь хүн амын эрүүл мэнд аюулгүй орчинд амьдрах нэг чухал нөхцөлүүдийн нэг билээ.





Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнг 2000 оныхтой зэрэгцүүлэхэд байшинд амьдардаг нийт өрхөөс халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 1.1 пунктээр буурч байсан байна. Энэ нь иргэд хувиараа байшин барьж суух нь олширч, төвлөрсөн системд холбогдсон халуун, хүйтэн устай тохилог сууцанд орогчдоос илүү байсныг харуулж байсан аж. Харин хөдөөд халуун хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеэс 2 дахин нэмэгдэж байжээ.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнг 2010 оныхтой зэрэгцүүлэхэд дээр өгүүлснээс арай өөр дүр зураг харагдаж байна.

### ХҮСНЭГТ 3.12. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Усан хангамжийн төрөл	БҮГД	ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ			
		Нийтийн зориулалтай орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтин байр
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	49.1	95.7	86.0	2.7	34.6
Халуун хүйтэн устай	92.1	94.4	68.0	42.0	61.6
Зөвхөн хүйтэн устай	7.9	5.6	32.0	58.0	38.4
Бие даасан систем	1.5	0.7	13.9	1.9	3.3
Халуун хүйтэн устай	48.9	69.8	66.9	38.7	48.9
Зөвхөн хүйтэн устай	51.1	30.2	33.1	61.3	51.1
Зөөврийн	49.4	3.7	0.1	95.4	62.0

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 6.3 пунктээр өссөний дотор халуун, хүйтэн устай сууцанд амьдрагчдын хувь 6.8 пунктээр өссөн бол зөөврийн усан хангамжтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 7.4 пунктээр буурсан байна.

Усан хангамжийн систем аймаг, нийслэлд нэлээд ялгаатай байгаа нь тэдгээрийн орон сууцжуулах төсөл хөтөлбөр, төвлөрсөн ус хангамжийн системд айл өрхийг холбох арга хэмжээтэй уялдан өөр өөр байна.(Хавсралт-5)





### ХҮСНЭГТ 3.13 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Бүгд	Төвлөрсөн систем	Үүнээс:		Бие даасан систем	Үүнээс:		Зөөврийн
			Халуун, хүйтэн устай	Зөвхөн хүйтэн устай		Халуун, хүйтэн устай	Зөвхөн хүйтэн устай	
Бүгд	100.0	49.1	92.1	7.9	1.5	48.9	51.1	49.4
Архангай	100.0	12.5	33.8	66.2	0.5	35.0	65.0	86.9
Баян-Өлгий	100.0	4.5	58.2	41.8	4.2	30.3	69.7	91.3
Баянхонгор	100.0	34.3	11.1	88.9	0.6	48.4	51.6	65.2
Булган	100.0	6.5	27.2	72.8	1.0	15.3	84.7	92.6
Говь-Алтай	100.0	46.6	11.7	88.3	1.3	43.6	56.4	52.1
Дорноговь	100.0	56.2	31.1	68.9	0.7	44.9	55.1	43.1
Дорнод	100.0	35.8	99.0	1.0	0.4	44.2	55.8	63.8
Дундговь	100.0	38.9	8.4	91.6	0.8	43.5	56.5	60.3
Завхан	100.0	12.0	21.4	78.6	0.5	54.8	45.2	87.5
Өвөрхангай	100.0	18.6	54.6	45.4	0.9	44.9	55.1	80.5
Өмнөговь	100.0	50.6	35.2	64.8	2.8	39.9	60.1	46.6
Сүхбаатар	100.0	37.8	67.3	32.7	0.3	52.6	47.4	61.9
Сэлэнгэ	100.0	24.5	75.4	24.6	4.7	18.5	81.5	70.8
Төв	100.0	20.5	71.2	28.8	1.0	59.5	40.5	78.4
Увс	100.0	32.4	86.1	13.9	1.3	35.7	64.3	66.3
Ховд	100.0	26.2	94.1	5.9	3.4	20.4	79.6	70.3
Хөвсгөл	100.0	4.8	28.6	71.4	0.3	69.8	30.2	94.9
Хэнтий	100.0	31.7	75.4	24.6	0.7	58.3	41.7	67.6
Дархан-Уул	100.0	61.9	94.3	5.7	1.3	5.2	94.8	36.8
Орхон	100.0	52.3	95.4	4.6	0.1	60.7	39.3	47.6
Говьсүмбэр	100.0	71.2	84.8	15.2	1.0	62.1	37.9	27.9
Улаанбаатар	100.0	63.0	97.7	1.4	0.6	159.0	86.2	36.4

Байшинд амьдардаг өрхийн ус хангамж өнгөрсөн тооллогын үеийнхээс нэлээд сайжирсны дотор нийт өрхөд төвлөрсөн усан хангамжийн системд хамрагдсан өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 20.3 пунктээр өссөний дотор Дорноговь 12.5, Өмнөговь 17.0, Сүхбаатар 14.6 пунктээр өссөн нь бусдаас өндөр өсөлттэй байна. Харин зөөврийн усан хангамжтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 21.4 пунктээр буурсны дотор Дорноговь 13.0, Өмнөговь 18.0, Сүхбаатар 14.2, Улаанбаатар 8.8, Говьсүмбэр 7.8, Увс 7.0 пунктээр буурсан нь бусдаас илүү бууралттай байна.

Зөөврийн усан хангамжтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд улсын дунджаар 49.4 хувь байхад Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд улсын дунджаас бараг хоёр дахин өндөр байна. Харин Дорноговь, Өмнөговь, Орхон, Говьсүмбэр аймгууд улсын дунджаас доогуур байгаа юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өмнөх тооллогуудад нарийвчлан тодорхойлж байгаа нэг үзүүлэлт бол өрхийн усан хангамжийн эх үүсвэр юм. Үүнд: байшинд амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн болон бие даасан системд холбогдсон бол байшин доторх, үүнээс бусад эх үүсвэрийг байшингийн



гаднах эх үүсвэр гэж үзсэн. Энэ нь ундны усны чанар хүний эрүүл ахуйд хэрхэн нөлөөлж байгаа судлахад ач холбогдолтой чухал үзүүлэлтүүд юм.

Байшинд амьдардаг өрхийн байшингийн гаднах ундны усны эх үүсвэр нь ихэнхдээ сууцны тусдаа байшинд хамаарч байна. Энэ үзүүлэлтийн цөөхөн хувь нь нийтийн байранд хамааралтай юм.

### ХҮСНЭГТ 3.14. БАЙШИНГИЙН ГАДНАХ УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРТЭЙ ӨРХИЙН ТОО, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Байшингийн гаднах ундны усны эх үүсвэр	БАЙШИНГИЙН ГАДНАХ УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРТЭЙ ӨРХ			
	БҮГД	Дүнд эзлэх хувь	Орон сууцны тусдаа байшин	Дүнд эзлэх хувь
БҮГД	284 221	100.0	262 684	100.0
Хамгаалагдсан гүний худаг	163 413	57.5	155 592	59.2
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийтийн ус түгээх байр	38 709	13.6	37 199	14.2
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр	26 393	9.3	25 969	9.9
Хамгаалагдсан гар худаг	17 959	6.3	17 762	6.8
Хамгаалагдсан булаг, шанд	574	0.2	566	0.2
Хамгаалагдаагүй гүний худаг	1 967	0.7	1 954	0.7
Хамгаалагдаагүй гар худаг	2 001	0.7	1 919	0.7
Хамгаалагдаагүй булаг, шанд	631	0.2	628	0.2
Зөөврийн усны үйлчилгээ	8 700	3.1	8 594	3.3
Ердийн хөсгөөрх зөөврийн ус	851	0.3	844	0.3
Савласан ус	11 454	4.0	141	0.1
Хурын ус	24	0.0	24	0.0
Усны ил эх үүсвэр (гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм)	11 097	3.9	11 070	4.2
Бусад	448	0.2	422	0.2

Байшинд амьдардаг ундны усны эх үүсвэр нь байшингийн гадна байдаг өрхийн дийлэнхийнх нь ундны усны эх үүсвэр нь хамгаалагдсан гүний худаг байгаа нь үндсэндээ ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан эх үүсвэртэй байна гэж үзэж болох юм.

НҮБ-ын хүн ам, орон сууцны тооллоготой холбогдох зарчим, зөвлөмжид тооллого явуулж буй орнууд зөөврийн усаар хангагдаг өрх усаа хир зайнаас зөөдгийг тодорхойлж байхыг зөвлөмж болгосон байдаг. Энэ зөвлөмжийн хүрээнд хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор байшинд амьдардаг зөөврөөр усаа авдаг өрхийн тоо, усаа хир зайнаас зөөдгийг тодорхойлсон.

Тооллогын дүнгээр байшинд амьдардаг нийт өрхийн 31.9, хотын өрхийн 55.4, хөдөөгийн өрхийн 43.1 хувь нь тус тус 200 метр хүртэлх, нийт өрхийн 30 орчим хувь нь 200-500 метр зайнаас усаа зөөдөг аж. Харин 1000 метрээс хол зайнаас нийт өрхийн 4.3, хотын өрхийн 2.1, хөдөөгийн өрхийн 8.9 хувь нь усаа зөөдөг байна.



### ХҮСНЭГТ 3.14а. БАЙШИНД АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, УНДНЫ УСАА ЗӨӨДӨГ ЗАЙ, БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийсэлэл	БҮГД	УС АВДАГ ЗАЙ, МЕТРЭЭР			
		200 хүртэл	200-500	500-1000	1000+
БҮГД	100.0	43.1	30.2	17.8	8.9
Архангай	100.0	29.2	42.3	21.9	6.7
Баян-Өлгий	100.0	65.4	13.7	8.1	12.8
Баянхонгор	100.0	32.0	35.4	24.0	8.6
Булган	100.0	35.2	38.1	17.8	8.9
Говь-Алтай	100.0	28.6	42.9	17.9	10.7
Дорноговь	100.0	50.7	29.4	13.5	6.4
Дорнод	100.0	16.2	25.2	36.2	22.4
Дундговь	100.0	34.6	41.1	20.3	4.0
Завхан	100.0	23.2	33.5	30.6	12.7
Өвөрхангай	100.0	25.0	35.9	27.4	11.7
Өмнөговь	100.0	21.4	36.6	25.2	16.8
Сүхбаатар	100.0	66.6	23.0	9.1	1.3
Сэлэнгэ	100.0	30.2	37.1	21.6	11.1
Төв	100.0	30.8	40.7	23.1	5.5
Увс	100.0	57.1	27.7	10.8	4.4
Ховд	100.0	33.4	33.1	22.8	10.7
Хөвсгөл	100.0	38.4	35.0	19.7	6.9
Хэнтий	100.0	63.6	23.9	11.1	1.5
Дархан-Уул	100.0	35.3	20.0	24.7	20.0
Орхон	100.0	92.9	4.8	2.4	0.0
Говьсүмбэр	100.0	12.9	38.7	32.3	16.1

Байшинд амьдардаг хөдөөгийн өрхүүдээс 1000 метрээс хол зайнаас усаа зөөдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дорнод, Даран-Уул, Баян-Өлгий, Өмнөговь, Завхан аймгуудад хамгийн өндөр байна.

### БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ДЭД БҮТЭЦ

**Бие засах газар.** Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод байшинд амьдардаг өрхийн бие засах газрын төрлийг өмнөх тооллогуудаас ихээхэн нарийвчлан тодорхойлсон тул ихэнх үзүүлэлтийг харьцуулах боломжгүй юм. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр байшинд амьдардаг өрхийн 50.1 хувь нь сууц дотроо, үлдсэн хувь нь сууцны гадна бие засах газартай байсан аж.

### ХҮСНЭГТ 3.15. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРЛӨӨР, БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Байршил	БҮГД	БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ						
		Төвлөрсөн системд холбогдсон	Зориулалтын цооногт	Нүхэн жорлонд урсгадаг	Сайжруулсан нүхэн жорлон	Энгийн нүхэн жорлон	Био жорлон	Задгай
Өрхийн тоо								
<b>Бүгд</b>	<b>546 979</b>	<b>271 870</b>	<b>5 859</b>	<b>2 537</b>	<b>3 439</b>	<b>259 360</b>	<b>591</b>	<b>3 323</b>
Хот	451 638	261 901	4 933	1 459	2 322	180 134	530	359
Хөдөө	95 341	9 969	926	1 078	1 117	79 226	61	2 964
Бүгд дүнд эзлэх хувь								
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>49.7</b>	<b>1.1</b>	<b>0.5</b>	<b>0.6</b>	<b>47.4</b>	<b>0.1</b>	<b>0.6</b>
Хот	100.0	58.0	1.1	0.3	0.5	39.9	0.1	0.1
Хөдөө	100.0	10.5	1.0	1.1	1.2	83.1	0.1	3.1



Байшинд амьдардаг нийт өрхийн 48 хувь буюу 262.7 мянган өрх, хотын өрхийн 40 хувь буюу 180.5 мянган өрх энгийн нүхэн жорлон ашиглах болон ил задгай бие засаж байгаа нь төв суурин газрын хөрсний бохирдолд сөрөг нөлөөтэйг анхаарч, төр захиргааны байгууллагууд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, энгийн нүхэн жорлон ашигладаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жинг бууруулах, ил задгай бие засдаг өрхийн тоог арилгах шаардлагатай юм.

### **ХҮСНЭГТ 3.16. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРЛӨӨР, БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД	БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРЛӨӨР						
		Төвлөрсөн шугам систем	Цооногт	Нүхэн жорлонд урсгадаг	Сайжруулсан нүхэн жорлон	Энгийн нүхэн жорлон	Био жорлон	Задгай
БҮГД	100.0	49.7	1.1	0.5	0.6	47.4	0.1	0.6
Архангай	100.0	11.7	0.5	0.3	0.8	85.5	0.2	1.0
Баян-Өлгий	100.0	2.7	1.6	0.8	1.6	86.8	0.0	6.5
Баянхонгор	100.0	33.5	1.0	0.5	0.7	62.4	0.1	1.8
Булган	100.0	6.5	0.5	0.2	0.9	90.7	0.2	1.0
Говь-Алтай	100.0	46.5	0.7	2.0	1.7	46.9	0.1	2.2
Дорноговь	100.0	53.2	2.4	0.5	1.3	41.8	0.2	0.6
Дорнод	100.0	33.6	0.3	0.6	0.3	64.9	0.1	0.2
Дундговь	100.0	35.9	2.5	0.6	2.3	57.3	0.0	1.4
Завхан	100.0	11.0	1.1	0.8	0.8	83.6	0.0	2.5
Өвөрхангай	100.0	18.6	1.2	0.6	1.0	77.4	0.1	1.2
Өмнөговь	100.0	41.9	6.5	1.6	3.4	46.0	0.0	0.6
Сүхбаатар	100.0	36.7	0.7	0.1	0.5	60.2	0.0	1.8
Сэлэнгэ	100.0	21.5	2.2	1.1	0.3	74.3	0.0	0.5
Төв	100.0	19.3	0.9	1.8	1.1	75.6	0.1	1.1
Увс	100.0	32.6	3.1	3.5	1.5	58.3	0.0	1.0
Ховд	100.0	27.0	1.2	0.9	0.9	67.2	0.3	2.5
Хөвсгөл	100.0	4.5	0.5	0.6	1.3	92.0	0.0	1.1
Хэнтий	100.0	31.6	0.6	2.0	0.4	64.9	0.1	0.4
Дархан-Уул	100.0	63.0	0.8	0.7	0.2	35.2	0.0	0.1
Орхон	100.0	52.0	0.8	0.6	0.5	45.9	0.1	0.1
Говьсүмбэр	100.0	72.2	1.3	0.3	0.7	25.2	0.0	0.3
Улаанбаатар	100.0	64.0	0.9	0.2	0.4	34.3	0.1	0.1

Байшинд амьдардаг өрхүүдийн бие засах газрыг орчны бохирдол, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангах зорилгоор төв суурин газарт сүүлийн үед сайжруулсан нүхэн, био жорлон болон тусгай цооногт жорлонгийн бохирыг хуримтлуулж, цэвэрлэх зэрэг орчин үеийн арга нэвтрүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловч түүний явц удаан ялангуяа орон нутагт энгийн нүхэн жорлон түлхүү ашигласан хэвээр байна. Бие засах тусгай цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд аймгуудад бусдаас илүү өндөр байгааг эдгээр аймгийн төр захиргааны байгууллагууд анхаарах шаардлагатай юм.

Хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг харуулах нэг гол үзүүлэлт нь өрхийн сууцны онгоц, шүршүүрийн өрөө түүний ашиглалтын үзүүлэлт билээ. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр байшинд амьдардаг нийт өрхийн 46.4 хувь нь онгоц шүршүүртэй байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 5.8 пунктээр нэмэгджээ. Энэ үзүүлэлт хотод 6.9, хөдөөд 5.2 пунктээр тус тус өсжээ.



**Хатуу хог хаягдал зайлуулалт.** Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлого зохицуулалтаар ангилан ялгаж, тогтсон газар цуглуулах, дахин боловсруулах, энэ чиглэлд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хатуу хог хаягдлыг өрхүүд өөрсдөө ангилж сурах хэвшлийг буй болгох нь байгаль орчны бохирдлыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүн нь энэ талын бодлого хөтөл боловсруулахад үндэслэл болохуйц мэдээллийг бүрдүүлсэн болно.

**ХҮСНЭГТ 3.17. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Байршил	БҮГД	ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР				
		Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Шатаадаг	Булдаг	Тогтсон цэггүй
Өрхийн тоо						
БҮГД	546 979	456 545	63 968	2 581	343	13 542
Хот	451 638	431 833	18 249	259	149	1 148
Хөдөө	95 341	34 712	45 719	2 322	194	12 394
Бүгд дүнд эзлэх хувь						
БҮГД	100.0	85.3	11.7	0.5	0.1	2.5
Хот	100.0	95.6	4.0	0.1	0.0	0.3
Хөдөө	100.0	36.4	48.0	2.4	0.2	13.0

Байшинд амьдардаг нийт өрхийн 3.1 хувь буюу 16.5 мянган өрх хатуу хог хаягдлаа шатаадаг, булдаг эсвэл тогтсон цэг байхгүй хаа дуртай газарт хаядаг нь аль аль нь байгаль орчин, агаарын бохирдолд сөрөг нөлөөтэйг анхаарах нь зүйтэй байна.

**ХҮСНЭГТ 3.18. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД	ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР				
		Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Шатаадаг	Булдаг	Тогтсон цэг байхгүй
БҮГД	100.0	85.3	11.7	0.5	0.1	2.5
Архангай	100.0	66.5	25.3	1.4	0.1	6.7
Баян-Өлгий	100.0	31.1	34.8	2.0	0.6	31.5
Баянхонгор	100.0	89.6	7.2	0.4	0.1	2.7
Булган	100.0	46.8	42.0	1.7	0.1	9.3
Говь-Алтай	100.0	49.2	48.1	0.8	0.0	1.9
Дорноговь	100.0	75.3	22.3	0.9	0.2	1.3
Дорнод	100.0	79.2	19.5	0.9	0.0	0.4
Дундговь	100.0	63.5	32.3	0.5	0.0	3.7
Завхан	100.0	53.0	44.2	0.9	0.0	1.9
Өвөрхангай	100.0	83.0	13.9	0.2	0.1	2.7
Өмнөговь	100.0	80.9	15.5	0.7	0.3	2.7
Сүхбаатар	100.0	73.7	25.7	0.5	0.0	0.1
Сэлэнгэ	100.0	56.0	39.6	1.6	0.1	2.7
Төв	100.0	55.4	43.3	1.0	0.1	0.2
Увс	100.0	53.7	44.0	0.7	0.1	1.5
Ховд	100.0	44.0	48.2	1.7	0.1	6.0
Хөвсгөл	100.0	59.2	27.1	3.1	0.2	10.5
Хэнтий	100.0	66.2	32.3	1.4	0.0	0.1
Дархан-Уул	100.0	90.4	6.8	0.2	0.1	2.5
Орхон	100.0	98.8	1.0	0.1	0.0	0.1
Говьсүмбэр	100.0	81.7	18.1	0.2	0.0	0.0
Улаанбаатар	100.0	98.0	2.0	0.0	0.0	0.0



Аймгуудаас хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгийд бусад аймгаас хэд дахин өндөр байгаа нь анхаарал татаж байна. Энэ аймгийн төр захиргааны байгууллагаас өөрийн аймгийн байшинд амьдардаг төв суурин газрын өрхүүдийн хатуу хог хаягдлыг зайлуулах орчин үеийн арга хэлбэрийг нэвтрүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Байшинд амьдардаг өрхийн хатуу хог хаягдал зайлуулалт аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр ялгаатай байна (Хавсралт 6,7)

**Бохир ус зайлуулалт.** Өрхийн бохир ус зайлуулах хэлбэрээс хамаарч орчны бохирдол ялангуяа хөрс, усны ундаргад хэрхэн нөлөөлөх төлөв байдлыг илэрхийлж болох юм. Ялангуяа орон сууцын тусдаа байшинд амьдардаг өрхийн дийлэнх хувь нь бохир усаа цооногт эсвэл ил задгай асгадаг байна.

### ХҮСНЭГТ 3.19. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР, БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Байршил	БҮГД	БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР			
		Төвлөрсөн систем	Бие даасан систем	Цооног	Задгай
Өрхийн тоо					
БҮГД	546 979	265 344	5 635	252 958	23 042
Хот	451 638	255 467	4 538	186 603	5 030
Хөдөө	95 341	9 877	12 097	66 355	18 012
Бүгд дүнд эзлэх хувь					
БҮГД	100.0	48.5	1.0	46.2	1.2
Хот	100.0	56.6	1.0	41.3	1.1
Хөдөө	100.0	10.4	1.2	69.6	18.9

Байшинд амьдардаг өрхийн талаас илүү хувь нь буюу 276 мянган өрх үүний дотор хотын 191.6 мян.өрх бохир усаа цооногт буюу ил задгай асгаж байгаа нь хөрс, гадаргын усыг бохирдуулах, элдэв халдвар тараах нөхцөлийг бүрдүүлж байгааг анхаарч, бохир ус зайлуулах орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.



### ХҮСНЭГТ 3.20. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР, БҮГД ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР			
		Төвлөрсөн систем	Бие даасан систем	Цооног	Задгай
БҮГД	100.0	48.5	1.0	46.2	4.2
Архангай	100.0	12.3	0.6	64.7	22.4
Баян-Өлгий	100.0	3.3	2.1	56.5	38.1
Баянхонгор	100.0	34.4	0.8	61.7	3.2
Булган	100.0	6.3	0.4	79.2	14.1
Говь-Алтай	100.0	45.2	2.5	49.6	2.8
Дорноговь	100.0	53.5	2.0	34.3	10.2
Дорнод	100.0	35.6	0.3	61.2	2.8
Дундговь	100.0	36.6	2.7	56.7	4.0
Завхан	100.0	11.7	0.6	83.9	3.8
Өвөрхангай	100.0	18.5	0.9	75.0	5.6
Өмнөговь	100.0	41.6	6.1	49.2	3.1
Сүхбаатар	100.0	36.8	0.6	61.9	0.7
Сэлэнгэ	100.0	21.6	2.6	69.4	6.3
Төв	100.0	19.7	1.3	76.9	2.1
Увс	100.0	32.9	1.9	56.4	8.8
Ховд	100.0	27.7	1.2	60.4	10.6
Хөвсгөл	100.0	4.9	0.3	80.4	14.4
Хэнтий	100.0	31.5	0.6	66.0	1.8
Дархан-Уул	100.0	62.7	0.6	30.6	6.1
Орхон	100.0	52.1	0.6	46.9	0.5
Говьсүмбэр	100.0	71.0	1.5	26.8	0.7
Улаанбаатар	100.0	61.7	0.9	37.1	0.3

Аймгуудаас бохир усаа ил задгай асгадаг өрхүүдийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий аймагт бусдаас хэт өндөр байна. Энэ аймгийн байшинд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдлаа ил задгай хаядаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь бусдаас хэд дахин өндөр байсан, бас бохир усаа ил задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь мөн бусад аймгаас хэт өндөр байгаа нь энэ аймгийн байшинд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь бусад аймгаас илүү байдгийг өмнөх бүлэгт тэмдэглэж байсанчлан тус аймагт хот суурин газраас гадна хөдөөгийн малчин өрхүүд байшинд олноороо амьдардагтай холбоотой байж болох юм. Байшинд амьдардаг өрхийн бохир ус зайлуулалт аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр ялгаатай байна (Хавсралт 8,9)

#### Байшинд амьдардаг өрхийн ахуй нөхцөлөөр хангагдсан байдал

Хүн ам, орон сууцны сүүлийн хоёр тооллогын дүнгээс өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг сонгон нэгтгэж, өрх ахуйн нөхцөлөөр хир хангагдсан байдлыг тодорхойлохыг оролдсоныг өмнөх бүлэгт тэмдэглэсэн. Байшинд амьдардаг өрхийг мөн ижил төстэй аргаар тодорхойлсон. Үүнд:

**Ц-** Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан байдал. Үүнд: өрхийн цахилгааны эх үүсвэрийн төрөл хэлбэрээс үл хамааран цахилгааны ямар нэг эх үүсвэртэй бол цахилгаанаар хангагдсан гэж үзсэн.

**У-** Усан хангамж. Үүнд: төвлөрсөн болон бие даасан усан хангамжийн системтэй өрхүүдийг хамруулсан. Ингэхдээ халуун, хүйтэн устай эсвэл зөвхөн хүйтэн устай эсэхийг харгалзаж үзээгүй.

**Ж-** Бие засах газрын төрөл. Үүнд: бие засах газрын бохир зайлуулалт нь төвлөрсөн системд холбогдсон, битүү тунгаагуурт урсгадаг, энгийн нүхэн жорлонтой өрхүүдээс сайжруулсан болон био жорлонтой өрхүүдийг хамруулсан





**Б-Бохир ус зайлуулалт.** Үүнд: бохир усаа төвлөрсөн болон бие даасан системтэй болон тусгай цооногтой өрхүүдийг хамруулсан.

**Х- Хатуу хог, хаягдал зайлуулалт.** Үүнд: хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг, зөвшөөрөгдсөн цэгт хаядаг өрхүүдийг тус тус хамруулав. Эдгээр нь өмнөх тооллогынхтой ихэнхдээ тохирч байгаа боловч зарим нэг үзүүлэлт арай зөрүүтэйг анхаарах нь зүйтэй.

Байшинд амьдардаг өрхийг ахуйн нөхцөлийг хангасан байдлыг дараах 6 ангилал болгож үзэв. Үүнд:

- Ахуйн нөхцөл сайтай өрх (5 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг хангасан өрх (4 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг хагас хангасан өрх (3 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг дутуу хангасан өрх (2 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг муу хангасан өрх (1 нөхцөл хангагдсан)
- Ахуйн нөхцөлийг хангаагүй өрх (Нэг ч нөхцөл хангаагүй)

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын хуудасны асуултуудад өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийг хариулсан байдлаас зохих тодорхойлолтын шаардлагыг хангасан нөхцөлд ахуйн нөхцөлийн шаардлага хангасан гэж үзэж байгаа юм. Үзүүлэлт тус бүрийн тодорхойлолтыг өмнөх нэгдүгээр бүлгээс үзнэ үү.

Ахуйн нөхцөл сайтай хотын өрхөд сонгосон таван нөхцөл бүгдийг хангасан өрхийг хамруулж байгаа билээ.

### **ХҮСНЭГТ 3.21. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ САЙТАЙ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	УЦЖБХ	Хувь	Өрхийн тоо	УЦЖБХ	Хувь	Өрхийн тоо	УЦЖБХ	Хувь
Бүгд	546 979	262 305	48.0	451 638	252 672	55.9	95 341	9 633	10.1
Архангай	7 761	858	11.1	4 079	842	20.6	3 682	16	0.4
Баян-Өлгий	23 258	743	3.2	8 719	710	8.1	14 539	33	0.2
Баянхонгор	5 375	1 766	32.9	3 808	1 735	45.6	1 567	31	2.0
Булган	8 770	495	5.6	3 759	468	12.5	5 011	27	0.5
Говь-Алтай	3 064	1 364	44.5	1 985	1 346	67.8	1 079	18	1.7
Дорноговь	14 748	4 878	33.1	9 751	4 826	49.5	4 997	52	1.0
Дорнод	3 026	1 096	36.2	1 650	993	60.2	1 376	103	7.5
Дундговь	6 880	712	10.3	2 658	680	25.6	4 222	32	0.8
Завхан	9 998	1 804	18.0	5 346	1 578	29.5	4 652	226	4.9
Өвөрхангай	5 396	2 314	42.9	2 947	1 675	56.8	2 449	639	26.1
Өмнөговь	6 275	2 292	36.5	3 508	2 122	60.5	2 767	170	6.1
Сүхбаатар	22 034	4 910	22.3	8 556	2 213	25.9	13 478	2 697	20.0
Сэлэнгэ	10 618	2 011	18.9	3 001	1 692	56.4	7 617	319	4.2
Төв	4 313	1 344	31.2	2 684	1 338	49.9	1 629	6	0.4
Увс	6 279	1 500	23.9	3 645	1 423	39.0	2 634	77	2.9
Ховд	19 334	807	4.2	9 553	780	8.2	9 781	27	0.3
Хөвсгөл	8 696	2 654	30.5	3 610	1 463	40.5	5 086	1 191	23.4
Хэнтий	24 794	15 379	62.0	20 276	13 192	65.1	4 518	2 187	48.4
Дархан-Уул	11 583	6 077	52.5	8 896	5 284	59.4	2 687	793	29.5
Орхон	23 812	12 317	51.7	23 256	12 145	52.2	556	172	30.9
Говьсүмбэр	3 021	2 119	70.1	2 007	1 302	64.9	1 014	817	80.6
Улаанбаатар	317 944	194 865	61.3	317 944	194 865	61.3	-	-	-





Байшинд амьдардаг өрхийн 48 хувь нь ахуй нөхцөл сайтай байгаагийн дотор Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Хэнтий аймгууд, Улаанбаатар хот улсын дундаас дээгүүр хувьтай байна. Харин улсын дунджаас нэлээд доогуур, нийт өрхөд ахуй нөхцөл сайтай өрхийн хувийн жин 10-аас доош байгаа аймгуудад Ховд, Баян-Өлгий, Булган аймгууд орж байна. Ахуй нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын пунктээр 11.8 пунктээр өссөний дотор Хэнтий 37.0, Өвөрхангай 31.5, Хөвсгөл 27.0, Төв 17.5 пунктээр тус тус өссөн нь бусдаас өндөр өсөлттэй байна. Харин энэ үзүүлэлт Дундговьд 17.2, Ховдод 16 пунктээр буурсан байна.

Байшинд амьдардаг өрхийн дийлэнх хувь нь төв суурин газарт байдаг тул ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаас нэлээд өндөр байгаа нь зүйн асуудал билээ. Хотын нийт өрхөд ахуйн нөхцөл сайтай өрхийн эзлэх хувь улсын дунджаар 55.9 хувь байгаагийн дотор Говь-Алтай 67.8, Өмнөговь 60.5, Дорноговь 60.2 хувь байгаа нь бусдаас өндөр байгаа юм. Гэвч энэ үзүүлэлт Ховдод 8.2, Баян-Өлгийд 8.1 хувь байгаа нь улсын дундаж болон бусад аймгуудаас ихээхэн доогуур байгаа юм.

Ахуйн нөхцөл хангасан хотын өрх гэдэгт дээрх таван нөхцөлөөс дөрвийг нь хангасан өрхийг хамруулж байгаа билээ.

### ХҮСНЭГТ 3.22. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Дөрвөн нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Дөрвөн нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Дөрвөн нөхцөл	Хувь
Бүгд	546 979	10 609	1.9	451 638	9 514	2.1	95 341	1 095	1.1
Архангай	7 761	115	1.5	4 079	101	2.5	3 682	14	0.4
Баян-Өлгий	23 258	419	1.8	8 719	287	3.3	14 539	132	0.9
Баянхонгор	5 375	79	1.5	3 808	66	1.7	1 567	13	0.8
Булган	8 770	64	0.7	3 759	40	1.1	5 011	24	0.5
Говь-Алтай	3 064	103	3.4	1 985	97	4.9	1 079	6	0.6
Дорноговь	14 748	420	2.8	9 751	401	4.1	4 997	19	0.4
Дорнод	3 026	77	2.5	1 650	44	2.7	1 376	33	2.4
Дундговь	6 880	113	1.6	2 658	92	3.5	4 222	21	0.5
Завхан	9 998	129	1.3	5 346	61	1.1	4 652	68	1.5
Өвөрхангай	5 396	304	5.6	2 947	157	5.3	2 449	147	6.0
Өмнөговь	6 275	68	1.1	3 508	31	0.9	2 767	37	1.3
Сүхбаатар	22 034	442	2.0	8 556	227	2.7	13 478	215	1.6
Сэлэнгэ	10 618	182	1.7	3 001	61	2.0	7 617	121	1.6
Төв	4 313	158	3.7	2 684	150	5.6	1 629	8	0.5
Увс	6 279	294	4.7	3 645	271	7.4	2 634	23	0.9
Ховд	19 334	102	0.5	9 553	85	0.9	9 781	17	0.2
Хөвсгөл	8 696	150	1.7	3 610	110	3.0	5 086	40	0.8
Хэнтий	24 794	303	1.2	20 276	248	1.2	4 518	55	1.2
Дархан-Уул	11 583	383	3.3	8 896	301	3.4	2 687	82	3.1
Орхон	23 812	214	0.9	23 256	214	0.9	556	-	-
Говьсүмбэр	3 021	77	2.5	2 007	57	2.8	1 014	20	2.0
Улаанбаатар	317 944	6 413	2.0	317 944	6 413	2.0	-	-	-

Ахуйн нөхцөл сайтай өрхүүдийн дийлэнх нь эрүүл аюулгүй ундны усны хангамжтай, цахилгаанаар хангагдсан, бие засах газар нь эрүүл ахуйн шаардлага хангасан, орчны бохирдол багатай байгаагийн хамт хатуу хог хаягдлаа ахуй



үйлчилгээний байгууллага болон төвлөрсөн цэгт асгаж тогтсон хугацаанд зайлуулах нөхцөлүүдийг голлон хангасан байна.

Ахуйн нөхцөл сайтай өрхийн эзлэх хувийн жин улсын хэмжээнд 1.9 хувь байгаагийн дотор Өвөрхангайд 5.6, Увсад 4.7, Говь-Алтайд 3.4 хувь байгаа нь бусдаас өндөр байна. Ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс улсын дунджаар 4.5, хувь буурсны дотор Дорнодод 9.7, Говьсүмбэрт 5.9, Орхонд 5.6, Өмнөговьд 4.7 хувиар тус тус буурсан байна. Энэ нь ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өссөнтэй холбоотой.

Хотын байшинд амьдардаг нийт өрхийн 2.1 хувь нь ахуй нөхцөл сайтай байгаагийн дотор Увс 7.4, Төв 5.6, Өвөрхангай 5.3, Говь-Алтай 4.9, Дорноговь 4.1 хувь байгаа нь бусдаас өндөр байна. Харин хотын байшинд амьдардаг нийт өрхөд ахуй нөхцөл сайтай өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 5.5 пунктээр буурсны дотор Дорноговьд 12.8, Дархан-Уулд 11.6, Өмнөговьд 8.1, пунктээр буурсан нь бусдаас илүү байна.

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөл хагас хангасан өрхүүдийг сонгосон үзүүлэлтээс аль нэг гурван үзүүлэлтийг хангасан өрхүүдийг хамруулж байгаа билээ.

### ХҮСНЭГТ 3.23. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ ХАГАС ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ,ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Гурван нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Гурван нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Гурван нөхцөл	Хувь
Бүгд	546 979	19 616	3.6	451 638	15 987	3.5	95 341	3 629	3.8
Архангай	7 761	189	2.4	4 079	113	2.8	3 682	76	2.1
Баян-Өлгий	23 258	1 225	5.3	8 719	741	8.5	14 539	484	3.3
Баянхонгор	5 375	185	3.4	3 808	97	2.5	1 567	88	5.6
Булган	8 770	259	3.0	3 759	127	3.4	5 011	132	2.6
Говь-Алтай	3 064	124	4.0	1 985	78	3.9	1 079	46	4.3
Дорноговь	14 748	255	1.7	9 751	161	1.7	4 997	94	1.9
Дорнод	3 026	123	4.1	1 650	53	3.2	1 376	70	5.1
Дундговь	6 880	235	3.4	2 658	126	4.7	4 222	109	2.6
Завхан	9 998	250	2.5	5 346	102	1.9	4 652	148	3.2
Өвөрхангай	5 396	590	10.9	2 947	316	10.7	2 449	274	11.2
Өмнөговь	6 275	79	1.3	3 508	57	1.6	2 767	22	0.8
Сүхбаатар	22 034	1 580	7.2	8 556	589	6.9	13 478	991	7.4
Сэлэнгэ	10 618	465	4.4	3 001	98	3.3	7 617	367	4.8
Төв	4 313	291	6.7	2 684	251	9.4	1 629	40	2.5
Увс	6 279	396	6.3	3 645	230	6.3	2 634	166	6.3
Ховд	19 334	388	2.0	9 553	225	2.4	9 781	163	1.7
Хөвсгөл	8 696	328	3.8	3 610	188	5.2	5 086	140	2.8
Хэнтий	24 794	555	2.2	20 276	452	2.2	4 518	103	2.3
Дархан-Уул	11 583	514	4.4	8 896	432	4.9	2 687	82	3.1
Орхон	23 812	376	1.6	23 256	371	1.6	556	5	0.9
Говьсүмбэр	3 021	86	2.8	2 007	57	2.8	1 014	29	2.9
Улаанбаатар	317 944	11 123	3.5	317 944	11 123	3.5	-	-	-



Байшинд амьдардаг өрхийн ахуйн гурван нөхцөл хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үед аймаг, нийслэлд нэлээд өндөр, байшинд амьдардаг нийт өрхөд ахуйн нөхцөл хагас хангасан өрхийн эзлэх хувь 60-аас дээш аймаг 4, 50-60 хүртэл хангасан аймаг 6 байсан аж. Гэтэл энэ үзүүлэлт 2020 оны тооллогын дүнгээр өмнөхөөсөө ихээхэн өөр болсон нь анхаарал татаж байна. Энэ нь өмнөх тооллогын үед ахуйн нөхцөл хангасан үзүүлэлтэд энгийн хүн жорлонг өрх дангаараа ашигладаг бол ахуйн нөхцөл хангасан үзүүлэлтэд оруулдаг байсантай холбоотой гэж үзэж байна. Энэ тооллогын үед байшинд амьдардаг өрхийн жорлонг олон үзүүлэлтээр нарийвчлан тодорхойлж, энгийн хүн жорлонг ахуй нөхцөл хангасан гэсэн үзүүлэлтээс хассан юм.

Улсын хэмжээний байшинд амьдардаг хотын нийт өрхийн 3.5 хувь нь ахуйн нөхцөл хангасны дотор Өвөрхангай 10.4, Төв 9.4, Баян-Өлгий 8.5 хувь нь хангасан байгаа нь бусдаас нэлээд өндөр байна. Харин Ховд 2.2, Дорноговь 1.7, Өмнөговь 1.6 хувь байгаа нь бусдаас нэлээн доогуур байна.

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөл муу хангасан өрхүүдийг сонгосон үзүүлэлтээс аль нэг хоёр үзүүлэлтийг хангасан өрхүүдийг хамруулж байгаа билээ.

### **ХҮСНЭГТ 3.24. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ ДУТУУ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Хоёр нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Хоёр нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Хоёр нөхцөл	Хувь
Бүгд	546 979	238 356	43.6	451 638	171 829	38.0	95 341	66 527	69.8
Архангай	7 761	5 972	76.9	4 079	3 000	73.5	3 682	2 972	80.7
Баян-Өлгий	23 258	13 137	56.5	8 719	6 720	77.1	14 539	6 417	44.1
Баянхонгор	5 375	3 180	59.2	3 808	1 906	50.1	1 567	1 274	81.3
Булган	8 770	6 995	79.8	3 759	2 978	79.2	5 011	4 017	80.2
Говь-Алтай	3 064	1 405	45.9	1 985	457	23.0	1 079	948	87.9
Дорноговь	14 748	8 985	60.9	9 751	4 333	44.4	4 997	4 652	93.1
Дорнод	3 026	1 604	53.0	1 650	560	33.9	1 376	1 044	75.9
Дундговь	6 880	5 634	81.9	2 658	1 751	65.9	4 222	3 883	92.0
Завхан	9 998	7 508	75.1	5 346	3 593	67.2	4 652	3 915	84.2
Өвөрхангай	5 396	2 007	37.2	2 947	790	26.8	2 449	1 217	49.7
Өмнөговь	6 275	3 797	60.5	3 508	1 297	37.0	2 767	2 500	90.4
Сүхбаатар	22 034	14 214	64.5	8 556	5 267	61.6	13 478	8 947	66.4
Сэлэнгэ	10 618	7 831	73.8	3 001	1 149	38.3	7 617	6 682	87.7
Төв	4 313	2 429	56.3	2 684	936	34.9	1 629	1 493	91.7
Увс	6 279	3 642	58.0	3 645	1 682	46.1	2 634	1 960	74.4
Ховд	19 334	15 459	80.0	9 553	8 311	87.0	9 781	7 148	73.1
Хөвсгөл	8 696	5 431	62.5	3 610	1 830	50.7	5 086	3 601	70.8
Хэнтий	24 794	7 913	31.9	20 276	6 057	29.9	4 518	1 856	41.1
Дархан-Уул	11 583	4 347	37.5	8 896	2 852	32.1	2 687	1 495	55.6
Орхон	23 812	10 866	45.6	23 256	10 505	45.2	556	361	64.9
Говьсүмбэр	3 021	735	24.3	2 007	590	29.4	1 014	145	14.3
Улаанбаатар	317 944	105 265	33.1	317 944	105 265	33.1	-	-	-

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлөө дутуу хангасан өрхүүдийн хувьд цахилгаантай, хатуу хог хаягдлаа тогтоосон цэгт, эсвэл ахуй үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхүүд хамрагдаж байна.

Байшинд амьдардаг нийт өрхөд ахуй нөхцөлийг дутуу хангасан өрхийн эзлэх хувь улсын дунджаар 46.5 хувь байгаагаас Архангай, Булган, Дорноговь, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Ховд аймгууд нэлээд өндөр байгаа нь сайн үзүүлэлт



биш юм. Ялангуяа хот суурин газрын байшинд амьдардаг нийт өрхүүдээс ахуй нөхцөлийн хоёрхон үзүүлэлт хангасан өрхийн эзлэх хувь улсын дунджаас бага байгаа аймгууд ундны усны аюулгүй байдал, орчны эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газар, бохир ус зайлуулах төвлөрсөн шугам сүлжээнд айл өрхүүдийг холбох арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөл муу хангасан аймгуудад сонгосон үзүүлэлтээс зөвхөн нэг үзүүлэлт хангасан өрхүүдийг хамруулж байгаа юм.

### ХҮСНЭГТ 3.25. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ МУУ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Нэг нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Нэг нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Нэг нөхцөл	Хувь
Бүгд	546 979	16 066	2.9	451 638	1 633	0.4	95 341	14 433	15.1
Архангай	7 761	627	8.1	4 079	23	0.6	3 682	604	16.4
Баян-Өлгий	23 258	7 713	33.2	8 719	261	3.0	14 539	7 452	51.3
Баянхонгор	5 375	165	3.1	3 808	4	0.1	1 567	161	10.3
Булган	8 770	957	10.9	3 759	146	3.9	5 011	811	16.2
Говь-Алтай	3 064	68	2.2	1 985	7	0.4	1 079	61	5.7
Дорноговь	14 748	209	1.4	9 751	30	0.3	4 997	179	3.6
Дорнод	3 026	126	4.2	1 650	-	-	1 376	126	9.2
Дундговь	6 880	186	2.7	2 658	9	0.3	4 222	177	4.2
Завхан	9 998	306	3.1	5 346	12	0.2	4 652	294	6.3
Өвөрхангай	5 396	181	3.4	2 947	9	0.3	2 449	172	7.0
Өмнөговь	6 275	39	0.6	3 508	1	0.0	2 767	38	1.4
Сүхбаатар	22 034	888	4.0	8 556	260	3.0	13 478	628	4.7
Сэлэнгэ	10 618	129	1.2	3 001	1	0.0	7 617	128	1.7
Төв	4 313	91	2.1	2 684	9	0.3	1 629	82	5.0
Увс	6 279	447	7.1	3 645	39	1.1	2 634	408	15.5
Ховд	19 334	2 577	13.3	9 553	152	1.6	9 781	2 425	24.8
Хөвсгөл	8 696	133	1.5	3 610	19	0.5	5 086	114	2.2
Хэнтий	24 794	644	2.6	20 276	327	1.6	4 518	317	7.0
Дархан-Уул	11 583	262	2.3	8 896	27	0.3	2 687	235	8.7
Орхон	23 812	39	0.2	23 256	21	0.1	556	18	3.2
Говьсүмбэр	3 021	4	0.1	2 007	1	0.0	1 014	3	0.3
Улаанбаатар	317 944	275	0.1	317 944	275	0.1	-	-	-

Байшинд амьдардаг өрхөөс ахуйн нэг нөхцөл хангасан өрхүүд нь үндсэндээ цахилгаантай, бусад нөхцөл хангагдаагүй гэсэн үг юм. Ийм өрхийн тоо Баян-Өлгий аймагт өндөр хувийг эзэлж байгаа нь уул аймагт хот, хөдөөгүй байшинд амьдардаг өрхүүд олон байгаатай холбоотой.




### ХҮСНЭГТ 3.26. БАЙШИНД АМЬДАРДАГ АХУЙН НӨХЦӨЛ МУУ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Нэг нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Нэг нөхцөл	Хувь	Өрхийн тоо	Нэг нөхцөл	Хувь
Бүгд	546 979	16 066	2.9	451 638	1 633	0.4	95 341	14 433	15.1
Архангай	7 761	627	8.1	4 079	23	0.6	3 682	604	16.4
Баян-Өлгий	23 258	7 713	33.2	8 719	261	3.0	14 539	7 452	51.3
Баянхонгор	5 375	165	3.1	3 808	4	0.1	1 567	161	10.3
Булган	8 770	957	10.9	3 759	146	3.9	5 011	811	16.2
Говь-Алтай	3 064	68	2.2	1 985	7	0.4	1 079	61	5.7
Дорноговь	14 748	209	1.4	9 751	30	0.3	4 997	179	3.6
Дорнод	3 026	126	4.2	1 650	0	0.0	1 376	126	9.2
Дундговь	6 880	186	2.7	2 658	9	0.3	4 222	177	4.2
Завхан	9 998	306	3.1	5 346	12	0.2	4 652	294	6.3
Өвөрхангай	5 396	181	3.4	2 947	9	0.3	2 449	172	7.0
Өмнөговь	6 275	39	0.6	3 508	1	0.0	2 767	38	1.4
Сүхбаатар	22 034	888	4.0	8 556	260	3.0	13 478	628	4.7
Сэлэнгэ	10 618	129	1.2	3 001	1	0.0	7 617	128	1.7
Төв	4 313	91	2.1	2 684	9	0.3	1 629	82	5.0
Увс	6 279	447	7.1	3 645	39	1.1	2 634	408	15.5
Ховд	19 334	2 577	13.3	9 553	152	1.6	9 781	2 425	24.8
Хөвсгөл	8 696	133	1.5	3 610	19	0.5	5 086	114	2.2
Хэнтий	24 794	644	2.6	20 276	327	1.6	4 518	317	7.0
Дархан-Уул	11 583	262	2.3	8 896	27	0.3	2 687	235	8.7
Орхон	23 812	39	0.2	23 256	21	0.1	556	18	3.2
Говьсүмбэр	3 021	4	0.1	2 007	1	0.0	1 014	3	0.3
Улаанбаатар	317 944	275	0.1	317 944	275	0.1	-	-	-

Улсын хэмжээнд байшинд амьдардаг өрхүүдээс цахилгаанаас өөр ахуйн нөхцөлөөр хангагдаагүй өрх 16.1 мянга байгаагийн 89.8 хувь нь хөдөөгийн өрх юм. Байшинд амьдардаг хотын өрхүүд үндсэндээ цахилгаанаар хангагдсан аж. Гэхдээ ахуйн бусад нөхцөлийг бүрдүүлэх талаар орон нутгийн төр захиргааны байгууллагууд анхаарах шаардлагатай юм.

Байшинд амьдардаг өрхүүдээс ахуйн нөхцөл хангаагүй өрх өнгөрсөн тооллогын үед 795 өрх байсан бол 2020 онд 27 болж, бараг 30 дахин буурсан аж.

**ЗУРАГ 3.2 БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙ НӨХЦӨЛӨӨР ХАНГАГДСАН БАЙДАЛ, ХУВИАР, 2020 ОН**





# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО,  
АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ**





Монголын нутаг дэвсгэрт нутаглаж байсан овог аймгуудын орон сууц болох эсгий гэрийн түүх бол МЭӨ 500 жилийн тэртээ үеэс буюу эсгий хийж гэрээ бүрдэг болсон цагаас эхлэлтэй гэж түүхийн ном сударт олонтоо тэмдэглэгдэн үлджээ. Нүүдлийн амьдралтай айлуудын гэр нь ачиж нүүхэд аль болох хөнгөн, барихад хялбар бол хот суурин газрын гэр нь аль болох тохилог, гоёмсог байдлыг эрхэмлэдэг учраас өөр хоорондоо бага зэрэг ялгаатай.

Монголд жилийн 300 орчим өдөр нартай байдаг учраас монгол гэр цаг улиралд маш сайн зохицсон байхын хамт тоононоос туссан нарны байдлаар цагийн баримжаа олдог, агаарын солилцоо сайтай зэрэг олон талын ач холбогдолтойг орчин үед шинжлэх ухааны үндэслэлтэй төрөл бүрийн судалгаа нотолсоор байна.

Монгол гэрийн багтаамжийг ханын тоогоор тогтоодог уламжлалтай. Монгол Улсын хүн ам, мал, хөрөнгө хогшлын 1933 оны бүртгэлээс эхлээд хүн ам, орон сууцны болон орон сууцны үе үеийн тооллогуудад гэрийн багтаамжийг ханын тоогоор тогтоож ирсэн аж. Дээр үеэс ханын тоог сондгой тоогоор тогтоодог байсан бол сүүлийн үед тэгш, сондгой аль алианаар нь тогтоодог болж байна. Монгол гэрийн үүсэл гарал, бүтэц хийц болон бусад холбогдох асуудлаар маш өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажлууд хийгддэг боловч монгол гэрийн талбайн хэмжээг тогтоосон бодит судалгаа өнөө хир байхгүй байгаа юм. Үйлдвэрийн аргаар гэр хийдэг аж ахуйн нэгжүүдийн тогтоосноор 4 ханатай гэрийн талбай 20, 5 ханатынх 28, 6 ханатынх 35, 8 ханатынх 65, 10 ханатынх 80 кв.м гэж тогтоосон аж.

Хүн ам, орон сууцны сүүлийн тооллогуудын дүнгээр улсын хэмжээний нийт өрхөд гэрт амьдардаг өрхийн эзлэх хувийн жин буурсаар байгаа боловч гэр нь монголчуудын уламжлалт сууц хэвээр байх нь дамжиггүй.

#### **ХҮСНЭГТ 4.1 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛ, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН**

Ам бүлийн тоо	БҮГД		5-ААС ЦӨӨН		ТАВ		ЗУРГАА		ЗУРГААГААС ОЛОН	
	Мян өрх	Эзлэх хувь	Мян өрх	Эзлэх хувь	Мян өрх	Эзлэх хувь	Мян өрх	Эзлэх хувь	Мян өрх	Эзлэх хувь
2010										
БҮГД	322.8	100.0	82.0	25.4	181.7	56.3	50.8	15.7	8.3	2.6
1-2	88.0	100.0	31.3	35.6	44.8	51.0	10.5	11.9	1.4	1.5
3-4	150.4	100.0	35.2	23.4	87.8	58.4	23.7	15.7	3.7	2.5
5-6	21.6	100.0	13.3	18.5	41.6	58.2	14.1	19.6	2.6	3.7
7+	12.8	100.0	2.3	17.5	7.4	58	2.6	20.5	0.5	4
2020										
БҮГД	342.4	100.0	60.9	17.8	235.2	68.7	38.5	11.3	7.8	2.2
1-2	118.4	100.0	27.6	23.3	79.1	66.8	9.9	8.3	1.8	1.6
3-4	124.4	100.0	20	16.1	87	69.9	14.3	11.5	3.1	2.5
5-6	81.7	100.0	11.2	13.6	56.6	69.3	14.6	14.2	2.3	2.9
7+	19.9	100.0	2.2	12.1	12.5	69.8	2.7	15.2	0.5	2.9

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр гэрт амьдардаг нийт өрхийн 56.3 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байсан бол энэ үзүүлэлт 2020 онд 68.7 болж, өмнөх тооллогын үеийнхээс 12.4 пунктээр өссөнөөс үзэхэд таван ханатай гэр манай ард түмний түгээмэл сууц хэвээр байна. Гэрийн ханын тоогоор талбайн





хэмжээг тооцож болох хэдий ч аймаг орон нутаг, үндэс, угсаатны уламжлалт зан заншилтай холбоотойгоор ханын толгойн тоо, зууравчны хэмжээ, ханын эрс зэргээс хамаарч, гэрийн хэмжээ өөр өөр байх нь ойлгомжтой. Гэхдээ түүвэр судалгааны аргаар бүс нутгуудаас төлөөлөхүйц хэмжээний гэрийг сонгон авч хэмжилт хийж, гэрийн талбайн хэмжээг тогтоох цаг нэгэнт болсон гэж үзэж байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр улсын хэмжээний нийт өрхийн 27 хувь, хөдөөгийн өрхийн 66.1 хувь нь гэрт амьдарч байгаа юм.

Хүн ам, орон сууцны үе үеийн тооллогоор байшинд амьдардаг өрхийн сууцны талбайг тодорхойлж байсан боловч гэрийн талбайг тодорхойлоогүй явж ирсэн нь учир дутагдалтай юм. Учир нь улсын хэмжээнд хэдий хэмжээний талбайтай сууцны фондтойг, нэг хүнд дунджаар хэдэн квадрат метр талбай ногддог, тэр нь олон улсын дундажтай зэрэгцүүлэхэд ямар түвшинд байдгийг тодорхойлох боломж байхгүй явж ирсэн аж.

Гэрт амьдардаг өрхийн ханын тоо, ам бүлийн тоогоор ангилж үзэхэд 2010 онд 2000 оныхоос нэлээд өөрчлөлт гарч байжээ. Тухайлбал: Таваас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 10 жилийн өмнөхөөс 4.8 пунктээр нэмэгдсэн бол харин 6, түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 3.0 пунктээр буурсан байжээ. Мөн долоо, түүнээс дээш ам бүлтэй 5-аас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин 2000 онд 11.5 байсан бол 2010 онд 6 пунктээр өсөж, харин 6 ханатай гэрт амьдрагчдын хувь 2.1 пунктээр буурсан аж. Гэтэл Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнг 2010 оныхтой харьцуулахад 2020 онд 2010 оноос таван ханатай гэр, түүнд амьдардаг өрхийн тоо өсөж, бусад ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь буурсан байгаагаас бусад мэдэгдэхүйц том өөрчлөлт гараагүй байна.

#### **ХҮСНЭГТ 4.2.ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ГЭРИЙН ХАНЫН ТООГООР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН**


Аймаг, нийслэл	БҮГД	ХАНЫН ТООГООР			
		<5	5	6	7+
БҮГД	100.0	6.0	89.2	4.8	0.1
Архангай	100.0	5.9	46.1	45.9	2.0
Баян-Өлгий	100.0	27.3	72.3	0.3	0.0
Баянхонгор	100.0	8.5	86.2	4.3	1.0
Булган	100.0	13.9	75.2	10.8	0.1
Говь-Алтай	100.0	57.2	42.1	0.4	0.4
Дорноговь	100.0	33.5	66.1	0.3	0.0
Дорнод	100.0	2.5	42.5	53.6	1.4
Дундговь	100.0	14.2	85.5	0.2	0.0
Завхан	100.0	30.9	68.3	0.6	0.2
Өвөрхангай	100.0	61.6	37.7	0.4	0.3
Өмнөговь	100.0	8.6	81.2	7.5	2.7
Сүхбаатар	100.0	17.3	79.7	2.3	0.8
Сэлэнгэ	100.0	0.2	4.4	63.9	31.5
Төв	100.0	3.1	38.4	57.3	1.2
Увс	100.0	5.1	80.3	13.9	0.7
Ховд	100.0	47.5	51.6	0.6	0.3
Хөвсгөл	100.0	12.2	72.0	11.5	4.3
Хэнтий	100.0	44.3	54.9	0.7	0.1
Дархан-Уул	100.0	10.5	74.7	12.7	2.1
Орхон	100.0	25.3	73.6	1.0	0.1
Говьсүмбэр	100.0	12.2	83.0	3.7	1.1
Улаанбаатар	100.0	12.2	83.0	3.7	1.1






Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр гэрт амьдардаг өрхийн 89.2 хувь нь таван ханатай гэрт амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 32.9 пунктээр өссөн аж. Гэвч энэ үзүүлэлт аймаг, нийслэлд харилцан адилгүй, нэлээд ялгаатай байна. Таван ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дундажтай ойролцоо 6 аймаг, нийслэл байгаа боловч, Говь-Алтай, Өвөрхангай, Хэнтий аймгууд улсын дунджаас бараг хоёр дахин, Сэлэнгэ аймаг 20 дахин бага байгаа нь ихээхэн сонин баримт юм. Сэлэнгийн 6, 7 түүнээс дээш ханатай гэрт амьдардаг өрхийн тоо бусдаас ихээхэн өндөр байгаа нь энэ аймаг улсын хэмжээнд нэлээд том гэрт амьдардаг аж. Таван ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс Увс 74.1, Сүхбаатар 46.2, Баян-Өлгий 44.0, Завхан 38.9, Дундговь 30.2 пунктээр өссөн нь бусдаас өндөр, харин Сэлэнгэ 55,6, Өвөрхангай 42.9 пунктээр буурсан аж.

**ЗУРАГ 4.1 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН**



Таван ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс аймаг, нийслэлд нэлээд өөрчлөлт гаргахын зэрэгцээгээр таваас цөөн буюу жижиг гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь ч нэлээд өөрчлөгдсөн аж. Таваас цөөн ханатай гэрт амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 19.4 пунктээр өссөний дотор Дорнодод 62.0, Говьсүмбэрт 31.0, Дундговьд 29.5 пунктээр тус тус өссөн байхад Өвөрхангайд 42.3, Ховдод 41.6, Говь-Алтайд 40.9 пунктээр буурсан нь бусдаас илүү байна.

**ЗУРАГ 4.2 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН**





## ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ДЭД БҮТЭЦ

**Цахилгааны хангамж.** Гэрт амьдардаг өрхийн гишүүдийн тав тухтай, амьдрах урьдах нөхцөлийн нэг бол цахилгаанаар хангагдах явдал юм. Гэрт амьдардаг өрхүүдийн цахилгаанаар хангагдсан байдал тооллогоос тооллогод улам дээшилсээр байна.

### ХҮСНЭГТ 4.3 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ, ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Цахилгааны эх үүсвэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Мян.өрх	Эзлэх хувь	Мян.өрх	Эзлэх хувь	Мян.өрх	Эзлэх хувь
<b>2010</b>						
<b>Бүгд</b>	<b>322.8</b>	<b>100.0</b>	<b>156.7</b>	<b>100.0</b>	<b>166.1</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	182.3	56.5	139.4	88.9	42.9	25.9
Дизель станц	12.5	3.9	5.5	3.5	7.0	4.2
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	96.5	29.9	5.7	3.6	90.8	54.7
Бага оврын цахилгаан үүсгүүр	10.2	3.2	1.6	1.0	8.7	5.2
Цахилгааны эх үүсвэргүй	21.2	6.5	4.6	3.0	16.6	10.0
<b>2020</b>						
<b>Бүгд</b>	<b>342.4</b>	<b>100.0</b>	<b>149.9</b>	<b>100.0</b>	<b>192.5</b>	<b>100.0</b>
Төвлөрсөн систем	196.7	57.4	144.1	96.2	52.6	27.3
Дизель станц	0.2	0.1	-	-	0.2	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	134.4	39.2	3.9	2.6	130.5	67.8
Бага оврын цахилгаан үүсгүүр	6.8	2.0	0.8	0.5	6.0	3.1
Цахилгааны эх үүсвэргүй	4.4	1.3	1.0	0.7	3.4	1.7

Гэрт амьдардаг өрхийн цахилгаан хангамж сайжирч, төвлөрсөн системээс цахилгаанаа авдаг өрхийн тоо 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 0.9 пунктээр, үүнээс хотын өрхийнх 7.3 пунктээр нэмэгдсэний зэрэгцээгээр сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөс цахилгаанаа авдаг хөдөөгийн өрхийн тоо 10.1 пунктээр тус тус өсжээ. Харин цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 16.8 мянгаар буурсан байна.


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр төвлөрсөн системээс цахилгаанаа авдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 57.4 хувь байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 15.5 пунктээр өссөний дотор Говь-Алтай 39.6, Завхан 34.1, Өмнөговь 20.6 пунктээр тус тус өссөн сайн талтай боловч энэ үзүүлэлт 13 аймагт буурсны дотор Булганд 12.7, Өвөрхангайд 10.2, Хөвсгөлд 15.5 пунктээр буурсан нь бусдаас илүү байна. Харин нийт өрхөд цахилгаан гэрэлгүй өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 6.6 пунктээр буурсны дотор энэ үзүүлэлт бүх аймаг нийслэлд буурсан нь том амжилт юм. Үүний дотор Баян-Өлгийд 13.3, Дорноговьд 10.4, Сүхбаатарт 8.9, Төвд 8.0 пунктээр буурсан нь бусдаас илүү байна.



#### ХҮСНЭГТ 4.4. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР				
		Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
БҮГД	100.0	57.4	0.1	39.2	2.0	1.3
Архангай	100.0	19.4	0.0	78.8	0.0	1.8
Баян-Өлгий	100.0	30.8	0.0	60.9	3.6	4.6
Баянхонгор	100.0	40.8	0.0	56.0	2.1	1.1
Булган	100.0	17.0	0.2	67.9	12.6	2.2
Говь-Алтай	100.0	41.7	0.0	56.6	0.0	1.7
Дорноговь	100.0	53.0	0.0	44.8	1.1	1.2
Дорнод	100.0	44.9	0.1	48.5	4.3	2.2
Дундговь	100.0	43.7	0.0	54.2	1.2	0.9
Завхан	100.0	41.0	0.0	57.2	1.0	0.9
Өвөрхангай	100.0	40.3	0.0	58.7	0.0	1.0
Өмнөговь	100.0	64.9	0.0	29.9	3.3	1.8
Сүхбаатар	100.0	38.1	0.0	61.7	0.1	0.1
Сэлэнгэ	100.0	41.3	0.1	54.2	2.7	1.8
Төв	100.0	43.2	0.0	56.6	0.0	0.2
Увс	100.0	50.6	0.0	49.2	0.0	0.2
Ховд	100.0	47.9	0.8	44.8	3.8	2.6
Хөвсгөл	100.0	25.0	0.2	63.3	8.8	2.7
Хэнтий	100.0	49.4	0.0	40.8	7.4	2.4
Дархан-Уул	100.0	82.4	0.0	14.9	1.6	1.1
Орхон	100.0	91.9	0.0	7.4	0.5	0.2
Говьсүмбэр	100.0	63.9	0.0	29.0	4.7	2.4
Улаанбаатар	100.0	98.1	0.0	0.7	0.3	0.9

**ЗУРАГ 4.3 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРГҮЙ ӨРХИЙН НИЙТ ӨРХӨД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН**





Гэрт амьдардаг өрхийн цахилгааны хангамж улсын хэмжээгээр сайжирч байгаа боловч аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.

#### ХҮСНЭГТ 4.5 ГЭРТ АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР				
		Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
БҮГД	100.0	96.2	0.0	2.6	0.5	0.7
Архангай	100.0	87.6	0.0	10.8	0.0	1.6
Баян-Өлгий	100.0	95.0	0.0	5.0	0.0	0.0
Баянхонгор	100.0	95.0	0.0	5.0	0.0	0.0
Булган	100.0	63.5	0.2	30.2	3.1	3.1
Говь-Алтай	100.0	88.6	0.0	10.9	0.0	0.5
Дорноговь	100.0	95.7	0.0	3.1	0.8	0.4
Дорнод	100.0	94.5	0.1	4.2	1.1	0.1
Дундговь	100.0	99.6	0.0	0.2	0.0	0.1
Завхан	100.0	96.4	0.0	3.2	0.3	0.1
Өвөрхангай	100.0	98.8	0.0	1.0	0.0	0.2
Өмнөговь	100.0	98.3	0.0	1.3	0.2	0.2
Сүхбаатар	100.0	96.2	0.0	3.8	0.0	0.0
Сэлэнгэ	100.0	53.1	0.1	43.9	2.1	0.8
Төв	100.0	98.0	0.0	2.0	0.0	0.0
Увс	100.0	96.5	0.0	3.4	0.0	0.2
Ховд	100.0	98.5	0.0	1.1	0.1	0.2
Хөвсгөл	100.0	79.3	0.9	11.1	7.4	1.4
Хэнтий	100.0	83.3	0.0	12.6	3.5	0.6
Дархан-Уул	100.0	94.6	0.0	4.1	0.7	0.6
Орхон	100.0	99.7	0.0	0.2	0.1	0.1
Говьсүмбэр	100.0	98.6	0.0	0.5	0.2	0.7
Улаанбаатар	100.0	98.1	0.0	0.7	0.3	0.9

Гэрт амьдардаг хотын нийт өрхөд төвлөрсөн системээс цахилгаанаа авдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 7.2 пунктээр өссөний дотор, Говьсүмбэр 29.9, Сүхбаатар 22.7, Дундговь 20.6, Сэлэнгэ 18.1 пунктээр өссөн нь бусдаас өндөр байна. Үүнээс гадна Говь-Алтай, Завхан аймгуудад ихээхэн дэвшил гарчээ. Хотын өрхүүдийн хувьд дизель станцаас цахилгаанаар хангагдах явдал бараг байхгүй байгаа нь энэ эх үүсвэрийг ашиглах нь багасаж байгааг харуулж байна. Гэвч төвлөрсөн системээс цахилгаанаар хангагддаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Булган, Сэлэнгэ аймгууд бусдаас ихээхэн доогуур байгаа нь анхаарах асуудал юм. Хот суурин газар гэрт амьдардаг өрхүүдээс цахилгаангүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс улсын дүнгээр 2.3 пунктээр буусны дотор Сэлэнгэ 7.8, Баян-Өлгий 6.8, Сүхбаатар 4.0 пунктээр тус тус буурсан нь бусдаас өндөр байна.



Хот суурин газарт гэрт амьдардаг өрхүүдээс 2020 оны тооллогын дүнгээр цахилгаангүй 1016 өрх байгаагийн 78.2 хувь буюу 795 өрх нийслэлд байгаа нь анхаарах асуудал юм.

#### ХҮСНЭГТ 4.6. ГЭРТ АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг	БҮГД	ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР				
		Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
БҮГД	100.0	27.3	0.1	67.8	3.1	1.7
Архангай	100.0	13.1	0.0	85.1	0.0	1.8
Баян-Өлгий	100.0	18.3	0.0	71.9	4.4	5.5
Баянхонгор	100.0	20.8	0.0	74.8	2.9	1.5
Булган	100.0	13.7	0.2	70.6	13.3	2.2
Говь-Алтай	100.0	25.8	0.0	72.1	0.0	2.1
Дорноговь	100.0	27.6	0.0	69.5	1.3	1.6
Дорнод	100.0	24.1	0.1	67.0	5.6	3.1
Дундговь	100.0	31.0	0.0	66.4	1.5	1.1
Завхан	100.0	32.2	0.0	65.7	1.1	1.0
Өвөрхангай	100.0	28.5	0.0	70.3	0.0	1.2
Өмнөговь	100.0	48.0	0.0	44.4	4.9	2.7
Сүхбаатар	100.0	28.2	0.0	71.5	0.1	0.1
Сэлэнгэ	100.0	38.7	0.1	56.4	2.8	2.0
Төв	100.0	37.1	0.0	62.7	0.0	0.2
Увс	100.0	28.7	0.0	71.0	0.0	0.2
Ховд	100.0	29.9	1.1	60.4	5.1	3.5
Хөвсгөл	100.0	14.0	0.1	73.8	9.1	3.0
Хэнтий	100.0	34.8	0.0	53.0	9.1	3.2
Дархан-Уул	100.0	43.9	0.0	49.0	4.3	2.9
Орхон	100.0	39.1	0.0	56.2	3.5	1.2
Говьсүмбэр	100.0	32.8	0.0	54.6	8.7	4.0

Гэрт амьдардаг хөдөөгийн өрхүүдийн цахилгааны эх үүсвэр хот, суурин газрынхаас нэлээд ялгаатай, хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний, бага оврын үүсгүүр нэлээд нэвтэрч байгаа сайн талтай аж. Гэрт амьдардаг хөдөөгийн өрхүүдээс төвлөрсөн системээс цахилгаанаа авдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 25.9 пунктээр өссөний дотор Увс 40.8, Төв 40.3, Дундговь 40.5, Сэлэнгэ 33.5, Өвөрхангай 33.0, Сүхбаатар 31.5 пунктээр тус тус өссөн нь бусдаас өндөр байна.

Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөр цахилгаанаа хангадаг өрхийн тоо өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 13.1 пунктээр өссөний дотор Говьсүмбэр 35.1, Архангай 24.0, Дорноговь 23.8, Увс 20.2 пунктээр тус тус өссөн нь бусдаас өндөр байна.



Гэрт амьдардаг хөдөөгийн өрхүүдээс цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээгээр 8.2 пунктээр буурсны дотор Баян-Өлгий 15.4, Дорноговь 15.0, Дорнод 11.3, Архангай 10.7, Сүхбаатар 10.3, Хэнтий 10.2 пунктээр тус тус буурсан нь бусдаас илүү байна. Гэвч гэрт амьдардаг хөдөөгийн 3368 өрх цахилгааны эх үүсвэргүй байгаагийн дотор Хөвсгөлд 452, Ховдод 401, Архангайд 301 өрх байгаа нь бусдаас илүү олон өрх байна.

## ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙ НӨХЦӨЛ

Гэрт амьдардаг өрхийн ахуй нөхцөлийн голлох үзүүлэлтийг бие засах газар, хатуу хог хаягдал, бохир ус зайлуулах хэлбэрийг үе үеийн тооллогоор тодорхойлсоор ирсэн. Харин Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гэрт амьдардаг өрхийн ахуй нөхцөлийн үзүүлэлтийг өмнөх тооллогынхоос нэлээд нарийвчилж тодорхойлсон.

### ХҮСНЭГТ 4.7. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙ НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Ахуйн нөхцөлийн төрөл	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>Бие засах газар</b>						
БҮГД	342 409	100.0	149 873	100.0	192 536	100.0
Сайжруулсан	4 987	1.5	3 328	2.2	1 659	0.9
Энгийн	264 909	77.4	145 031	96.8	119 878	62.3
Био жорлон	458	0.1	331	0.2	127	0.1
Задгай	72 055	21.0	1 183	0.8	70 872	36.8
<b>Хатуу хог хаягдал зайлуулалт</b>						
БҮГД	342 409	100.0	149 873	100.0	192 536	100.0
Үйлчилгээний байгууллагаар	155 644	45.5	135 626	90.5	20 018	10.4
Зөвшөөрөгдсөн цэгт	52 561	15.4	7 893	5.3	44 668	23.2
Шатаадаг	11 205	3.3	306	0.2	10 899	5.7
Булдаг	1 320	0.4	79	0.1	1 241	0.6
Тогтсон цэг байхгүй	121 679	35.5	5 969	4.0	115 710	60.1
<b>Бохир ус дайлуулалт</b>						
БҮГД	342 409	100.0	149 873	100.0	192 536	100.0
Цооног	183 873	53.7	127 747	85.2	56 126	29.2
Задгай	158 536	46.3	22 126	14.8	136 410	70.8

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр гэрт амьдардаг нийт өрхөд бие засах тодорхой цэггүй өрхийн эзлэх хувь улсыг хэмжээнд 25.8, хөдөөд 45.7 хувь байсан бол 2020 онд улсын хэмжээнд 4.8, хөдөөд 8.9 пунктээр буурсан аж.

Хатуу хог хаягдал зайлуулах хэлбэрийн хувьд 2020 онд гэрт амьдардаг нийт өрхийн 45.5 хувь нь үйлчилгээний байгууллагаар хатуу хог хаягдлаа зайлуулж байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 2.5 пунктээр, хотын өрхийнх



10.4 пунктээр тус тус өссөн байна. Гэтэл хатуу хог хаягдал зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь хоёр тооллогын хооронд бараг буураагүй байгаа нь орчны бохирдлыг бууруулах талаар зохион байгуулж буй ажлын үр дүн бага байгааг харуулж байна.

Бохир ус зайлуулах тодорхой цэггүй задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 2.8 пунктээр өссөн нь муу талтай ч, харин хотын өрхийнх 3.5 пунктээр буурсан аж. Цаашид төв суурин газрын хөрс, гадаргын усны бохирдлыг бууруулах, бохир усаа задгай асгах явдлыг цөөрүүлэх талаар орон нутгийн төр захиргааны байгууллагууд дорвитой ажил зохион байгуулах нь зүйтэй байна.

#### ХҮСНЭГТ 4.8.ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙ НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг нийслэл	БҮГД	БИЕ ЗАСАХ ГАЗАР			ХАТУУ ХОГ ХЯАГДАЛ				БОХИР УС	
		Сайжруулсан, био	Энгийн	Задгай	Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Бусад	Тогтсон цэг байхгүй	Цооног	Задгай
БҮГД	100.0	1.6	77.4	21.0	45.5	15.4	3.7	35.5	53.7	46.3
Архангай	100.0	0.5	72.4	27.1	10.2	11.9	7.2	70.7	16.0	84.0
Баян-Өлгий	100.0	2.2	76.8	21.1	10.5	27.2	5.3	57.0	42.0	58.0
Баянхонгор	100.0	0.7	52.3	47.0	36.1	5.7	3.9	54.4	42.1	57.9
Булган	100.0	0.8	80.4	18.8	7.1	28.0	4.9	59.9	26.3	73.7
Говь-Алтай	100.0	1.7	51.3	47.0	26.8	20.7	3.5	48.9	46.1	53.9
Дорноговь	100.0	1.1	76.0	22.9	43.6	9.0	13.1	34.3	40.5	59.5
Дорнод	100.0	0.8	90.0	9.2	31.8	16.8	3.3	48.1	30.9	69.1
Дундговь	100.0	2.0	74.5	23.4	28.3	21.2	5.8	44.7	51.0	49.0
Завхан	100.0	1.2	62.3	36.5	17.2	31.7	5.7	45.5	46.6	53.4
Өвөрхангай	100.0	0.5	56.8	42.7	29.9	13.9	2.4	53.8	38.5	61.5
Өмнөговь	100.0	2.7	87.6	9.8	54.9	14.7	3.3	27.2	71.4	28.6
Сүхбаатар	100.0	0.2	51.4	48.5	23.2	16.5	3.4	57.0	33.9	66.1
Сэлэнгэ	100.0	0.6	91.8	7.6	16.2	41.1	3.9	38.8	37.8	62.2
Төв	100.0	0.7	70.7	28.6	17.9	33.4	3.8	44.9	35.3	64.7
Увс	100.0	0.9	56.1	43.0	23.2	27.7	3.9	45.2	39.1	60.9
Ховд	100.0	2.1	62.6	35.3	12.4	36.9	4.5	46.2	46.5	53.5
Хөвсгөл	100.0	0.8	91.3	8.0	15.4	20.4	10.9	53.3	39.9	60.1
Хэнтий	100.0	0.6	84.2	15.2	30.0	23.1	5.3	41.5	43.9	56.1
Дархан-Уул	100.0	0.8	97.8	1.4	64.1	9.4	1.1	25.5	58.4	41.6
Орхон	100.0	0.5	92.0	7.5	89.2	2.6	1.1	7.1	90.2	9.8
Говьсүмбэр	100.0	3.1	87.7	9.2	52.1	8.4	4.2	35.3	62.7	37.3
Улаанбаатар	100.0	3.1	96.6	0.3	96.6	1.4	0.1	1.9	86.5	13.5

Хүнийг аюулгүй орчинд, эрүүл саруул амьдрах гол нөхцөл нь байгаль орчин үүний дотор хөрс, усыг бохирдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь маш чухал билээ. Гэрт амьдарч байгаа өрхүүдийн ахуй нөхцөлийн сүүлийн хоёр тооллогын дүнгээс үзэхэд ахуй нөхцөлийн гол үзүүлэлтүүд сайжирч байгаа боловч бас томоохон ахиц олохгүй байгаа нь харагдаж байна.

**Бие засах газар.** Улсын хэмжээгээр гэрт амьдардаг өрхийн 77.4 хувь нь энгийн бие засах газартай байгаагийн дотор 80-аас дээш хувьтай 10 аймаг, нийслэл байна. Нүхэн жорлон төв суурийн газрын хөрсний бохирдолд ихээхэн





сөрөг нөлөөтэйг шинжлэх ухааны үндэслэлтэй олон судалгаа шинжилгээ тогтоож, сүүлийн үед сайжруулсан, био жорлонг нэвтрүүлж байгаа боловч төдийлөн ахицтай биш байна. Энэ ажлыг Говьсүмбэр аймаг, нийслэлд бусдаас арай ахицтай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна. Байгаль орчны бохирдолд жирийн нүхэн жорлонгоос илүү их хор хөнөөлтэй, бие засах тогтсон цэг байхгүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд улсын дунджаар 4.7 пунктээр буурсны дотор Баян-Өлгийд 29.4, Говьсүмбэрт 17.7, Өмнөговьд 16.5, Булганд 16.0 пунктээр тус тус буурсан нь бусдаас илүү буурсан байна. Гэтэл энэ үзүүлэлт сүүлийн хоёр тооллогын хооронд буурах бүү хэл өссөн аймаг ч бас байна. Эдгээрийн тоонд Увс 4.9, Орхон 1.9, Завхан, Говь-Алтай тус бүр 0,8, Баянхонгор 0.7 пунктээр тус тус өссөн байна. Бие засах газрын төрөл аймаг, нийслэл, хот хөдөөгөөр нэлээд ялгаатай байна. (Хавсралт 10)

**Хатуу хог хаягдалд зайлуулалт.** Гэрт амьдардаг өрхүүд хатуу хог хаягдаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 45.5 байгаа боловч, аймгуудын дотор энэ үзүүлэлт 40 –өөс дээш хувьтай аймаг дөнгөж 4 байна. Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 20-иос доош аймаг 7 байна. Энэ үзүүлэлт сүүлийн хоёр тооллогын хооронд олигтой ахиц гарсангүй. Хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэг байхгүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өнгөрсөн тооллогынхоос улсын хэмжээнд дөнгөж 0.4 пунктээр буурсан нь хангалтгүй юм. Харин энэ үзүүлэлт өнгөрсөн тооллогынхоос Архангай 16.7, Өвөрхангай 9.1, Завхан 8.1, пунктээр буурсан нь бусдаас илүү ахицтай байна. Гэтэл энэ үзүүлэлт Сэлэнгэд 12.3, Дорноговьд 8.2 пунктээр нэмэгдсэн зэргээс үзэхэд хатуу хог хаягдлыг ялгах, дахин ашиглах зэрэг үр ашигтай хэлбэрийг нэмэгдүүлэх, хөрсний бохирдолд хор хөнөөл багтай арга хэмжээг нэн даруй нэвтрүүлэх шаардлагатай байгаа аж. Хатуу хог хаягдлыг зайлуулах хэлбэр аймаг, нийслэл, хот, хөдөөд нэлээд ялгаатай байна (Хавсралт 11,12)

**Бохир ус зайлуулалт.** Гэрт амьдардаг өрхүүдээс бохир усаа задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 2.8 пунктээр буурсны дотор Хөвсгөл 12.0, Завхан 11,7, Архангай 8.5 пунктээр буурсан нь бусдаас илүү ахицтай бууруулж чадсан аж. Гэтэл энэ үзүүлэлт хоёр тооллогын хооронд Говьсүмбэрт 14.3, Өмнөговьд 4.7, Баян-Өлгийд 3.8 пунктээр өссөн нь өмнөх амжилтаасаа ухарсан гэсэн үг юм. Бохир ус зайлуулалт аймаг нийслэл хот, хөдөөгөөр (Хавсралт 13).

**Ундны усны баталгаат эх үүсвэр.** Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гэрт амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэрийг өмнөх тооллогынхоос ихээхэн дэлгэрүүлж тодорхойлсон байна. Гэхдээ ундны усны баталгаат, баталгаагүй эх үүсвэрийн талаарх ойлголт тодорхойлолт нь өмнөх тооллогынхтой ижил юм. Гэрт амьдардаг өрхийн ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн болон бие даасан систем, хамгаалагдсан худаг, цэвэршүүлж савласан усыг хамааруулж ойлгодог. Харин баталгаагүй эх үүсвэрт хамгаалагдаагүй худаг, булаг шанд, гол мөрөн зэрэг бусад эх үүсвэрийг хамруулж ойлгодог. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гэрт амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэрийг сууц дотроо, сууцны гадна гэж хоёр ангилсан нь өмнөх





тооллогуудад байгаагүй ойлголт юм. Үүнд: сууц дотроо гэсэн ойлголтод өрх ундны усаа төвлөрсөн болон бие даасан системээс хангадаг бол сууц дотроо гэж, харин үүнээс бусдыг сууцны гаднах эх үүсвэр гэж үзсэн аж.

#### ХҮСНЭГТ 4.9 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ГАДНАХ УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮВЭРЭЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Ундны усны эх үүсвэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	342 409	100.0	149 873	100.0	192 536	100.0
Хамгаалагдсан гүний худаг	187 025	54.6	124 822	83.3	62 203	32.3
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийтийн ус түгээх байр	15 224	4.4	14 130	9.4	1094	0.6
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр	9 677	2.8	9 037	6.0	640	0.3
Хамгаалагдсан гар худаг	3 201	0.9	417	0.3	2 784	1.4
Хамгаалагдсан булаг, шанд	874	0.3	51	0.0	823	0.4
Хамгаалагдаагүй гүний худаг	785	0.2	97	0.1	688	0.4
Хамгаалагдаагүй гар худаг	46 050	13.4	98	0.1	45 952	23.9
Хамгаалагдаагүй булаг, шанд	9 167	2.7	358	0.2	8 809	4.6
Зөөврийн усны үйлчилгээ	1 295	0.4	708	0.5	587	0.3
Ердийн хөсгөөрх зөөврийн ус	378	0.1	32	0.0	346	0.2
Савласан ус	61	0.0	38	0.0	23	0.0
Хурын ус	758	0.2	-	-	758	0.4
Усны ил эх үүсвэр (гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм)	67 847	19.8	63	0.0	67 784	35.2
Бусад	67	0.0	22	0.0	45	0.0

Ундны усаа гаднах эх үүсвэрээс авдаг гэрт амьдардаг нийт өрхийн 63.0 хувь нь ундны усны баталгаатай эх үүсвэрээс усаа авч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 7.3 пунктээр өссөний дотор хотын өрхийн 99 хувь, хөдөөгийн өрхийн 35 хувь нь баталгаат эх үүсвэрээс ундны усаа авч байна.

Гэвч хөдөөгийн өрхийн 35.2 хувь нь ундны усны ил эх үүсвэр болох гол мөрөн, булаг шанд, нуур цөөрмөөс усаа авч байгаа нь манай орны хувьд ундны цэвэр усаар хангагдаж байгаа гэж үзэж болох юм.

Ингэж тооцвол хөдөөгийн өрхийн 70 гаруй хувь нь ундны цэвэр усаар хангагдсан гэж ойлгож болох талтай. Улсын хэмжээний энэхүү байдал нь аймаг, нийслэлд нэлээд ялгаатай байна.



#### ХҮСНЭГТ 4.10. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮВЭРЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	Өрхийн тоо-бүгд	БАТАЛГААТ ЭХ ҮҮСВЭР		БАТАЛГААГҮЙ ЭХ ҮҮСВЭР		БАТАЛГААТ БОЛОН, ИЛ ЗАДГАЙ ЭХ ҮҮСВЭР	
		Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	342 409	216 062	63.1	126 347	36.9	283 909	82.9
Архангай	19 067	4 372	22.9	14 695	77.1	18 709	98.1
Баян-Өлгий	740	165	22.3	575	77.7	722	97.6
Баянхонгор	20 016	7 540	37.7	12 476	62.3	7 925	39.6
Булган	9 279	1 979	21.3	7 300	78.7	8 947	96.4
Говь-Алтай	12 895	4 822	37.4	8 073	62.6	4 870	37.8
Дорноговь	8 273	4 068	49.2	4 205	50.8	4 068	49.2
Дорнод	8 035	7 808	97.2	227	2.8	7 846	97.6
Дундговь	11 091	3 664	33.0	7 427	67.0	3 664	33.0
Завхан	13 571	4 040	29.8	9 531	70.2	13 019	95.9
Өвөрхангай	22 816	8 665	38.0	14 151	62.0	15 508	68.0
Өмнөговь	15 506	8 357	53.9	7 149	46.1	8 359	53.9
Сүхбаатар	11 395	3 806	33.4	7 589	66.6	3 809	33.4
Сэлэнгэ	6 580	6 431	97.7	149	2.3	6 479	98.5
Төв	16 114	15 814	98.1	300	1.9	15 898	98.7
Увс	17 190	8 514	49.5	8 676	50.5	16 885	98.2
Ховд	15 636	6 647	42.5	8 989	57.5	15 279	97.7
Хөвсгөл	17 962	4 608	25.7	13 354	74.3	17 004	94.7
Хэнтий	14 909	14 483	97.1	426	2.9	14 620	98.1
Дархан-Уул	3 775	3 750	99.3	25	0.7	3 756	99.5
Орхон	4 447	4 432	99.7	15	0.3	4 438	99.8
Говьсүмбэр	1 863	1 040	55.8	823	44.2	1 042	55.9
Улаанбаатар	91 249	91 057	99.8	192	0.2	91 062	99.8

Гэрт амьдардаг нийт өрхөд ундны усны баталгаат эх үүсвэрээр хангагдсан өрхийн эзлэх хувь улсын хэмжээнд 63.1 хувь байгаагийн дотор Улаанбаатар, Орхон, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгууд 90-ээс дээш хувь байгаа нь ундны цэвэр усаар хангагдсан гэж үзэж болохоор байна. Гэвч Архангай, Баян-Өлгий, Булган зэрэг аймгуудад энэ үзүүлэлт тун хангалтгүй байна.

Олон улсын жишиг аргачлалд ил задгай эх үүсвэрээс усаа авдаг өрхүүдийг ундны усны баталгаагүй эх үүсвэр гэж үздэг боловч манай орны хувьд байгалийн цэнгэг устай гол мөрөн, булаг шандаас ундны усныхаа хэрэгцээг хангаж байгаа өрхүүдийн хувьд бас цэвэр ус хэрэглэдэг гэж үзэж болох юм. Ингэж үзвэл 14 аймгийн 90 гаруй хувь нь ундны цэвэр ус хэрэглэдэг гэж үзэх үндэс бий юм. Гэвч зах зээлд шилжсэн сүүлийн 30 орчим жилд уул уурхайн үйлдвэрлэл хөгжиж, гол мөрөн, булаг шандыг ихээр бохирдуулж байгааг харгалзан үзвэл ундны усны ил задгай эх үүсвэрийг баталгаат эх үүсвэрт тооцдоггүй олон улсын жишиг аргачлалыг баримтлах нь зүйн асуудал юм.

Гэрт амьдардаг нийт өрхөд усаа 200 метрээс бага зайнаас зөөдөг өрхийн эзлэх хувь улсын хэмжээнд 33.3, хотод 47.3, хөдөөд 23.3 хувь байна. Харин усаа 1000 метр түүнээс хол зайнаас зөөдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээнд 18.2, хотод 3.0, хөдөөд 28.9 хувь байна.



**ХҮСНЭГТ 4.10 а. ГЭРТ АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, УНДНЫ УСАА ЗӨӨДӨГ ЗАЙ, МЕТРЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД	УСАА АВДАГ ЗАЙ, МЕТРЭЭР			
		200 хүртэл	200-500	500-1000	1000+
БҮГД	100.0	23.3	26.4	21.4	28.9
Архангай	100.0	19.3	31.3	20.9	28.5
Баян-Өлгий	100.0	47.7	18.2	13.6	20.5
Баянхонгор	100.0	14.9	21.5	23.2	40.4
Булган	100.0	13.9	18.3	24.8	43.0
Говь-Алтай	100.0	21.8	31.0	23.4	23.9
Дорноговь	100.0	30.8	26.8	23.6	18.8
Дорнод	100.0	10.5	18.7	23.0	47.8
Дундговь	100.0	47.1	32.6	13.2	7.1
Завхан	100.0	14.4	23.7	26.8	35.0
Өвөрхангай	100.0	20.6	31.9	26.4	21.1
Өмнөговь	100.0	19.5	22.7	19.0	38.8
Сүхбаатар	100.0	41.9	22.2	15.0	20.9
Сэлэнгэ	100.0	20.6	23.3	20.8	35.2
Төв	100.0	32.1	32.2	14.9	20.8
Увс	100.0	43.7	28.6	16.6	11.1
Ховд	100.0	25.4	30.6	24.1	19.9
Хөвсгөл	100.0	18.1	28.0	22.2	31.7
Хэнтий	100.0	46.5	28.3	8.7	16.5
Дархан-Уул	100.0	8.5	15.9	22.4	53.2
Орхон	100.0	65.3	27.8	4.2	2.8
Говьсүмбэр	100.0	22.0	22.0	25.7	30.3

Гэрт амьдардаг хөдөөгийн өрхүүдээс ундны усаа 1000 метрээс хол зайнаас зөөдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Дархан-Уул, Булган, Баянхонгор, Өмнөговь, Сэлэнгэ аймгууд бусдаас өндөр байна.

**Гэрт амьдардаг өрхийн ахуй нөхцөлөөр хангагдсан байдал**

Хүн ам, орон сууцны сүүлийн хоёр тооллогын дүнгээс өрхийн ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг сонгон нэгтгэж, өрх ахуйн нөхцөлөөр хир хангагдсан байдлыг өмнөх бүлгүүдэд тодорхойлсны адил гэрт амьдардаг өрхүүдийг мөн тодорхойлохыг оролдсон болно. Гэхдээ хоёр тооллогын хуудасны асуултын хариултын ялгаатай байдлаас хамааран байшинд амьдардаг өрхийнхтэй адил гэрт амьдардаг өрхөд олон шалгуур тавиагүй юм. Үүнд:

**Ц-** Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан байдал. Үүнд: өрхийн цахилгааны эх үүсвэрийн төрөл хэлбэрээс үл хамааран цахилгааны ямар нэг эх үүсвэртэй бол цахилгаанаар хангагдсан гэж үзсэн.

**У-** Усан хангамж. Үүнд: ундны усны баталгаат эх үүсвэртэй өрхүүдийг хамруулах ёстой боловч Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын хуудсанд гэрт амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэрийг сууц дотроо, сууцны гадна гэж ангилан сууцны гаднах эх үүсвэрийг нэлээд дэлгэрэнгүй тодорхойлсныг өмнө нь тэмдэглэсэн. Харин 2020 оны тооллогын хуудасны асуултын хариултаас ундны усны баталгаат эх үүсвэрийн талаарх хариултыг шууд авах боломжгүй учраас гэрт амьдардаг өрхүүдийн хувьд хүснэгт 4.15-д ундны усны эх үүсвэрийг тодорхойлсон байдлаар авав.

**Ж-** Бие засах газрын төрөл. Үүнд: бие засах газрын бохир зайлуулалт нь төвлөрсөн системд холбогдсон, битүү тунгаагуурт урсгадаг, энгийн нүхэн



жорлонтой өрхүүдээс сайжруулсан болон био жорлонтой өрхүүдийг хамруулсан. Гэвч өнгөрсөн тооллогын үед гэрт амьдардаг өрхүүдээс жорлонгоо дангаараа ашигладаг бол ахуй нөхцөл хангагдсан гэж үзэж байсан. Харин 2020 тооллогын дүнгээр гэрт амьдардаг өрхүүдийн энгийн нүхэн жорлонг ахуй нөхцөл хангасан гэж үзээгүй. Учир нь өмнөх бүлэгт дурдсантай адил энгийн нүхэн жорлон хөрс гадаргын усыг ихээр бохирдуулдаг нь шинжлэх ухааны үндэслэлтэй олон судалгаагаар нэгэнт нотлогдсон тул оруулаагүй.

**Б-Бохир ус зайлуулалт.** Үүнд: бохир усаа төвлөрсөн болон бие даасан системтэй болон тусгай цооногтой өрхүүдийг хамруулсан.

**Х- Хатуу хог, хаягдал зайлуулалт.** Үүнд: хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг, зөвшөөрөгдсөн цэгт хаядаг өрхүүдийг тус тус хамруулав. Эдгээр нь өмнөх тооллогынхтой ихэнхдээ тохирч байгаа боловч зарим нэг үзүүлэлт арай зөрүүтэйг анхаарах нь зүйтэй.

Гэрт амьдардаг өрхийг ахуйн нөхцөлийг хангасан байдлыг байшинд амьдардаг өрхөөс арай өөрөөр дараах хэдэн ангилал болгож үзэв. Үүнд:

- Ахуйн гурван нөхцөл хангагдсан.
- Ахуйн 2-нөхцөл хангагдсан
- Ахуйн 1-нөхцөл хангагдсан
- Ахуйн нөхцөл хангаагүй

Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн гурван нөхцөл хангасан өрх тун цөөн, бүх өрхөд эзлэх хувь улсын дүнгээр 0.1, хотын өрхүүдийн хувьд 0.2 хувь байгаа болно. Энэ нь дээр тэмдэглэсэнчлэн ундны усны баталгаат эх үүсвэр, энгийн нүхэн жорлонтой өрхүүд ахуйн нөхцөл хангасан үзүүлэлтэд ороогүйтэй холбоотой.

#### **ХҮСНЭГТ 4.11 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХҮҮДЭЭС АХУЙН ХОЁР НӨХЦӨЛ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	2 нөхцөл хангасан өрх	Хувь	Өрхийн тоо	2 нөхцөл хангасан өрх	Хувь	Өрхийн тоо	2 нөхцөл хангасан өрх	Хувь
Бүгд	342 409	206 705	60.4	149 873	142 461	95.1	192 536	64 244	33.4
Архангай	19 067	4 166	21.8	1 612	1 417	87.9	17 455	2 749	15.7
Баян-Өлгий	740	272	36.8	121	110	90.9	619	162	26.2
Баянхонгор	20 016	8 332	41.6	5 400	5 118	94.8	14 616	3 214	22.0
Булган	9 279	3 212	34.6	619	375	60.6	8 660	2 837	32.8
Говь-Алтай	12 895	6 115	47.4	3 260	3 043	93.3	9 635	3 072	31.9
Дорноговь	8 035	3 882	48.3	2 365	2 124	89.8	5 670	1 758	31.0
Дорнод	11 091	5 475	49.4	2 046	2 033	99.4	9 045	3 442	38.1
Дундговь	13 571	6 597	48.6	1 856	1 794	96.7	11 715	4 803	41.0
Завхан	22 816	9 963	43.7	3 820	3 757	98.4	18 996	6 206	32.7
Өвөрхангай	15 506	10 738	69.3	5 217	5 097	97.7	10 289	5 641	54.8
Өмнөговь	11 395	4 517	39.6	1 648	1 599	97.0	9 747	2 918	29.9
Сүхбаатар	6 580	3 731	56.7	1 176	654	55.6	5 404	3 077	56.9
Сэлэнгэ	16 114	8 265	51.3	1 619	1 574	97.2	14 495	6 691	46.2
Төв	17 190	8 736	50.8	5 550	5 267	94.9	11 640	3 469	29.8
Увс	15 636	7 638	48.8	4 105	3 912	95.3	11 531	3 726	32.3
Ховд	17 962	6 368	35.5	3 011	2 365	78.5	14 951	4 003	26.8
Хөвсгөл	14 909	7 868	52.8	4 501	3 708	82.4	10 408	4 160	40.0
Хэнтий	3 775	2 757	73.0	2 863	2 402	83.9	912	355	38.9
Дархан-Уул	8 273	4 341	52.5	3 080	2 896	94.0	5 193	1 445	27.8
Орхон	4 447	4 080	91.7	3 874	3 853	99.5	573	227	39.6
Говьсүмбэр	1 863	1 122	60.2	881	833	94.6	982	289	29.4
Улаанбаатар	91 249	88 530	97.0	91 249	88 530	97.0	-	-	-



Гэрт амьдардаг өрхүүдээс цахилгаантай, хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг эсвэл тогтсон цэгт асгаж, тодорхой хугацаанд зайлуулдаг өрхүүд хамрагдсан байна. Ийм өрхүүд улсын дунджаар 60.4 хувь байгаагийн дотор 50 –иас дээш хувьтай байгаа аймаг нийслэл 10, 40-өөс доош хувьтай аймаг, 4 байгаа юм. Хотын өрхүүдээс улсын дунджаар 95.1 хувь нь байгаагийн дотор 90-ээс дээш хувьтай аймаг, нийслэл 14. байгаа бол Булган, Сүхбаатар аймгууд сүүл мушгиж байгааг эдгээр аймгийн төр захиргааны байгууллагууд анхаарах нь зүйтэй.

#### ХҮСНЭГТ 4.12. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХҮҮДЭЭС АХУЙН НЭГ НӨХЦӨЛ ХАНГАСАН ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Нэг нөхцөл хангасан өрх	Хувь	Өрхийн тоо	Нэг нөхцөл хангасан өрх	Хувь	Өрхийн тоо	Нэг нөхцөл хангасан өрх	Хувь
Бүгд	342 409	130 940	38.2	149 873	6 073	4.1	192 536	124 867	64.9
Архангай	19 067	14 552	76.3	1 612	159	9.9	17 455	14 393	82.5
Баян-Өлгий	740	433	58.5	121	11	9.1	619	422	68.2
Баянхонгор	20 016	11 448	57.2	5 400	276	5.1	14 616	11 172	76.4
Булган	9 279	5 856	63.1	619	223	36.0	8 660	5 633	65.0
Говь-Алтай	12 895	6 562	50.9	3 260	202	6.2	9 635	6 360	66.0
Дорноговь	8 035	3 976	49.5	2 365	239	10.1	5 670	3 737	65.9
Дорнод	11 091	5 502	49.6	2 046	4	0.2	9 045	5 498	60.8
Дундговь	13 571	6 849	50.5	1 856	59	3.2	11 715	6 790	58.0
Завхан	22 816	12 608	55.3	3 820	45	1.2	18 996	12 563	66.1
Өвөрхангай	15 506	4 467	28.8	5 217	105	2.0	10 289	4 362	42.4
Өмнөговь	11 395	6 865	60.2	1 648	49	3.0	9 747	6 816	69.9
Сүхбаатар	6 580	2 730	41.5	1 176	512	43.5	5 404	2 218	41.0
Сэлэнгэ	16 114	7 819	48.5	1 619	45	2.8	14 495	7 774	53.6
Төв	17 190	8 408	48.9	5 550	271	4.9	11 640	8 137	69.9
Увс	15 636	7 567	48.4	4 105	164	4.0	11 531	7 403	64.2
Ховд	17 962	11 097	61.8	3 011	602	20.0	14 951	10 495	70.2
Хөвсгөл	14 909	6 667	44.7	4 501	759	16.9	10 408	5 908	56.8
Хэнтий	3 775	971	25.7	2 863	440	15.4	912	531	58.2
Дархан-Уул	8 273	3 831	46.3	3 080	168	5.5	5 193	3 663	70.5
Орхон	4 447	357	8.0	3 874	18	0.5	573	339	59.2
Говьсүмбэр	1 863	691	37.1	881	38	4.3	982	653	66.5
Улаанбаатар	91 249	1 684	1.8	91 249	1 684	1.8	-	-	-

Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн нэг нөхцөл хангасан өрхүүд гэдэг нь үндсэндээ цахилгаантай өрхүүд юм.

Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн нэг нөхцөл буюу цахилгаанаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 16.8 пунктээр өссөний дотор Дархан-Уул 40.3, Өмнөговь 40.0, Архангай 39.3, Дорнод 30.5, Булган 31.0 пунктээр өсөн нь бусдаас өндөр байна. Гэтэл энэ үзүүлэлт Хэнийд 5.8, Сүхбаатарт 2.6 өссөн нь бусдаас бага байгаа юм. Харин Өвөрхангайд энэ үзүүлэлт өмнөх тооллогын үеийнхээс 4.7 пунктээр буурсан нь ихээхэн анхаарал татаж байна.



Гэрт амьдардаг хотын өрхүүдээс ахуйн нөхцөлийн нэг үзүүлэлт хангасан өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дүнгээр 1.1 пунктээр өссөний дотор Сүхбаатар 29.4, Булган 26.4, Ховд 19.8 пунктээр тус тус өссөн нь бусдаас өндөр өсөлттэй байна. Харин энэ үзүүлэлт өнгөрсөн тооллогын үеийнхээс Дундговь 11.1, Төв 10.5 пунктээр буурсан аж.

#### ХҮСНЭГТ 4.13. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХҮҮДЭЭС АХУЙН НӨХЦӨЛ ХАНГАГДААГҮЙ ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН


Аймаг, нийслэл	БҮГД			ХОТ			ХӨДӨӨ		
	Өрхийн тоо	Ахуйн нөхцөл хангаагүй өрх	Хувь	Өрхийн тоо	Ахуйн нөхцөл хангаагүй өрх	Хувь	Өрхийн тоо	Ахуйн нөхцөл хангаагүй өрх	Хувь
Бүгд	342 409	3 190	0.9	149 873	273	0.2	192 536	2 917	1.5
Архангай	19 067	286	1.5	1 612	18	1.1	17 455	268	1.5
Баян-Өлгий	740	28	3.8	121	-	-	619	28	4.5
Баянхонгор	20 016	203	1.0	5 400	-	-	14 616	203	1.4
Булган	9 279	156	1.7	619	16	2.6	8 660	140	1.6
Говь-Алтай	12 895	200	1.6	3 260	12	0.4	9 635	188	2.0
Дорноговь	8 035	152	1.9	2 365	-	-	5 670	152	2.7
Дорнод	11 091	90	0.8	2 046	1	0.0	9 045	89	1.0
Дундговь	13 571	92	0.7	1 856	1	0.1	11 715	91	0.8
Завхан	22 816	201	0.9	3 820	1	0.0	18 996	200	1.1
Өвөрхангай	15 506	249	1.6	5 217	4	0.1	10 289	245	2.4
Өмнөговь	11 395	13	0.1	1 648	-	-	9 747	13	0.1
Сүхбаатар	6 580	80	1.2	1 176	7	0.6	5 404	73	1.4
Сэлэнгэ	16 114	15	0.1	1 619	-	-	14 495	15	0.1
Төв	17 190	31	0.2	5 550	4	0.1	11 640	27	0.2
Увс	15 636	354	2.3	4 105	1	0.0	11 531	353	3.1
Ховд	17 962	430	2.4	3 011	34	1.1	14 951	396	2.6
Хөвсгөл	14 909	312	2.1	4 501	19	0.4	10 408	293	2.8
Хэнтий	3 775	30	0.8	2 863	9	0.3	912	21	2.3
Дархан-Уул	8 273	84	1.0	3 080	8	0.3	5 193	76	1.5
Орхон	4 447	7	0.2	3 874	-	-	573	7	1.2
Говьсүмбэр	1 863	42	2.3	881	3	0.3	982	39	4.0
Улаанбаатар	91 249	135	0.1	91 249	135	0.1	-	-	-

Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн нөхцөл хангаагүй өрх гэдэг нь үнэндээ цахилгаан ч үгүй өрхүүд юм. Ийм өрхүүдийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 2.5 пунктээр буурсны дотор Дорноговь 5.7, Архангай 5.5, Сүхбаатар 5.0 пунктээр тус тус буурсан нь бусдаас илүү их буурсан сайн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт хөдөөгийн өрхийн хувьд улсын дунджаар 4.6, Баян-Өлгий 11.7, Дорноговь 9.9, Сүхбаатар 6.0 пунктээр буурсан нь бусдаас илүү буурсан аж.

Гэрт амьдардаг өрхүүдээс ахуйн нэг ч нөхцөл хангаагүй өрхийн 91.4 хувь нь хөдөө орон нутагт байна.



### ЗУРАГ 4.3 ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙ НӨХЦӨЛ ХАНГАСАН БАЙДАЛ ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН



Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах үндсэн нөхцөлүүд нь ундны усны баталгаат эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр байгаль орчинд хор хөнөөл аль болох багатай бие засах газрын төрлүүдийн нэмэгдүүлэх ялангуяа төв суурин газрын бие засах газар, бохир ус зайлуулах арга ажиллагааг улам төгөлдөржүүлэх шаардлагатай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.





# ТАВДУГААР БҮЛЭГ

**ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД  
СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО,  
АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ**



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй, эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууцыг бусад сууц гэж үзсэн. Үүнд: Тооллогын үед сургууль, аж ахуйн нэгж, байгууллагын хэсэг буюу өрөө тасалгаа, мөн байнгын бус түр орогнох байр зэрэгт айл өрх, хүн амьдарч байсан тохиолдлыг хамруулсан.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр зориулалтын бус, бусад сууцанд 8 039 өрх амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 97 өрхөөр цөөн байна.

Хүн амьдрах үндсэн нөхцөлийн нэг нь өөрийн өмчийн орон сууцтай байх нь өрхийн гишүүдийн амьдралын нэг чухал асуудал юм. Төр засгийн шат шатны байгууллага болон иргэд өөрсдөө анхаарч хүчин чармайлт гаргасны үр дүнд иргэд өөрийн өмчийн сууцтай болох үйл ажиллагаанд сүүлийн хоёр тооллогын хооронд ахиц гарсан нь хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс харагдаж байна.

#### **ХҮСНЭГТ 5.1.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ӨМЧИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2010, 2020 ОН**

Сууцны өмчийн хэлбэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	8,136	100.0	6643	100.0	1,493	100.0
Төрийн өмч	940	11.6	583	8.8	357	23.9
ААНБ-ын (Хувийн)	3,238	39.8	2913	43.9	325	21.8
Иргэний	3,958	48.6	3147	47.4	811	54.3
2020						
БҮГД	8039	100.0	4771	100.0	3268	100.0
Төрийн өмч	189	2.4	57	1.2	132	4.0
ААНБ-ын (Хувийн)	151	1.9	89	1.9	62	1.9
Иргэний	7699	95.8	4625	96.9	3074	94.1

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцных нь өмчлөлийн хэлбэр 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс нэлээд өөрчлөгдөж, төрийн өмчийн сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин буурч, харин иргэний өмчийн сууцны хувийн жин 47.2 пунктээр өссөн байна. Энэ үзүүлэлт хот, хөдөөд мөн нэг адил өөрчлөгдсөн байна.



**ХҮСНЭГТ 5.2. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨМЧИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД	ҮҮНЭЭС:ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР		
		Төрийн өмчийн	ААНБ-ын (Хувийн)	Иргэний
БҮГД	100.0	2.4	1.9	95.8
Архангай	100.0	-	-	100.0
Баян-Өлгий	100.0	0.3	4.3	95.4
Баянхонгор	100.0	1.7	1.1	97.2
Булган	100.0	1.4	0.7	97.9
Говь-Алтай	100.0	8.6	-	91.4
Дорноговь	100.0	16.2	-	83.8
Дорнод	100.0	1.0	1.8	97.1
Дундговь	100.0	11.6	4.2	84.2
Завхан	100.0	1.5	0.4	98.1
Өвөрхангай	100.0	2.4	-	97.6
Өмнөговь	100.0	6.9	2.0	91.2
Сүхбаатар	100.0	9.1	1.8	89.1
Сэлэнгэ	100.0	1.3	3.6	95.1
Төв	100.0	1.6	0.3	98.1
Увс	100.0	3.5	0.7	95.8
Ховд	100.0	1.5	1.0	97.5
Хөвсгөл	100.0	1.9	1.9	96.1
Хэнтий	100.0	5.3	3.3	91.4
Дархан-Уул	100.0	0.9	3.5	95.6
Орхон	100.0	0.8	3.9	95.3
Говьсүмбэр	100.0	13.7	1.1	85.3
Улаанбаатар	100.0	0.6	2.4	97.0

Ихэнх аймаг, нийслэлд зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 90-ээс дээш хувь нь өөрийн өмчийн сууцтай болсон байна. Гэвч энэ үзүүлэлт Дундговь, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг бусдаас доогуур хувьтай байна

Өрхийн өмчлөлийн хэлбэр эзэмшлийн хэлбэр хоёр нэлээд ялгаатай үзүүлэлт гэдгийг өмнөх бүлгүүдэд онцлон тэмдэглэсэн билээ. Зориулалтын бус, бусад сууцанд амьдарч байгаа өрхүүдээс хэд нь өөрийн гэсэн сууцтай эсэхийг сууцны эзэмшлийн хэлбэрээр тодорхойлдог.

**ХҮСНЭГТ 5.3. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН**

Сууцны өмчийн хэлбэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	8 136	100.0	6 643	100.0	1 493	100.0
Өөрийн эзэмшлийн	2 557	31.4	1 903	28.6	654	43.8
Бусдын сууцанд түрээстэй	2 257	27.8	2 011	30.3	246	16.5
Бусдын сууцанд түрээсгүй	2 029	24.9	1 586	23.9	443	29.7
Бусад	1 293	15.9	1 143	17.2	150	10.0
2020						
БҮГД	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Өөрийн эзэмшлийн	6 475	80.5	3 897	81.7	2 578	78.9
Бусдын сууцанд түрээстэй	482	6.0	307	6.4	175	5.4
Бусдын сууцанд түрээсгүй	991	12.3	509	10.7	482	14.7
Бусад	91	1.1	58	1.2	33	1.0



Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн өмчлөлийн асуудал 2020 онд 2010 оныхоос ихээхэн ахицтай байсны нэг адил сууцны эзэмшилд ч мөн ихээхэн өөрчлөлт гарсан байна. Өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд 2010 оныхоос 49.1 пунктээр өссөн нь хот, хөдөөд ч мөн адил өссөн байна.

#### ХҮСНЭГТ 5.4.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ҮҮНЭЭС:ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭЭР			
		Өөрийн	Бусдын сууцанд түрээстэй	Бусдын сууцанд түрээсгүй	Бусад
БҮГД	100.0	80.5	6.0	12.3	1.1
Архангай	100.0	93.8	1.8	3.5	0.9
Баян-Өлгий	100.0	60.8	5.8	31.6	1.8
Баянхонгор	100.0	95.5	1.1	3.4	0.0
Булган	100.0	84.0	3.5	12.0	0.5
Говь-Алтай	100.0	87.1	2.6	8.6	1.7
Дорноговь	100.0	64.1	17.0	18.5	0.4
Дорнод	100.0	74.5	3.0	22.2	0.3
Дундговь	100.0	74.7	11.6	12.6	1.1
Завхан	100.0	92.4	2.7	5.0	0.0
Өвөрхангай	100.0	92.7	2.4	4.4	0.4
Өмнөговь	100.0	79.9	11.3	7.8	1.0
Сүхбаатар	100.0	70.9	3.6	20.0	5.5
Сэлэнгэ	100.0	75.6	7.4	15.9	1.0
Төв	100.0	83.9	3.2	12.5	0.3
Увс	100.0	93.7	0.7	3.5	2.1
Ховд	100.0	96.0	0.5	3.2	0.3
Хөвсгөл	100.0	82.0	4.4	12.8	0.8
Хэнтий	100.0	65.1	6.0	22.9	6.0
Дархан-Уул	100.0	82.5	3.1	14.0	0.4
Орхон	100.0	89.8	2.4	5.5	2.4
Говьсүмбэр	100.0	57.9	4.2	34.7	3.2
Улаанбаатар	100.0	78.5	10.1	10.0	1.3

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдээс өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь, өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр болон олон аймагт өссөн нь ихээхэн дэвшил юм. Гэхдээ нийт өрхөд өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн эзлэх хувь 6 аймагт 90-ээс дээш байна. Харин Баян-Өлгий, Дорноговь, Хэнтий, Говьсүмбэр аймгуудад энэ үзүүлэлт 70-аас доош хувь байгааг холбогдох аймгуудын төр, захиргааны байгууллагууд анхаарах нь зүйтэй.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өөрийн гэсэн сууцгүй өрхийн тоо улсын хэмжээнд 1564 байгаагийн дотор Улаанбаатарт 478, Дорнодод 152, Баян-Өлгийд 129, Хөвсгөлд 111, Хэнтийд 105 байгаа нь бусдаас олон байна.



## ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛ, ДЭД БҮТЭЦ

**Ундны усны эх үүсвэр.** Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод зориулалтын бус, бусад сууцны ундны усны эх үүсвэрийг 2010 оны тооллогынхоос арай өөрөөр тодорхойлсон. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогод ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан булаг шандаас усаа авдаг болон цэвэршүүлж савласан ус хэрэглэдэг өрхийг хамруулж байсан. Ингэж тооцож үзэхэд 2010 онд зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 70.9 хувь нь ундны усны баталгаат эх үүсвэрээр хангагдсан байжээ. Харин хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод төвлөрсөн болон бие даасан систем, зөөврийн гэж ангилсан байна.

### ХҮСНЭГТ 5.5.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Усан хангамжийн төрөл	БҮГД		ХОТ		Хөдөө	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	679	8.4	612	12.8	67	2.1
Бие даасан систем - халуун, хүйтэн устай	23	0.3	16	0.3	7	0.2
Зөөврийн	7 058	87.8	3 928	82.3	3 130	95.8
Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай	216	2.7	185	3.9	31	0.9
Бие даасан систем - хүйтэн устай	63	0.8	30	0.6	33	1.0

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн 12.2 хувь нь төвлөрсөн болон төвлөрсөн бус усан хангамжтай сууцанд амьдарч байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн ундны усны хангамжийг сууц дотроо, сууцны гадна гэж ангилснаас үзэхэд сууц дотроо буюу төвлөрсөн системд холбогдсон өрх 77 байна. Бусад нь сууцны гаднаас ундны усаа авдаг байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг, сууцны гаднаас усаа авдаг өрхүүдийн 95.8 хувь нь ундны усны баталгаат эх үүсвэртэй гэж үзэж болох юм, Үүнийг 2010 оны тооллогын дүнтэй зэрэгцүүлэхэд 24.9 пунктээр өссөн байна. Энэ үзүүлэлт хотод 99.1 хувь, хөдөөд 91.1 хувь байна.



**ХҮСНЭГТ 5.6.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ ГАДНАХ УСАН ХАНГАМЖ ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН.**

Ундны усны эх үүсвэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	7 962	100.0	4 698	100.0	3 264	100.0
Хамгаалагдсан гүний худаг	6 540	82.1	3 861	82.2	2 679	82.1
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон нийтийн ус түгээх байр	417	5.2	415	8.8	2	0.1
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нийтийн ус түгээх байр	269	3.4	268	5.7	1	0.0
Хамгаалагдсан гар худаг	401	5.0	111	2.4	290	8.9
Хамгаалагдсан булаг, шанд	2	0.0	1	0.0	1	0.0
Хамгаалагдаагүй гүний худаг	1	0.0	-	-	1	0.0
Хамгаалагдаагүй гар худаг	18	0.2	1	0.0	17	0.5
Хамгаалагдаагүй булаг, шанд	2	0.0	2	0.0	-	-
Зөөврийн усны үйлчилгээ	108	1.4	33	0.7	75	2.3
Ердийн хөсгөөрх зөөврийн ус	1	0.0	1	0.0	-	-
Усны ил эх үүсвэр (гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм)	198	2.5	1	0.0	197	6.0
Бусад	5	0.1	4	0.1	1	0.0

**ХҮСНЭГТ 5.7.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР(СУУЦНЫ ГАДНАХ УСАН ХАНГАМЖТАЙ), ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН.**

Аймаг, нийслэл	БҮГД		БАТАЛГААТ ЭХ ҮҮСВЭР		БАТАЛГААГҮЙ ЭХ ҮҮСВЭР	
	Өрхийн тоо	Бүгд дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгд дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Бүгд дүнд эзлэх хувь
БҮГД	7 962	100.0	7629	95.8	333	4.2
Архангай	227	100.0	227	100.0	-	-
Баян-Өлгий	328	100.0	130	39.6	198	60.4
Баянхонгор	178	100.0	129	72.5	49	27.5
Булган	431	100.0	431	100.0	-	-
Говь-Алтай	116	100.0	87	75.0	29	25.0
Дорноговь	258	100.0	242	93.8	16	6.2
Дорнод	593	100.0	589	99.3	4	0.7
Дундговь	95	100.0	95	100.0	-	-
Завхан	262	100.0	260	99.2	2	0.8
Өвөрхангай	248	100.0	248	100.0	-	-
Өмнөговь	166	100.0	166	100.0	-	-
Сүхбаатар	55	100.0	55	100.0	-	-
Сэлэнгэ	390	100.0	390	100.0	-	-
Төв	307	100.0	307	100.0	-	-
Увс	143	100.0	143	100.0	-	-
Ховд	598	100.0	598	100.0	-	-
Хөвсгөл	613	100.0	583	95.1	30	4.9
Хэнтий	300	100.0	300	100.0	-	-
Дархан-Уул	221	100.0	221	100.0	-	-
Орхон	126	100.0	125	99.2	1	0.8
Говьсүмбэр	95	100.0	95	100.0	-	-
Улаанбаатар	2212	100.0	2208	99.8	4	0.2

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдээс ундны усны баталгаат эх үүсвэртэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 13 аймагт 100 хувь



хангагдсан сайн үзүүлэлт байгаа боловч Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай аймгууд тун хангалтгүй байгааг эдгээр аймгийн төр, захиргааны байгууллагууд онцгой анхаарах нь зүйтэй юм.

Цахилгааны эх үүсвэр. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн цахилгааны эх үүсвэрийг дулаан болон усан цахилгаан станц, дизель хөдөлгүүр, сэргээгдэх эрчим хүч, бага оврын цахилгаан үүсгүүр зэрэг эх үүсвэрээр тодорхойлсон.

**ХҮСНЭГТ 5.8.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГАНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН**

Ундны усны эх үүсвэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	8 136	100.0	6 643	100.0	1 493	100.0
Төвлөрсөн систем	7 372	90.6	6 314	95.0	1 058	70.9
Дизель станц	144	1.8	34	0.5	110	7.4
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрмж	181	2.2	24	0.4	157	10.5
Бага оврын цахилгаан үүсгүүр	62	0.8	32	0.5	30	2.0
Цахилгааны эх үүсвэргүй	377	4.6	239	3.6	138	9.2
2020						
БҮГД	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Төвлөрсөн систем	7 011	87.2	4 688	98.3	2 323	71.1
Дизель станц	10	0.1	1	0.0	9	0.3
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрмж	786	9.8	44	0.9	742	22.7
Бага оврын цахилгаан үүсгүүр	102	1.3	12	0.3	90	2.8
Цахилгааны эх үүсвэргүй	130	1.6	26	0.5	104	3.2

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдээс төвлөрсөн системд холбогдсон өрхүүдийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 3.4 пунктээр буурсан боловч хотын өрхүүдэд 3.3, хөдөөгийн өрхүүдэд 0.2 пунктээр өссөн аж. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүд дизель станцаас цахилгаанаар хангагдах нь эрс багасаж, харин сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглах нь илүү нэмэгдсэн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хямд эрчим хүч ашигладаг болсон нь харагдаж байна. Цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо улсын хэмжээгээр 130, үүнээс хөдөөд 104 байна.

**Халаалтын эх үүсвэр.** Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн халаалтын эх үүсвэрийг өмнөх тооллогуудад тодорхойлж байгаагүй. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод өрхүүдийн халаалтын эх үүсвэрийг сууцыг дулаан байлгах зориулалттай халаалтын системд: Байрыг бүхэлд нь халаах зориулалттай дулааны төвлөрсөн систем, нам даралтын зуух, ердийн галлагаа буюу зуух, пийшин зэргийг хамруулсан.

**ХҮСНЭГТ 5.9. ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Халаалтын төрөл	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Төвлөрсөн систем	968	12.0	812	17.0	156	4.8
Нам даралтын зуух	341	4.2	247	5.2	94	2.9
Цахилгаан халаагуур	94	1.2	84	1.8	10	0.3
Ердийн галлагаа	6 636	82.5	3 628	76.0	3 008	92.0





Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн халаалтын голлох эх үүсвэр нь ердийн галлагаа буюу зуух, пийшин байна. Энэ нь хот, хөдөөд онцын ялгаагүй байна.

**Бохир ус зайлуулалт.** Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрх хэрэглээнээс гарсан бохир усаа төвлөрсөн, бие даасан систем болон тусгайлан бэлтгэсэн цооногт эсвэл ил задгай асгадаг байдлыг тодорхойлсон нь өмнөх тооллогынхтой ижил юм.

**ХҮСНЭГТ 5.10.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БОХИР УС ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН**

Бохир ус зайлуулдаг хэлбэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	8 136	100.0	6 643	100.0	1 493	100.0
Төвлөрсөн системээр	3 249	39.9	3 224	48.5	25	1.7
Бие даасан системээр	77	0.9	61	0.9	16	1.1
Цооногт	3 133	38.5	2 182	32.8	951	63.7
Задгай	1 677	20.6	1 176	17.7	501	33.6
2020						
БҮГД	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Төвлөрсөн системээр	849	10.6	761	16.0	88	2.7
Бие даасан системээр	94	1.2	53	1.1	41	1.3
Цооногт	5 081	63.2	3 160	66.2	1 921	58.8
Задгай	2 015	25.1	797	16.7	1 218	37.3

**ХҮСНЭГТ 5.11.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, БОХИР УС ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Аймаг, нийслэл	Бүгд	БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР			
		Төвлөрсөн систем	Бие даасан систем	Цооног	Задгай
Бүгд	100.0	10.6	1.2	63.2	25.1
Архангай	100.0	7.5	-	41.4	51.1
Баян-Өлгий	100.0	1.8	0.3	41.6	56.2
Баянхонгор	100.0	11.2	-	71.5	17.3
Булган	100.0	4.9	0.7	68.8	25.7
Говь-Алтай	100.0	10.3	0.0	81.0	8.6
Дорноговь	100.0	16.2	0.8	66.8	16.2
Дорнод	100.0	5.7	-	46.4	47.9
Дундговь	100.0	20.0	-	64.2	15.8
Завхан	100.0	3.1	-	81.3	15.6
Өвөрхангай	100.0	3.6	1.2	79.0	16.1
Өмнөговь	100.0	14.7	3.9	61.3	20.1
Сүхбаатар	100.0	12.7	1.8	67.3	18.2
Сэлэнгэ	100.0	5.1	1.5	52.1	41.3
Төв	100.0	11.6	0.3	48.2	39.9
Увс	100.0	5.6	-	69.9	24.5
Ховд	100.0	12.9	3.5	58.9	24.7
Хөвсгөл	100.0	2.4	0.3	64.1	33.2
Хэнтий	100.0	4.0	1.3	60.8	33.9
Дархан-Уул	100.0	30.7	0.9	48.2	20.2
Орхон	100.0	32.3	0.8	65.4	1.6
Говьсүмбэр	100.0	9.5	1.1	82.1	7.4
Улаанбаатар	100.0	15.1	1.7	71.6	11.6



Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бохир ус зайлуулдаг хэлбэр 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс нэлээд өөрчлөгдсөн аж. Тухайлбал: төвлөрсөн системээр бохир усаа зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээнд 29.3 пунктээр буурч, задгай асгадаг өрхийн эзлэх хувь 4.5 пунктээр өссөний дотор эдгээр үзүүлэлт хот суурин газрын өрхүүдэд илүү ашиглагдаж байгаа нь байгаль орчныг бохирдуулах, орчны ариун цэвэр халдваргүйжүүлэхэд сөрөг нөлөөтэй юм. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бохир ус зайлуулдаг хэлбэр аймаг, нийслэлд ихээхэн ялгаатай, бохир усаа цооногт асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаас Говь-Алтай, Завхан, Өвөрхангай Баянхонгор, Говьсүмбэр, Улаанбаатарт ихээхэн өндөр байна. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бохир усаа цооногт асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс улсын дунджаар 24.7 пунктээр буурсны дотор Говьсүмбэр 55.1, Орхон 38.7, Дорноговь 27.7, Сүхбаатар 25.5, Дархан-Уул 23.4, Хэнтий 20.0 пунктээр тус тус буурсан нь бусдаас илүү байна. Гэвч энэ үзүүлэлт Баян-Өлгий 36.1, Хөвсгөл 18.1, Өмнөговь 17.1 пунктээр өссөн байна. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бохир усаа задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс улсын дунджаар 4.5 пунктээр буурсны дотор Баян-Өлгийд 35.4, Хөвсгөлд 17.7 пунктээр буурсан нь бусдаас өндөр байгаа боловч Дорноговьд 20.2, Хэнтийд 15.7, Улаанбаатарт 14.7 пунктээр өссөн аж. Бохир усыг цооногт асгаж байгаа нь задгай асгаж байгаагаас ариун цэвэр, хөрсний бохирдолд арай бага нөлөөтэй боловч удаан хугацаанд хөрсөнд нэвчиж бохирдуулдаг нь нэгэнт шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаагаар нотлогдсон тул цаашид цооногт болон задгайгаар бохир ус асгах явдлыг аль болох бууруулах талаар холбогдох төр захиргааны байгууллагууд анхаарах шаардлагатай юм.

**Бие засах газрын бохирыг зайлуулах хэлбэр.** Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бие засах газрын бохирыг зайлуулах хэлбэрийг өмнөх 2010 оны тооллогоор тодорхойлоогүй аж. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бие засах газрын бохирыг зайлуулдаг хэлбэрийг нэлээд нарийвчлан, төвлөрсөн системээр, цооногт, нүхэн жорлонд урсгадаг, сайжруулсан болон энгийн, био жорлон, задгай гэсэн төрлүүдээр тодорхойлсон байна.

### ХҮСНЭГТ 5.12.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БИЕ ЗАСДАГ ГАЗРЫН БОХИРЫГ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Бие засах газрын бохирыг зайлуулах хэлбэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Төвлөрсөн систем	1 151	14.3	1 053	22.1	98	3.0
Цооногт	54	0.7	44	0.9	10	0.3
Нүхэн жорлонд урсгадаг	191	2.4	79	1.7	112	3.4
Сайжруулсан жорлон	76	0.9	27	0.6	49	1.5
Энгийн нүхэн жорлон	6 271	78.0	3 531	74.0	2 740	83.8
Био жорлон	6	0.1	4	0.1	2	0.1
Задгай	290	3.6	33	0.7	257	7.9



Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бие засах газрын бохирыг зайлуулах гол хэлбэр нь энгийн нүхэн жорлон аж. Энэ үзүүлэлт хот, хөдөө, аймаг, нийслэлд онцын ялгаа ажиглагдахгүй байна. Сайжруулсан болон био жорлонг сүүлийн үед нэвтрүүлэх төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа сайн талтай боловч өргөн хүрээг хамарч чадаагүй байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.

**Хатуу хог хаягдал зайлуулалт.** Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэрийг хүн ам, орон сууцын 2020 оны тооллогоор өмнөх тооллогоос арай дэлгэрүүлж, газарт булдаг, шатаадаг гэсэн хоёр хэлбэр нэмсэн байна. Гэвч сүүлчийн энэ хоёр төрөл төдийлөн түгээмэл биш юм.

### ХҮСНЭГТ 5.13.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫГ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН

Хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэр	БҮГД		ХОТ		ХӨДӨӨ	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	8 039	100.0	4 771	100.0	3 268	100.0
Үйлчилгээний байгууллагаар	4 676	58.2	4 120	86.4	556	17.0
Зөвшөөрөгдсөн цэгт	2 261	28.1	475	10.0	1 786	54.7
Шатаадаг	10	0.1	1	0.0	9	0.3
Булдаг	10	0.1	-	-	10	0.3
Тогтсон цэг байхгүй	1 082	13.5	175	3.7	907	27.8

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэр өнгөрсөн 2010 оны тооллогынхоос нэлээд өөрчлөгдсөн аж. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн 70.5 хувь нь үйлчилгээний байгууллагуудаар хатуу хог хаягдал зайлуулдаг байсан бол энэ үзүүлэлт 2020 онд 12.3 пунктээр буурч харин зөвшөөрөгдсөн цэгт асгадаг өрхийн эзлэх хувийн жин 8.8 пунктээр өссөн байна. Харин хатуу хог хаягдлыг зайлуулдаг тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 3.3 пунктээр өссөн байна.

Ерөнхийдөө байгаль орчны бохирдолд сөрөг нөлөө бага үзүүлдэг хатуу хог хаягдлыг үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн хувийн жин буурч, харин хогоо зайлуулах тогтсон цэггүй өрхийн хувийн жин нэмэгдсэн нь анхаарах гол асуудал юм.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэр аймаг, нийслэлээр нэлээд ялгаатай, үйлчилгээний байгууллагаар хатуу хог хаягдлаа зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Нийслэл, Дархан-Уул, Орхонд илүү өндөр хувьтай байгаа нь хүн ам төвлөрсөн том хотуудад хатуу хог хаягдлыг зайлуулах нэгдсэн системтэйн давуу талыг харуулж байна. Гэвч хатуу хог хаягдлыг зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий, Архангай, Хөвсгөл аймгууд бусдаас илүү өндөр байна.



**ХҮСНЭГТ 5.14.ЗОРИУЛАЛТЫН БУС, БУСАД СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫГ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН**

Аймаг, нийслэл	БҮГД	ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭР			
		Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт асгадаг	Тогтсон цэг байхгүй	Шатаадаг, булдаг
Бүгд	100.0	58.2	28.1	13.5	0.2
Архангай	100.0	42.3	25.6	32.2	0.0
Баян-Өлгий	100.0	3.6	44.1	51.7	0.6
Баянхонгор	100.0	62.6	18.4	17.9	1.1
Булган	100.0	26.2	58.1	15.0	0.7
Говь-Алтай	100.0	68.1	23.3	7.8	0.9
Дорноговь	100.0	64.1	30.5	5.0	0.4
Дорнод	100.0	81.7	10.4	7.7	0.2
Дундговь	100.0	42.1	41.1	16.8	0.0
Завхан	100.0	21.4	66.4	11.1	1.1
Өвөрхангай	100.0	68.1	19.4	12.5	0.0
Өмнөговь	100.0	50.5	28.9	20.6	0.0
Сүхбаатар	100.0	49.1	36.4	14.5	0.0
Сэлэнгэ	100.0	36.9	48.7	14.4	0.0
Төв	100.0	43.4	45.7	10.6	0.3
Увс	100.0	12.6	81.8	5.6	0.0
Ховд	100.0	17.9	59.9	22.2	0.0
Хөвсгөл	100.0	34.0	32.7	32.5	0.8
Хэнтий	100.0	31.6	50.5	17.6	0.3
Дархан-Уул	100.0	85.5	7.9	6.6	0.0
Орхон	100.0	96.9	3.1	-	-
Говьсүмбэр	100.0	56.8	35.8	7.4	0.0
Улаанбаатар	100.0	95.9	2.2	1.9	0.0

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс Говь-Алтай 34.4, Сэлэнгэ 26.2, Архангай 28.2 пунктээр тус тус буурсан сайн талтай боловч Говьсүмбэрт 28.6, Баян-Өлгийд 17.2, Төвд 12.3 пунктээр тус тус буурсан байна. Гэвч хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс дорвитой өөрчлөлт гарсангүйг орон нутгийн төр захиргааны байгууллагуудын анхаарах асуудлын нэг болж байна.



# ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



## **ӨРХИЙН ТОО, ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ**

### **Өрхийн тоо, хэлбэр.**

Монгол Улсын өрхийн тоо 2020 онд 2010 оныхоос 186.6 мянгаар буюу 25.7 хувиар өссөн байна. Өрхийн жилийн дундаж өсөлт энэ хугацаанд 2.9 хувь байгаа нь мөн үеийн хүн амын жилийн дундаж өсөлтөөс 0.7 пунктээр илүү байна.

Хотын өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2010 онд 2000 оныхоос 12.4 пунктээр өсөж байсан бол 2020 онд 2010 оныхоос 0.4 пунктээр өссөн нь хүн ам өрхөөрөө хот суурин газар уруу шилжих шилжилт бага зэрэг саарсан гэж үзэж болохоор байна.

Монгол Улс өрхийн тоог өрхийн хэлбэрээр Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн тодорхойлж ирсэн. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр нийт өрхийн тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр улсын хэмжээний нийт өрхийн дотор ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 61.9 мянгаар буюу 81.5 хувиар өссөн нь бусад хэлбэрийн өрхөөс өндөр өсөлттэй байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл, хөгжлийн онцлогтой уялдаатай байж болох боловч цаашдаа хүн амын өсөлт хөгжилд сөрөг нөлөөтэй үзүүлэлт учир үүний шалтгаан нөхцөлийг цаашид анхааран нарийвчлан судлах шаардлагатай юм.

### **Хүн амьдрахад зориулагдсан сууцны тоо, төрөл, хэлбэр.**

Манай улс орон сууцны үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон сууцны урт хугацаатай зээлийн анхдагч ба хоёрдогч зах зээлийн тогтолцоог бий болгон хөгжүүлэх, орон сууц барих сан байгуулах, иргэдийн орлого, зорилтод бүлэгт зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авсны үр дүнд хүн амын орон сууцны хүрэлцээ хангамж сайжирч байгаа нь байшин, орон сууцны 2019 оны тооллогын дүнгээс харагдаж байна.

Байшин, орон сууцны 2019 он тооллогын дүнгээр улсын хэмжээнд 677 620 сууц байгаагийн 44.9 хувь нь гэр, үүний дотор 74.2 хувь нь үндсэн гэр үлдэх хэсэг нь илүү гэр байв. Нийт сууцны 55.1 хувь нь байшин сууц байгаагийн дотор 78.3 хувь нь үндсэн байшин, 21.7 хувь нь улирлын чанартай хүн амьдардаг зуслангийн байшин байна.

Байшин, орон сууцны тооллого явуулсны гол ач холбогдол нь улсын хэмжээнд байгаа хүн амьдрахад зориулагдсан нийт сууцны тоог төрөл тус бүрээр нь тодорхойлсны дотор тэдгээрт хүн байнга амьдардаг, амьдардаггүйгээр (Илүү гэр, зуслангийн байшин зэрэг) нь ялган тодорхойлсон нь цаашид улсын хэмжээнд орон сууцны хүрэлцээ хангамжийн талаарх төсөл хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой мэдээлэл бүрдсэн гэж үзэж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр нийт өрхийн 38.2 хувь нь гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Манай улсын өрхүүдийн сууцны төрөл сүүлийн 20 жилд нэлээд өөрчлөгдөж, хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 50.9 хувь нь гэрт амьдарч байсан



бол 2010 онд 45,2 хувь, 2020 онд өмнөх тооллогынхоос 7.0 пунктээр буурчээ. Энэ нь хот, суурин газарт оршин суугаа өрхийн тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр нийтийн орон сууцны байшин олон тоогоор ашиглалтад орж, мөн хот суурин газарт төдийгүй хөдөө орон нутаг амьдарч байгаа өрхүүд байшинд амьдрах нь улам нэмэгдэж байгаатай холбоотой.

Байшинд амьдардаг өрхийн тоо өсөж байгаагийн дотор бие даасан тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэж байгаа нь хүн амын амьдралын чанар дээшилж,, тав тухтай амьдрах нөхцөл нэмэгдэж байгааг харуулж байна. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 29.4 хувийг эзэлж байгаа нь 2010 оныхоос 8.1 пунктээр нэмэгджээ. Үүний дотор сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2010 оныхоос 0.5 пунктээр, бие даасан тохилог сууцных 0.2 пунктээр тус тус өсөв.

### **Сууцны өмчлөл, эзэмшлийн хэлбэр**

Тооллогын дүнгээс үзэхэд өөрийн өмчийн сууцанд амьдарч байгаа өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 2.3 пунктээр нэмэгдэж, манай иргэд үндсэндээ өөрийн өмчийн сууцтай болсон байна. Байшинд амьдарч байгаа өрхийн нэг хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 1.5 пунктээр буурсан байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 74.8 мянган өрх, өөрийн гэсэн сууцгүй байгаа нь өмнөх тооллогынхоос 20 мянгаар буурсан боловч цаашид хүн амыг орон сууцжуулах төсөл хөтөлбөрийн эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Хотын өрхийн 9.8 хувь буюу 59.3 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаа нь Булган, Говь-Алтай, Дорноговь, Сүхбаатар аймгийн нийт өрхийн тоотой дүйцэхүйц хэмжээ юм. Өөрийн гэсэн сууцгүй өрхийн тоо хөдөөд хурьцангуй цөөн байгаа нь шинэ гэр бүл бологсад болон бусад шаардлагатай тохиолдолд шинээр гэр барьж орон сууцны асуудлыг шийддэг монгол уламжлалтай холбоотой гэж үзэж байна.

### **Орон сууцны цахилгааны эх үүсвэр, ахуйн нөхцөл**

Монгол Улсын айл өрхүүдийн цахилгааны хангамж хүрэлцээ тооллогоос тооллого хооронд улам сайжирч байна. Ялангуяа сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх, үүний дотор төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох, хөдөөгийн малчин өрхүүдийг сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрүүдээр цахилгаанаар хангах арга хэмжээ авсны үр дүн хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс тодорхой харагдаж байна.

Төвлөрсөн эх үүсвэрээс цахилгаанаар хангагддаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 4.8, хотын өрхийнх 3.7, хөдөөгийн өрхийнх 6.6 пунктээр тус тус өссөн байна. Харин дизель станцаас эрчим хүчээ авдаг өрхийн тоо улсын хэмжээнд нийт дүнгээрээ буурсан бол, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаанаар хангагддаг өрхийн тоо нэмэгдсэн байна. Улсын





хэмжээнд цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 18.8 мянгаар буурсан сайн үзүүлэлт байна. Улсын хэмжээнд 4817 өрх цахилгааны эх үүсвэргүй байгаагийн дотор Улаанбаатар хот, Хэнтий, Хөвсгөл, Архангай аймгуудад цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо бусдаас олон байна.

Өрхийн сууцны ахуйн нөхцөл. Төрөөс иргэдийг орон сууцжуулахад ихээхэн анхаарч, зохих амжилт олж байгаагийн зэрэгцээгээр орон сууц, түүний инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, төвлөрсөн болон бие даасан ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламж, халуун ус, дулаан, цахилгааны шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон арга хэмжээнүүдийг боловсруулж, хэрэгжүүлсээр байна.

Сууцны ахуйн нөхцөлөөр хангагдах байдал нь хот суурин газарт амьдарч байгаа өрхүүд хөдөөгийн өрхүүдээс илүү байх нь зүй асуудал. Хот суурин үүний дотор нийслэл болон аймгийн төвүүдэд цэвэр, бохир ус зайлуулах төвлөрсөн системтэйн зэрэгцээгээр хатуу хог хаягдлыг төвлөрсөн журмаар тээвэрлэж зайлуулдаг зэрэг давуу талууд олонтой юм. Хотын нийт өрхөд ахуйн нөхцөл сайтай өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 5.2 пунктээр өссөний дотор Дорноговьд 25.8, Сэлэнгэд 19.9, Увс 11.5, Говьсүмбэрт 11.4, Завханд 11.1 пунктээр тус тус өссөн байна. Харин энэ үзүүлэлт олон аймагт буурсны дотор Дархан-Уулд 31.1, Хэнтийд 24.3, Төвд 17.5, Ховдод 13.4, Өмнөговь 11.4 пунктээр буурсан нь бусдаас илүү байна.

Сууцны ахуйн нөхцөлийг сонгосон таван үзүүлэлтээс (Цахилгаан, усан хангамж, бие засах газар, бохир ус зайлуулалт, хатуу хог хаягдал зайлуулалт) үзэхэд 2020 онд нэлээд дэвшил гарсан гэж үзэж болохоор байна. Сууцны нөхцөл нэг буюу хоёр эсвэл огт хангаагүй өрхийн тоо үндсэндээ хөдөө орон нутагт байгаа нь харагдаж байна. Хөдөө мал аж ахуй эрхэлж байгаа өрхүүдийн хувьд цахилгааны эх үүсвэртэй байхад бусад нөхцөлийн шаардлага бага юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс үзэхэд өрхүүдийн цахилгааны хангамж, өмнөх тооллогын үеийнхээс нэлээд сайжирсан нь өрхүүдийн ахуй нөхцөлөөр хангагдсан байдлыг нэмэгдүүлэхэд нэг чухал нөхцөл болсон байна. Харин 2020 оны тооллогоор өрхийн ахуй нөхцөлийн үүний дотор бохир ус, бие газрын бохирыг зайлуулах хэлбэрүүдийг өмнөх тооллогын үеийнхээс нэлээд олон үзүүлэлтээр нарийвчлан тодорхойлсон. Энэ нь хөрс, ус, агаарын чанар, эрүүл ахуй, орчны бохирдолд өрхүүдийн бие газрын болон бохир ус, хатуу хог хаягдал хир нөлөөлж байгааг тодорхойлох, цаашид энэ талын төр засгийн бодлого хөтөлбөр боловсруулахад үндэслэл болохуйц мэдээлэл бүрдсэн гэж үзэж байна.

### **Байшинд амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл**

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр байшинд 547.0 мянган өрх амьдарч байгаа нь нийт өрхийн 60.9 хувь нь юм. Энэ нь өмнөх тооллогын үеийнхээс 7.3 пунктээр, үүний дотор орон сууцны байшин суудаг өрх 8.1, бие даасан тохилог сууцанд суудаг өрх 0.2, сууцны тусдаа байшинд суудаг өрх 0.3 пунктээр тус тус өссөн байна.



Байшинд амьдардаг өрхийн нэг хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа нь орон сууцыг хувьчлах үйл явц үндсэндээ дуусаж байгааг харуулж байна.

Байшинд амьдардаг 55.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаа нь 10 өрх тутмын нэг нь өөрийн гэсэн сууцгүй байна гэсэн үг юм. Иймээс ялангуяа төв суурин газарт орон сууцжуулах төсөл хөтөлбөрийн улам эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнг 2010 оныхтой харьцуулахад 20 хүртэл Кв.м талбайтай сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 4.8 пунктээр буурч, харин 40-өөс дээш кв.м талбайтай сууцанд амьдардаг өрхийнх 20.4 пунктээр өссөн байна. Мөн түүнчлэн манай улсын өрхийн дундаж ам бүл 3-4 байдаг. Сууцны талбай нь 40-өөс дээш Кв.м талбайтай сууцанд амьдардаг 3-4 ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 20.7 пунктээр өссөн байна

Байшинд амьдардаг өрхийн сууцны талбайн хэмжээ, ам бүлийн тооны харьцаа нь хүн амын амьдрах таатай нөхцөл хир бүрдсэн байгааг харуулах нэг гол үзүүлэлт билээ. Манай орны хувьд энэ үзүүлэлт тийм ч таатай бус байгааг тооллогын дүн харуулав. Байшинд амьдардаг нийт өрхийн 72.1 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогынхтой харьцуулахад дөнгөж нэг пунктээр буурсан аж. Тус улсын 3-4 ам бүлтэй өрхийн 74.3 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 0.7 пунктээр өссөн нь чамлалттай үзүүлэлт юм. Гэтэл 7 түүнээс дээш ам бүлтэй өрхийн 64.3 хувь нь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогынхоос 2.4 пунктээр өссөн ч хангалттай биш юм.

Цахилгаан хангамж. Байшинд амьдардаг өрхүүд үндсэндээ цахилгаанаар хангагдсан байна Цахилгааны эх үүсвэргүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 0.4 пунктээр буурч, хөдөөгийн өрхийн 0.1 хувь нь цахилгаангүй байна.

Дулааны хангамж. Хүйтний улирал урт байдаг манай орны хувьд орон сууцны дулаан хангамжийн асуудал гэр бүлийн гишүүдийн тав тухтай, эрүүл амьдрах нэг чухал нөхцөл болдог билээ. Байшинд амьдардаг өрхийн 49.6 хувь төвлөрсөн халаалтын системд, үүний дотор хотын өрхийн 57.6 хувь холбогдсон нь өмнөх тооллогын үеийнхээс улсын хэмжээнд 5.7 пунктээр, хотод 5.9 пунктээр тус тус өссөн байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод өмнөх тооллогоос өрхийн дулаан хангамжийн үзүүлэлтийг өргөжүүлж, газрын гүний, шатдаг хийн халаагуураар дулаанаа хангадаг өрхийг тодорхойлсон. Улсын хэмжээнд газрын гүний улаанаар хангадаг өрх 41, шатдаг хийгээр дулаанаа хангадаг өрх 51 байгаа юм.

Байшинд амьдардаг өрхийн халаалтын эх үүсвэр өнгөрсөн тооллогын үеийнхээс нэлээд ахиц гарсан гэж үзэж болохоор байна. Ялангуяа төвлөрсөн системээс халаалтаа авдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаар 19.5



пунктээр өссөний дотор Дорноговь 11.5, Сүхбаатар тус бүр 13.0 пунктээр өссөн байна. Төвлөрсөн системээс халаалтаа авдаг өрхийн тоо өсөхийн хирээр төв суурин газрын ердийн галлагаатай өрхийн нийт өрхөд эзлэх хувь буурч байна. Ердийн галлагаатай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 22.4 пунктээр буурсны дотор Өмнөговь 22.4, Сүхбаатар 12.8, Увс 10.9, Ховд 10.1 пунктээр буусан байна.

Усан хангамж. Байшинд амьдардаг өрхийн ус хангамж өнгөрсөн тооллогын үеийнхээс нэлээд сайжирсны дотор нийт өрхөд төвлөрсөн усан хангамжийн системд хамрагдсан өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 20.3 пунктээр өссөний дотор Дорноговь 12.5, Өмнөговь 17.0, Сүхбаатар 14.6 пунктээр өссөн нь бусдаас өндөр өсөлттэй байна. Харин зөөврийн усан хангамжтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 21.4 пунктээр буурсны дотор Дорноговь 13.0, Өмнөговь 18.0, Сүхбаатар 14.2, Улаанбаатар 8.8, Говьсүмбэр 7.8, Увс 7.0 пунктээр буурсан нь бусдаас илүү бууралттай байна.

Зөөврийн усан хангамжтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд улсын дунджаар 49.4 хувь байхад Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд улсын дунджаас бараг хоёр дахин өндөр байна. Харин Дорноговь, Өмнөговь, Орхон, Говьсүмбэр аймгууд улсын дунджаас доогуур байгаа юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өмнөх тооллогуудад нарийвчлан тодорхойлж байгаагүй нэг үзүүлэлт бол өрхийн усан хангамжийн эх үүсвэр юм. Үүнд: байшинд амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэр нь төвлөрсөн болон бие даасан системд холбогдсон бол байшин доторх, үүнээс бусад эх үүсвэрийг байшингийн гаднах эх үүсвэр гэж үзсэн. Энэ нь ундны усны чанар хүний эрүүл ахуйд хэрхэн нөлөөлж байгаа судлахад ач холбогдолтой чухал үзүүлэлтүүд юм.

Байшинд амьдардаг ундны усны эх үүсвэр нь байшингийн гадна байдаг өрхийн дийлэнхийнх нь ундны усны эх үүсвэр нь хамгаалагдсан гүний худаг байгаа нь үндсэндээ ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан эх үүсвэртэй байна гэж үзэж болох юм.

НҮБ-ын хүн ам, орон сууцны тооллоготой холбогдох зарчим, зөвлөмжид тооллого явуулж буй орнууд зөөврийн усаар хангагдаг өрх усаа хир зайнаас зөөдгийг тодорхойлж байхыг зөвлөмж болгосон байдаг. Энэ зөвлөмжийн хүрээнд хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор байшинд амьдардаг зөөврөөр усаа авдаг өрхийн тоог, усаа хир зайнаас зөөдгийг тодорхойлсон. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр байшинд амьдардаг нийт өрхийн 31.9, хотын өрхийн 55.4, хөдөөгийн өрхийн 43.1 хувь нь тус тус 200 метр хүртэлх, нийт өрхийн 30 орчим хувь нь 200-500 метр зайнаас усаа зөөдөг аж. Харин 1000 метрээс хол зайнаас нийт өрхийн 4.3, хотын өрхийн 2.1, хөдөөгийн өрхийн 8.9 хувь нь усаа зөөдөг байна.

Бие засах газар. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод байшинд амьдардаг өрхийн бие засах газрын төрлийг өмнөх тооллогуудаас ихээхэн



нарийвчлан тодорхойлсон тул ихэнх үзүүлэлтийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулах боломжгүй юм

Байшинд амьдардаг нийт өрхийн 48 хувь буюу 262.7 мянган өрх, хотын өрхийн 40 хувь буюу 180.5 мянган өрх энгийн нүхэн жорлон, ил задгай бие засаж байгаа нь төв суурин газрын хөрсний бохирдолд сөрөг нөлөөтэйг анхаарч, төр захиргааны байгууллагууд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, энгийн нүхэн жорлон ашигладаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жинг бууруулах, ил задгай бие засдаг өрхийн тоог арилгах шаардлагатай юм.

Хатуу хог хаягдал зайлуулалт. Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлого зохицуулалтаар ангилан ялгаж, тогтсон газар цуглуулах, дахин боловсруулах, энэ чиглэлд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хатуу хог хаягдлыг өрхүүд өөрсдөө ангилж сурах хэвшлийг буй болгох нь байгаль орчны бохирдлыг бууруулах, хүн амын эрүүл мэндийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүн нь энэ талын бодлого хөтөл боловсруулахад үндэслэл болохуйц мэдээллийг бүрдүүлсэн болно.

Байшинд амьдардаг нийт өрхийн 3.1 хувь буюу 16.5 мянган өрх хатуу хог хаягдлаа шатаадаг, булдаг эсвэл тогтсон цэг байхгүй хаа дуртай газарт хаядаг нь аль аль нь байгаль орчин, агаарын бохирдолд сөрөг нөлөөтэйг анхаарах нь зүйтэй байна.

Бохир ус зайлуулалт. Өрхийн бохир ус зайлуулах хэлбэрээс хамаарч орчны бохирдол ялангуяа хөрс, гадаргын усны бохирдолд хэрхэн нөлөөлөх төлөв байдлыг илэрхийлж болох юм. Ялангуяа орон сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн дийлэнх хувь нь бохир усаа цооногт эсвэл ил задгай асгадаг байна.

Байшинд амьдардаг өрхийн талаас илүү хувь нь буюу 276 мянган өрх үүний дотор хотын 191.6 мян.өрх бохир усаа цооногт буюу ил задгай асгаж байгаа нь хөрс, гадаргын усыг бохирдуулах, улмаар элдэв халдвар тархах нөхцөлийг бүрдүүлж байгааг анхаарч, бохир ус зайлуулах орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Байшинд амьдардаг өрхийн 48 хувь нь ахуй нөхцөл сайтай байгаагийн дотор Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Хэтний аймгууд, Улаанбаатар хот улсын дундаас дээгүүр хувьтай байна. Харин улсын дунджаас нэлээд доогуур, нийт өрхөд ахуй нөхцөл сайтай өрхийн хувийн жин 10-аас доош байгаа аймгуудад Ховд, Баян-Өлгий, Булган аймгууд орж байна. Ахуй нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 11.8 пунктээр өссөний дотор Хэнтий 37.0, Өвөрхангай 31.5, Хөвсгөл 27.0, Төв 17.5 пунктээр тус тус өссөн нь бусдаас өндөр өсөлттэй байна. Харин энэ үзүүлэлт Дундговьд 17.2, Ховдод 16 пунктээр буурсан байна.

Байшинд амьдардаг өрхийн дийлэнх хувь нь төв суурин газарт байдаг тул ахуйн нөхцөл сайтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын дунджаас нэлээд өндөр



байгаа зүйн асуудал билээ. Хотын нийт өрхөд ахуй нөхцөл сайтай өрхийн эзлэх хувь улсын дунджаар 55.9 хувь байгаагийн дотор Говь-Алтай 67.8, Өмнөговь 60.5, Дорноговь 60.2 хувь байгаа нь бусдаас өндөр байгаа юм.

Ахуйн нөхцөл сайтай өрхүүдийн дийлэнх нь эрүүл аюулгүй ундны усны хангамжтай, цахилгаанаар хангагдсан, бие засах газар нь эрүүл ахуйн шаардлага хангасан, орчны бохирдол багатай байгаагийн хамт хатуу хог хаягдлаа ахуй үйлчилгээний байгууллага болон төвлөрсөн цэгт асгаж тогтсон хугацаанд зайлуулах нөхцөлүүдийг голлон хангасан байна.

### **Гэрт амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл**

Монгол гэрийн багтаамжийг ханын тоогоор тогтоодог уламжлалтай. Монгол Улсын хүн ам, мал, хөрөнгө хогшлын 1933 оны бүртгэлээс эхлээд хүн ам, орон сууцны болон орон сууцны үе үеийн тооллогуудад гэрийн багтаамжийг ханын тоогоор тогтоож ирсэн аж. Дээр үеэс ханын тоог сондгой тоогоор тогтоодог байсан бол сүүлийн үед тэгш, сондгой аль алианаар нь тогтоодог болж байна. Монгол гэрийн үүсэл гарал, бүтэц хийц болон бусад холбогдох асуудлаар маш өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажлууд хийгддэг боловч монгол гэрийн талбайн хэмжээг тогтоосон бодит судалгаа, тооллого өнөө хир байхгүй байгаа юм. Үйлдвэрийн аргаар гэр хийдэг аж ахуйн нэгжүүдийн тогтоосноор 4 ханатай гэрийн талбай 20, 5 ханатынх 28, 6 ханатынх 35, 8 ханатынх 65, 10 ханатынх 80 кв.м гэж тогтоосон аж.

Хүн ам, орон сууцны үе үеийн тооллогоор байшинд амьдардаг өрхийн сууцны талбайг тодорхойлж байсан боловч гэрийн талбайг тодорхойлоогүй явж ирсэн нь учир дутагдалтай юм. Учир нь улсын хэмжээнд хэдий хэмжээний талбайтай сууцтай, нэг хүнд дунджаар хэдэн квадрат метр талбай ногддог, тэр нь олон улсын дундажтай зэрэгцүүлэхэд ямар түвшинд байдгийг тодорхойлох боломж байхгүй явж ирсэн аж.

Цахилгаан хангамж. Гэрт амьдардаг өрхийн цахилгаан хангамж сайжирч, төвлөрсөн системээс цахилгаанаа авдаг өрхийн тоо 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 0.9 пунктээр, үүнээс хотын өрхийнх 7.3 пунктээр нэмэгдсэний зэрэгцээгээр сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөс цахилгаанаа авдаг хөдөөгийн өрхийн тоо 10.1 пунктээр тус тус өсжээ. Харин цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 16.8 мянгаар буурсны зэрэгцээгээр нийт өрхөд цахилгаан гэрэлгүй өрхийн эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дунджаар 6.6 пунктээр буурсны дотор энэ үзүүлэлт бүх аймаг нийслэлд буурсан нь том амжилт юм. Хот суурин газарт гэрт амьдардаг өрхүүдээс 2020 оны тооллогын дүнгээр цахилгаангүй 1016 өрх байгаагийн 78.2 хувь буюу 795 өрх нийслэлд байгаа нь анхаарах асуудал юм.

Бие засах газар. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр гэрт амьдардаг нийт өрхөд бие засах тодорхой цэггүй өрхийн эзлэх хувь улсын хэмжээнд 25.8, хөдөөд 45.7 хувь байсан бол 2020 онд улсын хэмжээнд 4.8, хөдөөд 8.9 пунктээр буурсан аж.





Улсын хэмжээгээр гэрт амьдардаг өрхийн 77.4 хувь нь энгийн бие засах газартай байгаагийн дотор энэ үзүүлэлт 80-аас дээш хувьтай 10 аймаг, нийслэл орж байна. Нүхэн жорлон төв суурийн газрын хөрсний бохирдолд ихээхэн сөрөг нөлөөтэйг шинжлэх ухааны үндэслэлтэй олон судалгаа шинжилгээ тогтоож, сүүлийн үед сайжруулсан, био жорлонг нэвтрүүлж байгаа боловч төдийлөн ахицтай биш байна. Энэ ажлыг Говьсүмбэр аймаг болон нийслэлд бусдаас арай ахицтай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна. Байгаль орчны бохирдолд жирийн нүхэн жорлонгоос илүү их хор хөнөөлтэй, бие засах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд улсын дунджаар 4.7 пунктээр буурсны дотор Баян-Өлгийд 29.4, Говьсүмбэрт 17.7, Өмнөговьд 16.5, Булганд 16.0 пунктээр тус тус буурсан нь бусдаас илүү байна. Гэтэл энэ үзүүлэлт сүүлийн хоёр тооллогын хооронд буурах бүү хэл өссөн аймаг ч бас байна. Эдгээрийн тоонд Увс 4.9, Орхон 1.9, Завхан, Говь-Алтай тус бүр 0,8, Баянхонгор 0.7 пунктээр тус тус өссөн байна.

Хатуу хог хаягдалд зайлуулалт. Хатуу хог хаягдал зайлуулах хэлбэрийн хувьд 2020 онд гэрт амьдардаг нийт өрхийн 45.5 хувь нь үйлчилгээний байгууллагаар хатуу хог хаягдлаа зайлуулж байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 2.5 пунктээр, хотын өрхийнх 10.4 пунктээр тус тус өссөн байна. Гэтэл хатуу хог хаягдал зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь хоёр тооллогын хооронд бараг буурсангүй нь орчны бохирдлыг бууруулах талаар зохион байгуулж буй ажлын үр дүн бага байгааг харуулж байна.

Гэрт амьдардаг өрхүүд хатуу хог хаягдаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 45.5 байгаа боловч, аймгуудын дотор энэ үзүүлэлт 40 –өөс дээш хувьтай аймаг дөнгөж 4 байна. Хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 20-иос доош аймаг 7 байна. Энэ үзүүлэлт сүүлийн хоёр тооллогын хооронд олигтой ахиц гарсангүй. Хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэг байхгүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өнгөрсөн тооллогынхоос улсын хэмжээнд дөнгөж 0.4 пунктээр буурсан нь хангалтгүй юм. Харин энэ үзүүлэлт өнгөрсөн тооллогынхоос Архангай 16.7, Өвөрхангай 9.1, Завхан 8.1, пунктээр буурсан нь бусдаас илүү ахицтай байна. Гэтэл энэ үзүүлэлт Сэлэнгэд 12.3, Дорноговьд 8.2 пунктээр нэмэгдсэн зэргээс үзэхэд хатуу хог хаягдлыг ялгах, дахин ашиглах зэрэг хөрсний бохирдолд хор хөнөөл багтай арга хэмжээг нэн даруй нэвтрүүлэх шаардлагатай байгаа аж.

Бохир ус зайлуулалт. Бохир ус зайлуулах тодорхой цэггүй задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 2.8 пунктээр өссөн нь муу талтай ч, харин хотын өрхийнх 3.5 пунктээр буурсан аж. Цаашид төв суурин газрын хөрс, усны бохирдлыг бууруулах, бохир усаа задгай асгадаг явдлыг цөөрүүлэх талаар орон нутгийн төр захиргааны байгууллагууд дорвитой ажил зохион байгуулах нь зүйтэй байна.

Гэрт амьдардаг өрхүүдээс бохир усаа задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс 2.8 пунктээр буурсны дотор Хөвсгөл 12.0, Завхан 11,7, Архангай 8.5 пунктээр буурсан нь бусдаас илүү ахицтай байна. Гэтэл энэ үзүүлэлт хоёр тооллогын хооронд Говьсүмбэрт 14.3,



Өмнөговьд 4.7, Баян-Өлгийд 3.8 пунктээр өссөн нь өмнөх амжилтаасаа ухарсан гэсэн үг юм.

Ундны усны баталгаат эх үүсвэр. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гэрт амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэрийг өмнөх тооллогынхоос ихээхэн дэлгэрүүлж тодорхойлсон байна. Гэхдээ ундны усны баталгаат, баталгаагүй эх үүсвэрийн талаарх ойлголт тодорхойлолт нь өмнөх тооллогынхтой ижил юм. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гэрт амьдардаг өрхийн ундны усны эх үүсвэрийг сууц дотроо, сууцны гадна гэж хоёр ангилсан нь өмнөх тооллогуудад байгаагүй ойлголт юм. Үүнд: сууц дотроо гэсэн ойлголтод өрх ундны усаа төвлөрсөн болон бие даасан системээс хангадаг бол сууц дотроо гэж, харин үүнээс бусдыг сууцны гаднах эх үүсвэр гэж үзсэн аж.

Ундны усаа гаднах эх үүсвэрээс авдаг гэрт амьдардаг нийт өрхийн 63.0 хувь нь ундны усны баталгаатай эх үүсвэрээс усаа авч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 7.3 пунктээр өссөний дотор хотын өрхийн 99 хувь, хөдөөгийн өрхийн 35 хувь нь баталгаат эх үүсвэрээс ундны усаа авч байна. Гэвч хөдөөгийн өрхийн 35.2 хувь нь ундны усны ил эх үүсвэр болох гол мөрөн, булаг шанд, нуур цөөрмөөс усаа авч байгаа нь манай орны хувьд ундны цэвэр усаар хангагдаж байгаа гэж үзэж болох юм. Ингэж тооцвол хөдөөгийн өрхийн 70 гаруй хувь нь ундны цэвэр усаар хангагдсан гэж ойлгож болох талтай.

Гэрт амьдардаг нийт өрхөд ундны усны баталгаат эх үүсвэрээр хангагдсан өрхийн эзлэх хувь улсын хэмжээнд 63.1 хувь байгаагийн дотор Улаанбаатар, Орхон, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгууд 90-ээс дээш хувь байгаа нь ундны цэвэр усаар хангагдсан гэж үзэж болохоор байна. Гэвч Архангай, Баян-Өлгий, Булган зэрэг аймгуудад энэ үзүүлэлт тун хангалтгүй байна.

Олон улсын жишиг аргачлалд ил задгай эх үүсвэрээс усаа авдаг өрхүүдийг ундны усны баталгаагүй эх үүсвэр гэж үздэг боловч манай орны хувьд байгалийн цэнгэг устай гол мөрөн, булаг шандаас ундны усныхаа хэрэгцээг хангаж байгаа өрхүүдийн хувьд бас цэвэр ус хэрэглэдэг гэж үзэж болох юм. Ингэж үзвэл 14 аймгийн өрхийн 90 гаруй хувь нь ундны цэвэр ус хэрэглэдэг гэж үзэх үндэс бий юм. Гэвч зах зээлд шилжсэн сүүлийн 30 орчим жилд уул уурхайн үйлдвэрлэл хөгжиж, гол мөрөн, булаг шандыг ихээр бохирдуулж байгааг харгалзан үзвэл ундны усны ил задгай эх үүсвэрийг баталгаат эх үүсвэрт тооцдоггүй олон улсын жишиг аргачлалыг цаашид баримтлах нь зүйн асуудал юм.

Гэрт амьдардаг нийт өрхөд усаа 200 метрээс бага зайнаас усаа зөөдөг өрхийн эзлэх хувь улсын хэмжээнд 33.3, хотод 47.3, хөдөөд 23.3 хувь байна. Харин усаа 1000 метр түүнээс хол зайнаас зөөдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээнд 18.2, хотод 3.0, хөдөөд 28.9 хувь байна

Гэрт амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийг сайжруулах үндсэн нөхцөлүүд нь ундны усны баталгаат эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр байгаль орчинд хор хөнөөл аль болох багатай бие засах газрын төрлүүдийн нэмэгдүүлэх ялангуяа төв суурин газрын бие засах газар, бохир ус зайлуулах арга ажиллагааг





улам төгөлдөржүүлэх шаардлагатай байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.

### **Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн тоо, ахуйн нөхцөл**

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй, эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууцыг бусад сууц гэж үзсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр зориулалтын бус, бусад сууцанд 8039 өрх амьдарч байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээс 97 өрхөөр буурсан байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн сууцных нь өмчлөлийн хэлбэр 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс нэлээд өөрчлөгдөж, төрийн өмчийн сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин буурч, харин иргэний өмчийн сууцны хувийн жин 47.2 пунктээр өссөн байна. Энэ үзүүлэлт хот, хөдөөд мөн нэг адил өөрчлөгдсөн байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн өмчлөлийн асуудал 2020 онд 2010 оныхоос ихээхэн ахицтай байсны нэг адил сууцны эзэмшилд ч мөн ихээхэн өөрчлөлт гарсан байна. Өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд 2010 оныхоос 49.1 пунктээр өссөн нь хот, хөдөөд ч мөн адил өссөн байна.

Ундны усны эх үүсвэр. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод зориулалтын бус, бусад сууцны ундны усны эх үүсвэрийг 2010 оны тооллогынхоос арай өөрөөр тодорхойлсон. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг, сууцны гаднаас усаа авдаг өрхүүдийн 95.8 хувь нь ундны усны баталгаат эх үүсвэртэй гэж үзэж болох юм, Үүнийг 2010 оны тооллогын дүнтэй зэрэгцүүлэхэд 24.9 пунктээр өссөн байна. Энэ үзүүлэлт хотод 99.1 хувь, хөдөөд 91.1 хувь байна.

Цахилгааны эх үүсвэр. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдээс төвлөрсөн системд холбогдсон өрхүүдийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс улсын дүнгээр 3.4 пунктээр буурсан боловч хотын өрхүүдэд 3.3, хөдөөгийн өрхүүдэд 0.2 пунктээр өссөн аж. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүд дизель станцаас цахилгаанаар хангагдах нь эрс багасаж, харин сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглах нь илүү нэмэгдсэн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хямд эрчим хүч ашигладаг болсон нь харагдаж байна. Цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо улсын хэмжээгээр 130, үүнээс хөдөөд 104 байна

Халаалтын эх үүсвэр. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн халаалтын эх үүсвэрийг өмнөх тооллогуудад тодорхойлж байгаагүй. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод өрхүүдийн халаалтын эх үүсвэрийг сууцыг дулаан байлгах зориулалттай халаалтын системд байрыг бүхэлд нь халаах зориулалттай дулааны төвлөрсөн систем, нам даралтын зуух, ердийн галлагаа буюу зуух, пийшин зэргийг хамруулсан.



Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхийн халаалтын голлох эх үүсвэр нь ердийн галлагаа буюу зуух, пийшин байна. Энэ нь хот, хөдөөд онцын ялгаагүй байна.

Бохир ус зайлуулалт. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бохир ус зайлуулдаг хэлбэр 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс нэлээд өөрчлөгдсөн аж. Тухайлбал: төвлөрсөн системээр бохир усаа зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь улсын хэмжээнд 29.3 пунктээр буурч, задгай асгадаг өрхийн эзлэх хувь 4.5 пунктээр өссөний дотор эдгээр үзүүлэлт хот суурин газрын өрхүүдэд илүү ашиглагдаж байгаа нь байгаль орчныг бохирдуулах, орчны ариун цэвэр халдваргүйжүүлэхэд сөрөг нөлөөтэй юм.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бохир усаа задгай асгадаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс улсын дунджаар 4.5 пунктээр буусны дотор Баян-Өлгийд 35.4, Хөвсгөлд 17.7 пунктээр буурсан нь бусдаас өндөр байгаа боловч Дорноговьд 20.2, Хэнтийд 15.7, Улаанбаатарт 14.7 пунктээр өссөн аж. Бохир усыг цооногт асгаж байгаа нь задгай асгаж байгаагаас ариун цэвэр, хөрсний бохирдолд арай бага нөлөөтэй боловч удаан хугацаанд хөрсөнд нэвчиж бохирдуулдаг нь нэгэнт шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаагаар нотлогдсон тул цаашид цооногт болон задгайгаар бохир ус асгах явдлыг аль болох бууруулах талаар холбогдох төр захиргааны байгууллагууд анхаарах шаардлагатай юм.

Бие засах газрын бохирыг зайлуулах хэлбэр. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бие засах газрын бохирыг зайлуулах хэлбэрийг өмнөх 2010 оны тооллогоор тодорхойлоогүй аж. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бие засах газрын бохирыг зайлуулдаг хэлбэрийг нэлээд нарийвчлан, төвлөрсөн системээр, цооногт, нүхэн жорлонд урсгадаг, сайжруулсан болон энгийн, био жорлон, задгай гэсэн төрлүүдээр тодорхойлсон байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн бие засах газрын бохирыг зайлуулах гол хэлбэр нь энгийн нүхэн жорлон аж. Энэ үзүүлэлт хот, хөдөө, аймаг, нийслэлд онцын ялгаа ажиглагдахгүй байна. Сайжруулсан болон био жорлонг сүүлийн үед нэвтрүүлэх төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа сайн талтай боловч өргөн хүрээг хамарч чадаагүй байгаа нь тооллогын дүнгээс харагдаж байна.

Хатуу хог хаягдал зайлуулалт. Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэрийг хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өмнөх тооллогоос арай дэлгэрүүлж, газарт булдаг, шатаадаг гэсэн хоёр хэлбэр нэмсэн байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэр өнгөрсөн 2010 оны тооллогынхоос нэлээд өөрчлөгдсөн аж. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн 70.5 хувь нь үйлчилгээний байгууллагуудаар хатуу хог хаягдал зайлуулдаг байсан бол энэ үзүүлэлт 2020 онд 12.3 пунктээр буурч



харин зөвшөөрөгдсөн цэгт асгадаг өрхийн эзлэх хувийн жин 8.8 пунктээр өссөн байна. Харин хатуу хог хаягдлыг зайлуулдаг тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 3.3 пунктээр өссөн байна. Ерөнхийдөө байгаль орчны бохирдолд сөрөг нөлөө үзүүлдэг хатуу хог хаягдлыг үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн хувийн жин буурч, харин хогоо зайлуулах тогтсон цэггүй өрхийн хувийн жин нэмэгдсэн анхаарах гол асуудал юм.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдал зайлуулдаг хэлбэр аймаг, нийслэлээр нэлээд ялгаатай, үйлчилгээний байгууллагаар хатуу хог хаягдлаа зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь Нийслэл, Дархан-Уул, Орхонд илүү өндөр хувьтай байгаа нь хүн ам төвлөрсөн том хотуудад хатуу хог хаягдлыг зайлуулах нэгдсэн системтэйн давуу талыг харуулж байна. Гэвч хатуу хог хаягдлыг зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баян-Өлгий, Архангай, Хөвсгөл аймгууд бусдаас илүү өндөр байна.

Зориулалтын бус, бусад сууцанд амьдардаг өрхүүдийн хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зайлуулдаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс Говь-Алтай 34.4, Сэлэнгэ 26.2, Архангай 28.2 пунктээр тус тус буурсан сайн талтай боловч Говьсүмбэрт 28.6, Баян-Өлгийд 17.2, Төвд 12.3 пунктээр тус тус буурсан байна. Гэвч хатуу хог хаягдлаа зайлуулах тогтсон цэггүй өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогын үеийнхээс дорвитой өөрчлөлт гарсангүйг орон нутгийн төр захиргааны байгууллагуудын анхаарах асуудлын нэг болж байна.



# ХАВСРАЛТ



## ХАВСРАЛТ-1. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ ХОТЫН НИЙТ СУУЦНЫ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	СУУЦНЫ ТӨРӨЛ			
		Гэр	Илүү гэр	Байшин	Зуслангийн байшин
УЛСЫН ДҮН	385 539	98 583	38 064	195 194	53 698
Архангай	5 762	996	468	3 543	755
Баян-Өлгий	8 277	134	23	7 829	291
Баянхонгор	9 356	4 177	1 831	2 859	489
Булган	4 566	333	121	3 676	436
Говь-Алтай	4 651	2 631	791	1 171	58
Дорноговь	7 555	2 028	1 104	4 019	404
Дорнод	8 674	1 600	708	5 097	1 269
Дундговь	3 841	1 654	585	1 322	280
Завхан	5 531	1 354	818	2 861	498
Өвөрхангай	8 045	2 629	424	4 207	785
Өмнөговь	7 534	3 871	1 616	1 956	91
Сүхбаатар	4 320	1 415	151	2 379	375
Сэлэнгэ	7 763	726	182	6 419	436
Төв	3 553	927	470	1 715	441
Увс	7 476	3 888	1 381	1 810	397
Ховд	7 105	2 809	1 485	2 672	139
Хөвсгөл	12 578	844	921	9 117	1 696
Хэнтий	7 768	3 031	865	2 963	909
Дархан-Уул	11 063	1 357	1 124	7 431	1 151
Орхон	21 336	3 359	724	13 972	3 281
Говьсүмбэр	1 825	781	267	761	16
Улаанбаатар	226 960	58 039	22 005	107 415	39 501

## ХАВСРАЛТ- 2. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨӨГИЙН НИЙТ СУУЦНЫ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	СУУЦНЫ ТӨРӨЛ			
		Гэр	Илүү гэр	Байшин	Зуслангийн байшин
УЛСЫН ДҮН	292 081	127 301	40 413	97 061	27 306
Архангай	24 291	11 850	4 843	5 784	1 814
Баян-Өлгий	9 248	193	19	8 769	267
Баянхонгор	17 688	9 888	5 396	1 930	474
Булган	14 660	5 260	539	6 672	2 189
Говь-Алтай	8 322	5 629	1 283	1 241	169
Дорноговь	7 354	3 777	1 384	1 946	247
Дорнод	9 040	3 444	612	4 159	825
Дундговь	9 757	6 512	1 471	1 389	385
Завхан	14 800	7 166	2 064	4 958	612
Өвөрхангай	25 099	14 262	4 400	5 126	1 311
Өмнөговь	11 572	6 483	3 085	1 923	81
Сүхбаатар	14 188	8 544	1 688	3 400	556
Сэлэнгэ	17 301	3 490	1 217	10 925	1 669
Төв	26 167	8 835	4 273	9 258	3 801
Увс	13 088	8 236	1 329	2 577	946
Ховд	12 000	7 388	1 689	2 591	332
Хөвсгөл	34 158	7 729	2 682	15 725	8 022
Хэнтий	17 366	6 961	1 793	5 588	3 024
Дархан-Уул	4 082	597	415	2 560	510
Орхон	910	468	79	325	38
Говьсүмбэр	990	589	152	215	34



### ХАВСРАЛТ-3. ӨРХИЙН ТОО АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	ХОТ				ХӨДӨӨ			
	БҮГД	Гэр	Байшин	Бусад сууц	БҮГД	Гэр	Байшин	Бусад сууц
БҮГД	606 282	149 873	451 638	4 771	291 145	192 536	95 341	3 268
Архангай	5 792	1 612	4 079	101	21 263	17 455	3 682	126
Баян-Өлгий	8 906	121	8 719	66	15 421	619	14 539	263
Баянхонгор	9 284	5 400	3 808	76	16 286	14 616	1 567	103
Булган	4 516	619	3 759	138	13 965	8 660	5 011	294
Говь-Алтай	5 325	3 260	1 985	80	10 750	9 635	1 079	36
Дорноговь	12 142	3 080	8 896	166	7 973	5 193	2 687	93
Дорнод	12 600	2 365	9 751	484	10 778	5 670	4 997	111
Дундговь	3 726	2 046	1 650	30	10 486	9 045	1 376	65
Завхан	4 568	1 856	2 658	54	16 145	11 715	4 222	208
Өвөрхангай	9 235	3 820	5 346	69	23 827	18 996	4 652	179
Өмнөговь	8 200	5 217	2 947	36	12 906	10 289	2 449	168
Сүхбаатар	5 177	1 648	3 508	21	12 548	9 747	2 767	34
Сэлэнгэ	9 858	1 176	8 556	126	19 146	5 404	13 478	264
Төв	4 711	1 619	3 001	91	22 332	14 495	7 617	220
Увс	8 330	5 550	2 684	96	13 316	11 640	1 629	47
Ховд	7 960	4 105	3 645	210	14 553	11 531	2 634	388
Хөвсгөл	12 775	3 011	9 553	211	25 139	14 951	9 781	407
Хэнтий	8 231	4 501	3 610	120	15 675	10 408	5 086	181
Дархан-Уул	23 328	2 863	20 276	189	5 469	912	4 518	39
Орхон	27 250	3 874	23 256	120	1 136	573	556	7
Говьсүмбэр	2 948	881	2 007	60	2 031	982	1 014	35
Улаанбаатар	411 420	91 249	317 944	2 227				

### ХАВСРАЛТ-4. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, БАЙШИНГИЙН ТӨРЛӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	ХОТ					ХӨДӨӨ				
	БҮГД	НЗОСБ*	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр	БҮГД	НЗОСБ*	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр
БҮГД	451 638	254 538	5 903	185 150	6 047	95 341	9 778	537	82 773	2 253
Архангай	4 079	868	24	3 118	69	3 682	16	10	3 637	19
Баян-Өлгий	8 719	459	272	7 967	21	14 539	10	20	14 477	32
Баянхонгор	3 808	1 882	48	1 874	4	1 567	65	2	1 467	33
Булган	3 759	491	24	3 198	46	5 011	41	9	4 899	62
Говь-Алтай	1 985	1 247	75	591	72	1 079	10	4	970	95
Дорноговь	8 896	4 807	190	3 678	221	2 687	807	17	1 542	321
Дорнод	9 751	4 857	90	4 222	582	4 997	306	16	4 467	208
Дундговь	1 650	822	168	647	13	1 376	84	19	1 108	165
Завхан	2 658	722	93	1 799	44	4 222	64	9	4 088	61
Өвөрхангай	5 346	1 510	86	3 745	5	4 652	168	71	4 311	102
Өмнөговь	2 947	1 311	210	1 386	40	2 449	579	57	1 581	232
Сүхбаатар	3 508	1 551	490	1 369	98	2 767	167	18	2 497	85
Сэлэнгэ	8 556	1 810	351	6 217	178	13 478	2 646	172	10 562	98
Төв	3 001	1 319	263	1 200	219	7 617	313	50	6 963	291
Увс	2 684	1 344	83	1 241	16	1 629	3	2	1 601	23
Ховд	3 645	1 734	68	1 805	38	2 634	89	12	2 443	90
Хөвсгөл	9 553	957	128	8 387	81	9 781	26	7	9 653	95
Хэнтий	3 610	1 576	62	1 814	158	5 086	1 155	19	3 744	168
Дархан-Уул	20 276	12 764	400	6 807	305	4 518	2 241	8	2 244	25
Орхон	23 256	11 888	424	10 765	179	556	182	2	370	2
Говьсүмбэр	2 007	1 282	28	661	36	1 014	806	13	149	46
Улаанбаатар	317 944	199 337	2 326	112 659	3 622					

\* Нийтийн зориулалтын орон сууцны байшин



### ХАВСРАЛТ-5. БАЙШИНД АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, УСАН ХАНГАМЖИЙН ТӨРЛӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ТӨВЛӨРСӨН СИСТЕМ		БИЕ ДААСАН СИСТЕМ		Зөөврийн
		Халуун, хүйтэн устай	Зөвхөн хүйтэн устай	Халуун, хүйтэн устай	Зөвхөн хүйтэн устай	
БҮГД	451 638	239 577	18 631	3 406	2 750	187 274
Архангай	4 079	315	621	5	15	3 123
Баян-Өлгий	8 719	563	400	198	266	7 292
Баянхонгор	3 808	171	1 626	11	10	1 990
Булган	3 759	125	397	7	20	3 210
Говь-Алтай	1 985	155	1 249	15	21	545
Дорноговь	8 896	1 760	3 876	23	36	3 201
Дорнод	9 751	5 179	46	6	14	4 506
Дундговь	1 650	54	980	2	9	605
Завхан	2 658	147	629	8	12	1 862
Өвөрхангай	5 346	829	771	15	24	3 707
Өмнөговь	2 947	412	1 559	25	35	916
Сүхбаатар	3 508	1 514	668	6	4	1 316
Сэлэнгэ	8 556	1 668	995	26	201	5 666
Төв	3 001	1 308	467	6	8	1 212
Увс	2 684	1 201	183	20	34	1 246
Ховд	3 645	1 491	77	20	139	1 918
Хөвсгөл	9 553	230	634	33	9	8 647
Хэнтий	3 610	945	603	11	11	2 040
Дархан-Уул	20 276	12 757	367	14	276	6 862
Орхон	23 256	11 878	410	17	10	10 941
Говьсүмбэр	2 007	1 102	230	7	7	661
Улаанбаатар	317 944	195 773	1 843	2 931	1 589	115 808

### ХАВСРАЛТ-6. БАЙШИНД АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ				
		Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Шатаадаг	Булдаг	Тогтсон цэггүй
БҮГД	451 638	431 833	18 249	259	149	1 148
Архангай	4 079	3 960	95	0	2	22
Баян-Өлгий	8 719	6 497	1 948	8	86	180
Баянхонгор	3 808	3 769	35	0	0	4
Булган	3 759	3 381	226	7	3	142
Говь-Алтай	1 985	1 242	735	0	0	8
Дорноговь	8 896	7 189	1 666	4	14	23
Дорнод	9 751	9 608	113	28	0	2
Дундговь	1 650	1 242	408	0	0	0
Завхан	2 658	2 579	70	0	0	9
Өвөрхангай	5 346	5 282	53	0	2	9
Өмнөговь	2 947	2 725	209	0	0	13
Сүхбаатар	3 508	3 376	132	0	0	0
Сэлэнгэ	8 556	5 814	2 478	110	6	148
Төв	3 001	2 994	6	0	0	1
Увс	2 684	2 230	446	0	2	6
Ховд	3 645	2 382	1 212	1	0	50
Хөвсгөл	9 553	9 159	237	10	2	145
Хэнтий	3 610	2 916	676	14	1	3
Дархан-Уул	20 276	19 074	856	37	10	299
Орхон	23 256	23 171	63	6	4	12
Говьсүмбэр	2 007	1 723	282	1	0	1
Улаанбаатар	317 944	311 520	6 303	33	17	71





### ХАВСРАЛТ-7. БАЙШИНД АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТ				
		Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Шатаадаг	Булдаг	Тогтсон цэггүй
БҮГД	95 341	34 712	45 719	2 322	194	12 394
Архангай	3 682	1 199	1 872	107	4	500
Баян-Өлгий	14 539	741	6 148	451	47	7 152
Баянхонгор	1 567	1 049	352	22	5	139
Булган	5 011	726	3 459	141	9	676
Говь-Алтай	1 079	264	740	25	1	49
Дорноговь	2 687	1 529	918	103	7	130
Дорнод	4 997	2 074	2 759	101	7	56
Дундговь	1 376	678	569	16	0	113
Завхан	4 222	1 069	2 968	65	1	119
Өвөрхангай	4 652	3 019	1 334	23	12	264
Өмнөговь	2 449	1 639	626	38	14	132
Сүхбаатар	2 767	1 247	1 482	31	3	4
Сэлэнгэ	13 478	6 532	6 240	250	18	438
Төв	7 617	2 891	4 591	106	13	16
Увс	1 629	88	1 451	29	1	60
Ховд	2 634	382	1 814	104	9	325
Хөвсгөл	9 781	2 288	4 994	588	33	1 878
Хэнтий	5 086	2 842	2 136	104	2	2
Дархан-Уул	4 518	3 343	830	7	8	330
Орхон	556	366	172	7	0	11
Говьсүмбэр	1 014	746	264	4	0	0

### ХАВСРАЛТ-8. БАЙШИНД АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР			
		Төвлөрсөн систем	Бие даасан систем	Цооног	Задгай
БҮГД	451 638	255 467	4 538	186 603	5 030
Архангай	4 079	925	38	2 416	700
Баян-Өлгий	8 719	726	278	7 330	385
Баянхонгор	3 808	1 805	16	1 973	14
Булган	3 759	515	13	3 040	191
Говь-Алтай	1 985	1 361	71	537	16
Дорноговь	8 896	5 347	209	2 850	490
Дорнод	9 751	5 196	25	4 320	210
Дундговь	1 650	996	49	602	3
Завхан	2 658	758	27	1 848	25
Өвөрхангай	5 346	1 601	40	3 664	41
Өмнөговь	2 947	1 608	193	1 134	12
Сүхбаатар	3 508	2 125	17	1 366	0
Сэлэнгэ	8 556	2 146	272	5 848	290
Төв	3 001	1 731	29	1 230	11
Увс	2 684	1 406	72	1 022	184
Ховд	3 645	1 659	37	1 875	74
Хөвсгөл	9 553	882	49	8 357	265
Хэнтий	3 610	1 539	27	1 948	96
Дархан-Уул	20 276	13 306	144	5 862	964
Орхон	23 256	12 228	139	10 791	98
Говьсүмбэр	2 007	1 324	30	640	13
Улаанбаатар	317 944	196 283	2 763	117 950	948



### ХАВСРАЛТ-9. БАЙШИНД АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР			
		Төвлөрсөн систем	Бие даасан систем	Цооног	Задгай
БҮГД	95 341	9 877	1 097	66 355	18 012
Архангай	3 682	29	10	2 602	1 041
Баян-Өлгий	14 539	43	201	5 816	8 479
Баянхонгор	1 567	42	25	1 342	158
Булган	5 011	39	20	3 910	1 042
Говь-Алтай	1 079	23	5	982	69
Дорноговь	2 687	845	25	1 127	690
Дорнод	4 997	56	22	4 710	209
Дундговь	1 376	111	32	1 115	118
Завхан	4 222	49	13	3 924	236
Өвөрхангай	4 652	251	46	3 835	520
Өмнөговь	2 449	637	134	1 523	155
Сүхбаатар	2 767	187	19	2 518	43
Сэлэнгэ	13 478	2 621	310	9 443	1 104
Төв	7 617	357	109	6 934	217
Увс	1 629	11	11	1 411	196
Ховд	2 634	81	40	1 920	593
Хөвсгөл	9 781	64	17	7 188	2 512
Хэнтий	5 086	1 204	27	3 792	63
Дархан-Уул	4 518	2 235	16	1 726	541
Орхон	556	172	0	367	17
Говьсүмбэр	1 014	820	15	170	9

### ХАВСРАЛТ-10. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРЛӨӨР, 2020 ОН

Аймаг, нийслэл	ХОТ					ХӨДӨӨ				
	Бүгд	Сайжруулсан	Энгийн	Био жорлон	Задгай	Бүгд	Сайжруулсан	Энгийн	Био жорлон	Задгай
БҮГД	149 873	3 328	145 031	331	1 183	192 536	1 659	119 878	127	70 872
Архангай	1 612	12	1 572	10	18	17 455	70	12 224	10	5 151
Баян-Өлгий	121	0	120	0	1	619	15	448	1	155
Баянхонгор	5 400	34	5 250	4	112	14 616	84	5 210	22	9 300
Булган	619	8	584	4	23	8 660	57	6 876	3	1 724
Говь-Алтай	3 260	156	2 975	0	129	9 635	62	3 642	2	5 929
Дорноговь	2 365	9	2 319	0	37	5 670	50	4 914	2	704
Дорнод	2 046	141	1 893	6	6	9 045	74	6 375	6	2 590
Дундговь	1 856	6	1 827	1	22	11 715	153	6 625	4	4 933
Завхан	3 820	51	3 721	11	37	18 996	53	9 238	5	9 700
Өвөрхангай	5 217	58	5 137	6	16	10 289	338	8 440	11	1 500
Өмнөговь	1 648	8	1 600	0	40	9 747	9	4 253	1	5 484
Сүхбаатар	1 176	11	1 130	1	34	5 404	22	4 912	3	467
Сэлэнгэ	1 619	2	1 598	0	19	14 495	104	9 801	5	4 585
Төв	5 550	58	5 374	2	116	11 640	89	4 269	7	7 275
Увс	4 105	56	4 009	19	21	11 531	239	5 784	13	5 495
Ховд	3 011	40	2 947	3	21	14 951	88	13 444	5	1 414
Хөвсгөл	4 501	15	4 339	5	142	10 408	50	8 218	16	2 124
Хэнтий	2 863	12	2 842	5	4	912	15	850	0	47
Дархан-Уул	3 080	31	2 960	3	86	5 193	52	3 325	8	1 808
Орхон	3 874	22	3 837	1	14	573	0	254	0	319
Говьсүмбэр	881	16	857	4	4	982	35	776	3	168
Улаанбаатар	91 249	2 582	88 140	246	281					



### ХАВСРАЛТ-11. ГЭРТ АМЬДАРДАГ ХОТЫН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛДАГ ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН

	БҮГД	Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Шатаадаг	Булдаг	Тогтсон цэггүй
БҮГД	149 873	135 626	7 893	306	79	5 969
Архангай	1 612	1 397	38	2	1	174
Баян-Өлгий	121	69	41	0	1	10
Баянхонгор	5 400	5 069	55	16	1	259
Булган	619	325	53	12	0	229
Говь-Алтай	3 260	2 760	286	3	0	211
Дорноговь	2 365	2 080	46	19	0	220
Дорнод	2 046	1 719	322	2	0	3
Дундговь	1 856	1 747	49	0	0	60
Завхан	3 820	3 736	38	0	0	46
Өвөрхангай	5 217	5 021	87	5	0	104
Өмнөговь	1 648	1 426	173	4	2	43
Сүхбаатар	1 176	196	461	26	1	492
Сэлэнгэ	1 619	1 570	4	6	1	38
Төв	5 550	3 862	1 413	8	0	267
Увс	4 105	1 526	2 414	7	0	158
Ховд	3 011	2 256	119	9	10	617
Хөвсгөл	4 501	2 981	742	87	13	678
Хэнтий	2 863	2 230	184	15	1	433
Дархан-Уул	3 080	2 830	74	8	20	148
Орхон	3 874	3 839	17	8	3	7
Говьсүмбэр	881	809	31	8	0	33
Улаанбаатар	91 249	88 178	1 246	61	25	1 739

### ХАВСРАЛТ-12. ГЭРТ АМЬДАРДАГ ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	БҮГД	Үйлчилгээний байгууллагаар	Зөвшөөрөгдсөн цэгт	Шатаадаг	Булдаг	Тогтсон цэггүй
БҮГД	192 536	20 018	44 668	10 899	1 241	115 710
Архангай	17 455	556	2 231	1 242	120	13 306
Баян-Өлгий	619	9	160	38	0	412
Баянхонгор	14 616	2 151	1 078	649	111	10 627
Булган	8 660	336	2 549	406	39	5 330
Говь-Алтай	9 635	701	2 384	404	46	6 100
Дорноговь	5 670	479	1 301	198	48	3 644
Дорнод	9 045	1 425	2 031	577	62	4 950
Дундговь	11 715	586	4 247	669	101	6 112
Завхан	18 996	3 090	3 140	431	113	12 222
Өвөрхангай	10 289	3 487	2 193	450	49	4 110
Өмнөговь	9 747	1 213	1 704	299	78	6 453
Сүхбаатар	5 404	867	2 243	206	25	2 063
Сэлэнгэ	14 495	1 318	5 385	557	41	7 194
Төв	11 640	130	3 344	617	50	7 499
Увс	11 531	413	3 350	615	86	7 067
Ховд	14 951	505	3 553	1 825	112	8 956
Хөвсгөл	10 408	1 494	2 709	636	55	5 514
Хэнтий	912	188	172	20	4	528
Дархан-Уул	5 193	779	670	957	96	2 691
Орхон	573	129	98	37	1	308
Говьсүмбэр	982	162	126	66	4	624



**ХАВСРАЛТ-13. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ХӨДӨӨ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН**

Аймаг, нийслэл	ХОТ			ХӨДӨӨ		
	БҮГД	Цооног	Задгай	Бүгд	Цооног	Задгай
БҮГД	149 873	127 747	22 126	192 536	56 126	136 410
Архангай	1 612	1 058	554	17 455	1 988	15 467
Баян-Өлгий	121	108	13	619	203	416
Баянхонгор	5 400	5 060	340	14 616	3 372	11 244
Булган	619	363	256	8 660	2 079	6 581
Говь-Алтай	3 260	2 998	262	9 635	2 949	6 686
Дорноговь	2 365	1 329	1 036	5 670	1 154	4 516
Дорнод	2 046	2 003	43	9 045	3 648	5 397
Дундговь	1 856	1 758	98	11 715	4 565	7 150
Завхан	3 820	3 694	126	18 996	5 091	13 905
Өвөрхангай	5 217	5 089	128	10 289	5 986	4 303
Өмнөговь	1 648	1 589	59	9 747	2 270	7 477
Сүхбаатар	1 176	447	729	5 404	2 037	3 367
Сэлэнгэ	1 619	1 298	321	14 495	4 392	10 103
Төв	5 550	3 763	1 787	11 640	2 958	8 682
Увс	4 105	3 794	311	11 531	3 477	8 054
Ховд	3 011	2 452	559	14 951	4 720	10 231
Хөвсгөл	4 501	3 232	1 269	10 408	3 307	7 101
Хэнтий	2 863	1 950	913	912	256	656
Дархан-Уул	3 080	2 251	829	5 193	1 103	4 090
Орхон	3 874	3 784	90	573	225	348
Говьсүмбэр	881	823	58	982	346	636
Улаанбаатар	91 249	78 904	12 345	0	0	0